СЗХ
2018 он 08 сар 29 өдөр
БҮРТГЭВ
№ 01

0000001
БҮРТГЭВ 01
он .... сар .... өдөр

ДААТГАЛ
SINCE 1994

# АРД ДААТГАЛ ХХК

# ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

Хүчтэй. Хамтдаа

2018 он

# ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН АНХААРАЛД!

Энэхүү Үнэт цаасны танилцуулга нь Хөрөнгө оруулагч таны хараат бус үнэлгээ гаргах, шинжилгээ хийхийг орлохгүй бөгөөд тэдгээрт тооцогдохгүй. Хөрөнгө оруулагч та Үнэт цаас гаргагч болоод түүний гаргаж буй үнэт цаас, холбогдох мэдээллийн талаар өөрийн хөндлөнгийн судалгаа шинжилгээг хийсний үндсэн дээр хөрөнгө оруулалт хийж буй бөгөөд өөрийн мэргэжлийн санхүүгийн, хуулийн болон бусад зохих мэргэжлийн зөвлөхүүдтэйгээ зөвлөлдөхийг зөвлөж байна.

"ҮНЭТ ЦААСЫГ МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ БҮРТГЭСЭН НЬ УГ ҮНЭТ ЦААСНЫ ЭРСДЛИЙН ТАЛААР АЛИВАА БАТАЛГАА ГАРГААГҮЙ БОЛОХЫГ АНХААРАХ НЬ ЗҮЙТЭЙ. ЭНЭХҮҮ ҮНЭТ ЦААСЫГ ХУДАЛДАН АВАХ ЗАМААР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ХИЙХ НЬ ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ ТАНЫ ХУВЬД ***ЯМАГТ ЭРСДЭЛТЭЙ*** ҮЙЛДЭЛ БАЙДГИЙГ ОНЦГОЙЛОН АНХААРЧ, ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА, ҮНЭТ ЦААС ГАРГАХ АЖИЛЛАГААГ САЙТАР АНХААРАН СУДАЛСНЫ ҮНДСЭН ДЭЭР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ШИЙДВЭРЭЭ ГАРГАХЫГ ЗӨВЛӨЖ БАЙНА"

СЭХ
2018.00.29
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
0000003
БҮРТГЭВ 01

# ҮНЭТ ЦААСНЫ ХУРААНГУЙ ТАНИЛЦУУЛГА

**Энэхүү үнэт цаасны танилцуулгыг Компанийн тухай хууль, Монголын Хөрөнгийн Биржийн "Үнэт цаасны бүртгэлийн журам", Санхүүгийн Зохицуулах Хорооны "Үнэт цаасны бүртгэлийн журам" болон Ард Даатгал ХХК-ийн 2018 оны 04 сарын 20-ны өдрийн Хувьцаа Эзэмшигчдийн хурлын 07/18 тоот тогтоолыг үндэслэн бэлтгэлээ.**

| | |
|---|---|
| Үнэт цаас гаргагч | Ард Даатгал ХХК |
| Компанийн товч танилцуулга | Ард Даатгал ХХК (цаашид "Үнэт цаас гаргагч" гэх) нь 1994 оны 03 сарын 14-ны өдөр Монголын анхны хувийн даатгалын компани болж үүсэн байгуулагдаж, 24 жилийн турш тасралтгүй тогтвортой үйл ажиллагаа явуулсаар ирсэн. Өнөөдрийн байдлаар 24 салбар, 238 төлөөлөгч, 100 гаруй ажиллагсадтайгаар даатгалын салбарт үйл ажиллагаагаа явуулж байна. Үнэт цаас гаргагч нь харилцагч, үйлчлүүлэгчиддээ 13 хэлбэрийн даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээг санал болгон ажилладаг. Мөн Үнэт цаас гаргагч нь дэлхийн тэргүүлэх давхар даатгалын Hannover Re, Munich RE зэрэг 20 гаруй компаниуд болон Монгол улсын давхар даатгагч Хөдөө аж ахуйн давхар даатгалтай хамтран ажилладаг. |
| Бүртгүүлэх ангилал | МХБ-ийн Хувьцааны Бүртгэлийн I ангилал |
| Санал болгож буй хувьцааны нэгж үнэ | 700 төгрөг /долоон зуун төгрөг/ |
| Санал болгож буй хувьцааны тоо ширхэг | 7,500,000 ширхэг энгийн хувьцаа |
| Нийт татан төвлөрүүлэх дүн | 5,250,000,000 төгрөг /таван тэрбум хоёр зуун тавин сая төгрөг/ |
| Олон нийтэд санал болгож буй хувь | 30% |
| Татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалт | - Дүрмийн сан болон өөрийн хөрөнгө нэмэгдүүлэх |
| Үнэт цаас арилжих арга | Тогтоосон үнийн арга |

2018-05-11

ARD INSURANCE COMPANY
АРД ДААТГАЛ ХХК
УЛААНБААТАР ХОТ

УЛААНБААТАР ХОТ
МХБ-ийн гишүүн Андеррайтер Брокер, дилерийн "БИДИСЕК" ҮЦК ХК

# АГУУЛГА


НЭГ. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТУХАЙ ....................................................................13

1.1. Үнэт цаас гаргагчийн оноосон нэр, оршин байгаа хаяг, холбоо барих утас ...........13

1.2. Үнэт цаас гаргагчийн хуулийн этгээдийн улсын бүртгэл ...........................................13

1.3. Үнэт цаас гаргагчийн танилцуулга ..............................................................................13

1.3.1. Компанийн үнэт зүйлс ...........................................................................................14

1.3.2. Мөрддөг зарчим ......................................................................................................14

1.3.3. Түүхэн замнал ..........................................................................................................16

1.3.4. Нийгмийн хариуцлага .............................................................................................17

1.4. Үнэт цаас гаргагчийн эрхэлж буй үйл ажиллагаа .......................................................21

1.4.1. Даатгалын үйлчилгээний процесс .........................................................................22

1.4.2. Бүтээгдэхүүн, үйлчилгээ .........................................................................................23

1.4.3. Группын хамтын ажиллагаа ...................................................................................28

1.4.4. Борлуулалт ................................................................................................................28

1.4.5. Даатгалын хэлбэрүүд ...............................................................................................32

1.4.6. Даатгуулагчдын тоо .................................................................................................34

1.4.7. Компанийн салбарын үзүүлэлт ...............................................................................35

1.4.8. Нөхөн төлбөр ............................................................................................................36

1.4.9. Хохирлын харьцаа ....................................................................................................38

1.4.10. Давхар даатгал .......................................................................................................38

1.4.11. Нөөц сан ..................................................................................................................41

1.5. Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа явуулдаг зах зээлийн талаарх мэдээлэл .....41

1.6. Үнэт цаас гаргагчийн хувь нийлүүлсэн хөрөнгө ........................................................49

1.7. Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчид ..................................................................51

1.8. Үнэт цаас гаргагчийн бүтэц зохион байгуулалт, эрх бүхий албан тушаалтны мэдээлэл ........................................................................................................................54

1.9. Үнэт цаас гаргагчийн санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт .......................................64

1.10. Үнэт цаас гаргагчийн хийсэн гэрээ, хэлцлийн талаар ...............................................74

1.11. Компанийн холбогдох этгээдийн тухай ........................................................................77

1.12. Үнэт цаас гаргагчийн компанийн засаглалын журмуудыг боловсруулж баталсан тухай 81

1.13. Компанийн тухай хуулийн 75,79,81 дүгээр зүйлүүдийг дагаж мөрдөх талаар ......81

1.14. Компанийн эрх бүхий байгууллагаар батлуулсан ногдол ашгийн бодлого ..........82

СЗХ
2018 .08. 29 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ 01
....... он .... сар .... өдөр
0000000005



1.15. Дунд хугацааны бизнес төлөвлөгөөний тойм ........ 84
1.15.1. ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ ........ 84
1.15.2. КОМПАНИЙН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ ........ 89
1.15.3. БИЗНЕСИЙН ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ ........ 90
1.15.4. ТӨЛӨВЛӨЛТ ........ 101
1.16. Компанийн үйл ажиллагаанд учирч болох эрсдэл, эрсдэлийн удирдлагын төлөвлөгөө ........ 117
ХОЁР. ҮНЭТ ЦААСНЫ ТУХАЙ ........ 120
2.1. Үнэт цаас гаргах тухай эрх бүхий этгээдээс гаргасан шийдвэр ........ 120
2.2. Нийтэд санал болгох үнэ тогтоосон үндэслэл, шийдвэр ........ 121
2.3. Нийтэд санал болгох үнэт цаасны төрөл тоо, хэлбэр, нэрлэсэн үнэ ........ 122
2.4. Нийтэд санал болгох болон арилжих нөхцөл ........ 123
2.5 Нийтэд санал болгож байгаа үнэт цаасаар гэрчлэгдэх эрх, үүрэг ........ 125
2.6. Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт ........ 126
ГУРАВ. ҮНЭТ ЦААС ГАРГАХ АЖИЛЛАГААНД ОРОЛЦСОН ЭТГЭЭДИЙН ТУХАЙ ........ 129
3.1. Аудитын компанийн танилцуулга, тусгай зөвшөөрөл ........ 129
3.2. Аудитын компанитай байгуулсан гэрээгээр хүлээсэн эрх, үүргийн тухай ........ 131
3.3. Үнэлгээний компанийн танилцуулга, тусгай зөвшөөрөл ........ 133
3.4. Үнэлгээний компанитай хийсэн гэрээгээр хүлээсэн эрх үүрэг ........ 135
3.5. Хөрөнгө болон бизнесийн үнэлгээний тайлан, дүгнэлт ........ 137
3.6. Хуулийн компанийн танилцуулга, тусгай зөвшөөрөл ........ 140
3.7. Хуулийн компанитай хийсэн гэрээний тухай ........ 142
3.8. Хуулийн дүгнэлт ........ 142
3.9. Андеррайтер компанийн танилцуулга, тусгай зөвшөөрөл ........ 146
3.10. Андеррайтер компанийн хийсэн гэрээгээр хүлээсэн эрх, үүрэг ........ 147

## График

График 1. Борлуулалтын орлогын бүтэц ........ 29
График 2. Нийт хөрөнгө /сая.төг/ ........ 30
График 3. Нийт хураамжийн орлого /сая.төг/ ........ 30
График 4. Нөхөн төлбөр /сая.төг/ ........ 31
График 5. Цэвэр ашиг /сая.төг/ ........ 31
График 6. Хөрөнгө оруулалт болон хөрөнгө оруулалтын олз /сая.төг/ ........ 31
График 7. Үйл ажиллагааны зардал /сая.төг/ ........ 32
График 8. Эх үүсвэрийн бүтэц /сая.төг/ ........ 32

ARD INSURANCE COMPANY
АРД ДААТГАЛ ХХК
УЛААНБААТАР ХОТ

УЛААНБААТАР ХОТ
МХБ-ийн гишүүн Андеррайтер Брокер, дилерийн "БИДИСЕК" ҮЦК ХК
1115205447 2058182

График 9. Орон нутгийн салбарын үзүүлэлт /сая.төг/ .......... 36
График 10. Нөхөн төлбөрийн хэмжээ /сая.төг/ .......... 37
График 11. Нөхөн төлбөрийн бүтэц .......... 37
График 12. Давхар даатгагчаас төлсөн нөхөн төлбөр .......... 37
График 13. Хохирлын харьцаа /нийт/ .......... 38
График 14. Хохирлын харьцаа /цэвэр/ .......... 38
График 15. Давхар даатгалын хураамжийн зардал /сая.төг/ .......... 40
График 16. Давхар даатгалын хураамжийн зардалын бүтэц .......... 40
График 17. Давхар даатгалын үзүүлэлт .......... 40
График 18. Нөөц сангийн бүтэц .......... 41
График 19. Нийт хөрөнгөөр зах зээлд эзлэх байр суурь /сая.төг/ .......... 42
График 20. Нийт хураамжийн орлогоор зах зээлд эзлэх байр суурь /сая.төг/ .......... 42
График 21. Цэвэр ашгийн хэмжээгээр зах зээлд эзлэх байр суурь /сая.төг/ .......... 43
График 22. Нийт хөрөнгийн өсөлтийн хувь /2013-2017/ .......... 43
График 23. Хураамжийн орлогын өсөлтийн хувь /2013-2017/ .......... 43
График 24. Цэвэр ашгийн өсөлт өсөлтийн хувь /2013-2017/ .......... 44
График 25. Үнэт цаас гаргагчийн зах зээлд эзлэх хувь .......... 44
График 26. Салбарын нийт хураамжийн орлогын бүтэц .......... 45
График 27. Салбарын нийт нөхөн төлбөрийн бүтэц .......... 45
График 28. Даатгалын салбарын нийт нөөц сан .......... 45
График 29. Даатгалын салбарын хураамжийн орлого төвлөрүүлэлт .......... 46
График 30. Даатгалын салбарын нийт хөрөнгө /тэрбум төг/ .......... 84
График 31. Даатгалын салбарын нийт хураамжийн орлого, давхар даатгалын хураамж .......... 85
График 32. Даатгалын салбарын нөхөн төлбөр /тэрбум.төг/ .......... 86
График 33. Даатгалын салбарын цэвэр ашиг /тэрбум.төг/ .......... 87
График 34. Даатгалын салбарын хураамжийн орлого, нөхөн төлбөр, хохирол нөхөлтийн харьцаа .......... 88
График 35. Ард Даатгал ХХК-ийн хөрөнгийн бүтэц /сая.төг/ .......... 89
График 36. Ард Даатгал ХХК-ийн эх үүсвэрийн бүтэц /сая.төг/ .......... 89
График 37. Ард Даатгал ХХК-ийн хураамж, нөхөн төлбөр /сая.төг/ .......... 89
График 38. Инфляци /хувь/ .......... 91
График 39. Үнэт цаас гаргагчийн хөрөнгө оруулалтын мэдээлэл /сая.төг/ .......... 128

## Схем

Схем 1. Үнэт цаас гаргагчийн түүхэн замнал .......... 16
Схем 2. Даатгалын үйлчилгээний процесс .......... 22
Схем 3. Компанийн үзүүлдэг бүтээгдэхүүн үйлчилгээ .......... 23
Схем 4. АСН-ийн хөрөнгө оруулсан компаниуд .......... 53
Схем 5. Ард Даатгал ХХК-ийн бүтэц зохион байгуулалт .......... 54
Схем 6. Ард Даатгал ХХК-ийн 2015 оны ROE харьцаа .......... 73
Схем 7. Ард Даатгал ХХК-ийн 2016 оны ROE харьцаа .......... 73
Схем 8. Ард Даатгал ХХК-ийн 2017 оны ROE харьцаа .......... 73
Схем 9. Өрхийн орлого .......... 93

СЭХ 2018.08.29 өдөр БҮРТГЭВ № 01
0000006
MONGOLIAN STOCK EXCHANGE БҮРТГЭВ 01
2018 05-11
АРД ДААТГАЛ ХХК УЛААНБААТАР ХОТ
УЛААНБААТАР ХОТ МХБ-ийн гишүүн Андеррайтер Брокер, дилерийн БИДИСЕК ҮЦК ХХК

СЗХ
2018.08.29
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
0000006007
БҮРТГЭВ 01
...... он .... сар .... өдөр

Схем 10. Хувьцаа худалдан авах заавар ........ 124

## Хүснэгт

Хүснэгт 1. Даатгуулагчдын тоо ........ 34
Хүснэгт 2. Даатгасан зүйлийн тоо ........ 35
Хүснэгт 3. Давхар даатгагч компанийн үзүүлэлт ........ 39
Хүснэгт 4. Салбарын харьцаа үзүүлэлт ........ 46
Хүснэгт 5. Ард Даатгал ХХК-ийн харьцаа үзүүлэлт ........ 46
Хүснэгт 6. Салбарын болон Ард Даатгал ХХК-ийн харьцаа ........ 48
Хүснэгт 7. Хувь нийлүүлсэн хөрөнгийн өөрчлөлт ........ 50
Хүснэгт 8. Ард Даатгал ХХК-ийн хувьцаа эзэмшигчид ........ 51
Хүснэгт 9. Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн хувьцаа эзэмшигчид ........ 53
Хүснэгт 10. АСН-ийн ТУЗ-ийн гишүүд ........ 54
Хүснэгт 11. Ард Даатгал ХХК-ийн ТУЗ-ийн гишүүд ........ 55
Хүснэгт 12. Ард Даатгал ХХК-ийн аудитын хорооны гишүүд ........ 60
Хүснэгт 13. Ард Даатгал ХХК-ийн засаглалын хорооны гишүүд ........ 61
Хүснэгт 14. Ард Даатгал ХХК-ийн эрсдэл хөрөнгө оруулалтын хорооны гишүүд ........ 61
Хүснэгт 15. Ард Даатгал ХХК-ийн эрх бүхий албан тушаалтнууд ........ 62
Хүснэгт 16. Ард Даатгал ХХК-ийн санхүүгийн байдлын тайлан ........ 65
Хүснэгт 17. Ард Даатгал ХХК-ийн орлого үр дүнгийн тайлан ........ 67
Хүснэгт 18. Ард Даатгал ХХК-ийн өмчийн өөрчлөлтийн тайлан ........ 68
Хүснэгт 19. Ард Даатгал ХХК-ийн мөнгөн гүйлгээний тайлан ........ 68
Хүснэгт 20. Ард Даатгал ХХК-ийн авлагын задаргаа ........ 70
Хүснэгт 21. Ард Даатгал ХХК-ийн өр төлбөрийн задаргаа ........ 71
Хүснэгт 22. Ард Даатгал ХХК-ийн санхүүгийн харьцаа ........ 72
Хүснэгт 23. Ард Даатгал ХХК-ийн ХНХ-ийн 5%-иас дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий гэрээ хэлцэл ........ 74
Хүснэгт 24. Сүүлийн 3 жилд хийгдсэн их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл ........ 76
Хүснэгт 25. Даатгалын салбарын хураамжийн орлогын бүтэц ........ 85
Хүснэгт 26. Ердийн даатгалын компаниудын хураамжийн орлого ........ 86
Хүснэгт 27. Ердийн даатгалын компаниудын нөхөн төлбөр ........ 87
Хүснэгт 28. Хүн ам, хувийн эмнэлгийн мэдээлэл ........ 92
Хүснэгт 29. Барилгын салбарын мэдээлэл ........ 92
Хүснэгт 30. Боловсролын салбар ........ 93
Хүснэгт 31. Өрхийн орлого ........ 93
Хүснэгт 32. Ердийн даатгалын компаниудын давхар даатгалын хураамж ........ 96
Хүснэгт 33. Ердийн даатгалын компаниудын нийт хөрөнгө ........ 97
Хүснэгт 34. Даатгалын компаниудын хэрэглэдэг програм хангамж ........ 98
Хүснэгт 35. Ердийн даатгалын компаниудын нөхөн төлбөр ........ 98
Хүснэгт 36. Ердийн даатгалын зах зээлийн мэдээлэл ........ 99
Хүснэгт 37. Даатгалын салбарын нийт хураамж, давхар даатгал, цэвэр хураамжийн орлого /сая.төг/ ........ 99
Хүснэгт 38. Даатгалын салбарын хураамжийн орлого /сая.төг/ ........ 100

ARD INSURANCE COMPANY
АРД ДААТГАЛ ХХК
ТТН 2062089
УЛААНБААТАР ХОТ
УЛААНБААТАР ХОТ
МХБ-ийн гишүүн Андеррайтер Брокер, дилерийн "БИДСЕК" ҮЦК ХК
1115205447 2062482

Хүснэгт 39. SWOT TOWS Шинжилгээ....101
Хүснэгт 40. SWOT Шинжилгээ....102
Хүснэгт 41. Хөрөнгийн даатгалд голлох оролцоотой даатгалын компаниуд....103
Хүснэгт 42. Эрүүл мэндийн даатгалд голлох оролцоотой даатгалын компаниуд....104
Хүснэгт 43. Жолоочийн даатгалд голлох оролцоотой даатгалын компаниуд....104
Хүснэгт 44. Хариуцлагын даатгалд голлох оролцоотой даатгалын компаниуд....105
Хүснэгт 45. Ард Даатгал ХХК"-ийн хэрэгжүүлэхээр төлөвлөж буй төслүүд....105
Хүснэгт 46. Борлуулалтын суваг, төлөвлөгөө....107
Хүснэгт 47. Орон тооны төлөвлөлт....109
Хүснэгт 48. Зах зээлийн таамаглал (Дэлхийн банкны таамаглалд үндэслэсэн болно)....109
Хүснэгт 49. Хураамжийн орлогын таамаглал /сая.төг/....110
Хүснэгт 50. Нөхөн төлбөрийн таамаглал /сая.төг/....111
Хүснэгт 51. Үйл ажиллагааны зардлын төлөвлөлт /сая.төг/....111
Хүснэгт 52. Үйл ажиллагааны зардал, хураамжийн орлогын өсөлтийн хувь....112
Хүснэгт 53. Орлого үр дүнгийн тайлангийн төлөвлөлт /сая.төг/....112
Хүснэгт 54. Хөрөнгө оруулалт хийх хязгаар /СЗХ-ны журмын дагуу/....113
Хүснэгт 55. Хөрөнгө оруулалтын төлөвлөлт /сая.төг/....114
Хүснэгт 56. Даатгалын харьцаа үзүүлэлтийн төлөвлөлт....114
Хүснэгт 57. Санхүүгийн байдлын тайлангийн төлөвлөлт /сая.төг/....115
Хүснэгт 58. Мөнгөн гүйлгээний тайлангийн төлөвлөлт /сая.төг/....116
Хүснэгт 59. Эрсдэл, эрсдэлийн удирдлагын төлөвлөгөө....117
Хүснэгт 60. IPO дараах хувьцаа эзэмшигчдийн бүтэц....122
Хүснэгт 61. IPO дараах хувь нийлүүлсэн хөрөнгө....123
Хүснэгт 62. Үнэт цаас гаргагчийн дүрмийн сангийн бүтэц....127
Хүснэгт 63. Хөрөнгө оруулалтын төлөвлөлт /сая.төг/....128
Хүснэгт 64. Үйл ажиллагааны үзүүлэлтийн төлөвлөлт....129
Хүснэгт 65. Аудитын компанитай байгуудсан гэрээгээр хүлээсэн эрх, үүрэг....131
Хүснэгт 66. Үнэлгээчдийн тусгай зөвшөөрөл....134
Хүснэгт 67. Үнэлгээний компанитай хийсэн гэрээгээр хүлээсэн эрх, үүрэг....135
Хүснэгт 68. Бизнес үнэлгээний аргуудын харьцуулалт....138
Хүснэгт 69. Үнэ цэнийн тооцоолол 23%-иар....138
Хүснэгт 70. Үнэ цэнийн тооцоолол 24%-иар....139
Хүснэгт 71. Хөрөнгийн үнэлгээний үр дүнгийн нэгтгэл....139
Хүснэгт 72. Өмгөөллийн ИЭлСи ХХН-ийн тусгай зөвшөөрөл....141
Хүснэгт 73. Өмгөөллийн ИЭлСи ХХН-ийн хуульчдын тусгай зөвшөөрөл....141

## Зураг

Зураг 1. Гадаад худалдааны тэнцэл....91
Зураг 2. Интернет хэрэглэгчдийн тоо /мянган хэрэглэгч/....94
Зураг 3. Үүрэн холбооны идэвхтэй хэрэглэгчдийн тоо /мянган хэрэглэгч/....94
*Зураг 4. Үнэт цаасыг анхдагч зах зээлд байршуулах явц*....123

СЗХ 2018.08.29 ..... БҮРТГЭВ № 01

0000 09

| Хавсралт материалын жагсаалт | |
|---|---|
| Хавсралт 1 | Ард Даатгал ХХК-ийн улсын бүртгэлийн гэрчилгээ, дүрэм, ХЭХ-ын хувьцаа хуваах тухай 04/18 тоот тогтоол |
| Хавсралт 2 | Ард Даатгал ХХК-ийн тусгай зөвшөөрлийн гэрчилгээ |
| Хавсралт 3 | ХЭХ-ын хувьцаа хуваах тухай 2018 оны 04 сарын 20-ны өдрийн 04/18 тоот тогтоол |
| Хавсралт 4 | Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн улсын бүртгэлийн гэрчилгээ, дүрэм |
| Хавсралт 5 | АСН-ийн холбоотой этгээдүүдийн улсын бүртгэлийн гэрчилгээ, дүрэм |
| Хавсралт 6 | Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн ҮЦТХТ ХХК дахь дансны үлдэгдэл |
| Хавсралт 7 | АСН нь Ард Актив ХЗХ-нд хувь нийлүүлсэн тухай мэдээлэл |
| Хавсралт 8 | Ард Даатгал ХХК-ийн ХК-ийн дүрмийн төсөл |
| Хавсралт 9 | Ард Даатгал ХХК-ийн бүтэц зохион байгуулалт, тогтоолын хамт |
| Хавсралт 10 | Ард Даатгал ХХК-ийн ТУЗ-ийн гишүүдийн анкетууд |
| Хавсралт 11 | Ард Даатгал ХХК-ийн ТУЗ-ийн гишүүдийн засаглалын гэрчилгээ |
| Хавсралт 12 | Ард Даатгал ХХК-ийн ТУЗ-ийн гишүүд томилох тухай тогтоолууд |
| Хавсралт 13 | Ард Даатгал ХХК болон түүний хяналтын багц эзэмшигчийн өр төлбөрийн лавлагаа |
| Хавсралт 14 | Ард Даатгал ХХК-ийн ТУЗ-ийн гишүүд, гүйцэтгэх захирлын холбогдох өр төлбөргүй тухай лавлагаа |
| Хавсралт 15 | ТУЗ бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай ХЭХ-ын 05/18 тогтоол |
| Хавсралт 16 | Шинээр ТУЗ-ийн 4 гишүүдийг томилох тухай ХЭХ-ын 03/18 тогтоол |
| Хавсралт 17 | ТУЗ дэргэдэх хороодын бүрэлдэхүүнийг томилох ТУЗ-ийн 15/14 тогтоол |
| Хавсралт 18 | Ард Даатгал ХХК-ийн эрх бүхий албан тушаалтнуудын анкет |
| Хавсралт 19 | Ард Даатгал ХХК-ийн эрх бүхий албан тушаалтнууд томилох тухай тогтоолууд |
| Хавсралт 20 | Ард Даатгал ХХК-ийн Гүйцэтгэх захирал болон ТУЗ-ийн даргын хооронд байгуулсан гэрээ |
| Хавсралт 21 | Үнэт цаас гаргагчийн сүүлийн 3 жилийн аудитын тайлан |
| Хавсралт 22 | Компанийн засаглалын журмуудыг баталсан тухай ТУЗ-ийн тогтоол, компанийн засаглалын журмууд |
| Хавсралт 23 | ХЭХ-ын нээлттэй ХК болох тухай 2018 оны 04 сарын 20-ны өдрийн 07/18 тоот тогтоол |
| Хавсралт 24 | ТУЗ-ийн хурлын эчнээ санал хураах тухай 2018 оны 05 сарын 04-ны 6/2018 тоот тогтоол |
| Хавсралт 25 | ТУЗ-ийн хурлын үнэт цаасны үнэ тогтоох тухай 2018 оны 05 сарын 08-ны өдрийн 07/18 тоот тогтоол |
| Хавсралт 26 | "Далайван Аудит" ХХК-ийн улсын бүртгэлийн гэрчилгээ, тусгай зөвшөөрөл, ҮЦЗЗ-д аудитын үйлчилгээ үзүүлэх зөвшөөрөл |

СЗХ 2018.08.29 өдөр БҮРТГЭВ № 01

| | |
|---|---|
| Хавсралт 27 | "Далайван Аудит" ХХК-ийн үнэт цаас гаргагчтай байгуулсан гэрээ |
| Хавсралт 28 | "БДО Аудит" ХХК-ийн тусгай зөвшөөрөл, бүртгэлийн гэрчилгээ, үнэлгээчдийн анкет |
| Хавсралт 29 | "БДО Аудит" ХХК-ийн үнэт цаас гаргагчтай байгуулсан гэрээ |
| Хавсралт 30 | "БДО Аудит" ХХК-ийн хөрөнгийн үнэлгээ |
| Хавсралт 31 | "БДО Аудит" ХХК-ийн бизнесийн үнэлгээ |
| Хавсралт 32 | "БДО Аудит" ХХК-ийн ҮЦЗЗ-д оролцогчид үйлчилгээ үзүүлэх зөвшөөрөл |
| Хавсралт 33 | "Өмгөөллийн И Эл Си" ХХН-ийн улсын бүртгэлийн гэрчилгээ, тусгай зөвшөөрөл |
| Хавсралт 34 | "Өмгөөллийн ИЭлСи" ХХН-ийн үнэт цаас гаргагчтай байгуулсан гэрээ |
| Хавсралт 35 | "Өмгөөллийн ИЭлСи" ХХН-ийн ҮЦЗЗ-д оролцогчид үйлчилгээ үзүүлэх зөвшөөрөл |
| Хавсралт 36 | "Өмгөөллийн ИЭлСи" ХХН-ийн хууль зүйн дүгнэлт |
| Хавсралт 37 | "Би Ди Сек" ХК-ийн улсын бүртгэлийн гэрчилгээ, тусгай зөвшөөрөл |
| Хавсралт 38 | "БиДиСЕК ҮЦК" ХК-ийн үнэт цаас гаргагчтай байгуулсан гэрээ |
| Хавсралт 39 | Андеррайтерийн дүгнэлт |

СЗХ 2018.08.29 БҮРТГЭВ № 01

# ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

| | |
|---|---|
| СЗХ | Санхүүгийн зохицуулах хороо |
| ТУЗ | Төлөөлөн удирдах зөвлөл |
| ҮЦЗЗ | Үнэт цаасны зах зээл |
| ҮЦЗЗТХ | Үнэт цаасны зах зээлийн тухай хууль |
| ЭСЯ | Элчин сайдын яам |
| КТХ | Компанийн тухай хууль |
| ХААДД | Хөдөө Аж Ахуйн Давхар Даатгал |
| МИД | Малын индексжүүлсэн даатгал |
| ББСБ | Банк бус санхүүгийн байгууллага |
| ХЗХ | Хадгаламж зээлийн хоршоо |
| ТББ | Төрийн бус байгууллага |
| ХНС | Хохирлын нөөц сан |
| СТОУС | Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт |
| АСН | Ард Санхүүгийн Нэгдэл |
| ТӨХК | Төрийн өмчит хувьцаат компани |
| ҮЦК | Үнэт цаасны компани |
| ШШГЕГ | Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар |
| МХБ | Монголын хөрөнгийн бирж |
| ДХО | Даатгалын хураамжийн орлого |
| НТ | Нөхөн төлбөр |
| ХЭХ | Хувьцаа эзэмшигчдийн хурал |

СЗХ 2018.08.29 өдөр БҮРТГЭВ № 01

МОНГОЛИЯ 0000012 БҮРТГЭВ 01

## ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА БЭЛТГЭХЭД ОРОЛЦСОН БАЙГУУЛЛАГУУД

### ХУУЛИЙН ЗӨВЛӨХ БАЙГУУЛЛАГА:

ELC LLP ADVOCATES
ӨМГӨӨЛЛИЙН "ИЭлСи" ХХН

| | |
|---|---|
| Нэр: | **Өмгөөллийн ИЭлСи ХХН** |
| Хаяг: | Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 1-р Хороо, Ардчиллын өргөө, 6 давхар |
| Утас: | (976) 77118193 |
| Вебсайт: | www.elclawoffice.mn |

### ҮНЭЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГА:

BDO

| | |
|---|---|
| Нэр: | **БДО Аудит ХХК** |
| Хаяг: | Улаанбаатар хот, СБД, 1-р хороо, ЮНЕСКО-гнийн гудамж, Нарны зам-62, ЮНИОН БЮЛДИНГ В-блок 15-р давхар, 1502 тоот |
| Утас: | (976) 77404040, (976) 77404041 |
| Вебсайт: | www.bdo.mn |

### АУДИТЫН БАЙГУУЛЛАГА:

ДАЛАЙВАН АУДИТ

| | |
|---|---|
| Нэр: | **Далайван Аудит ХХК** |
| Хаяг: | Монгол Улс, Улаанбаатар-16066, Амарсанаагийн гудамж-5, Далайван ХХК-ийн байр |
| Утас: | (976) 70005401 |
| Вебсайт: | www.dalaivanaudit.mn |

### АНДЕРРАЙТЕР КОМПАНИ:

sec

| | |
|---|---|
| Нэр: | **БиДиСЕК ҮЦК ХХК** |
| Хаяг: | БиДиСЕК ҮЦК ХК-ийн байр, Залуучуудын өргөн чөлөө 27/1, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, Монгол улс |
| Утас: | (976) 11 313108 |
| Вебсайт: | www.bdsec.mn |

ARD INSURANCE COMPANY АРД ДААТГАЛ ХХК УЛААНБААТАР ХОТ

УЛААНБААТАР ХОТ МХБ-ийн гишүүн Андеррайтер Брокер, дилерийн "БиДиСЕК" ҮЦК ХК 5205447

СЗХ
он 2018 сар 08 . 29 өдөр
БҮРТГЭВ
№ 01

ARD ДААТГАЛ SINCE 1994

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIA
0000013
БҮРТГЭВ



# НЭГ. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТУХАЙ

## 1.1. Үнэт цаас гаргагчийн оноосон нэр, оршин байгаа хаяг, холбоо барих утас

| | |
|---|---|
| Үнэт цаас гаргагчийн нэр: | Ард Даатгал ХХК |
| Үнэт цаас гаргагчийн хаяг: | Монгол улс, Улаанбаатар хот 14200, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Ерөнхий сайд Амарын гудамж, Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн байр, 2-р давхарт |
| Холбоо барих утас: | 77200088 |
| И-мэйл хаяг: | info@arddaatgal.mn |

## 1.2. Үнэт цаас гаргагчийн хуулийн этгээдийн улсын бүртгэл

| | |
|---|---|
| Компанийн нэр: | Ард Даатгал ХХК |
| Бүртгэгдсэн он, сар, өдөр: | 2006 он 2 сарын 15 |
| Улсын бүртгэлийн дугаар: | 9011325015 |
| Регистрийн дугаар: | 2062089 |
| Үйл ажиллагаа: | Гэнэтийн ослын, жуулчдын гэнэтийн осол, эрүүл мэнд, хөрөнгө, барилга угсралт, тээврийн хэрэгсэл, ачаа, зорчин явагч- тээвэрлэгчийн хариуцлага, зочид буудлын эзний хариуцлага, гуравдагч этгээдийн өмнө хүлээх хариуцлага, давхар даатгалын үйлчилгээ /672000/ |
| Хувьцаа эзэмшигчдийн тоо: | 2 /2018.05.10-ны байдлаар/ |

## 1.3. Үнэт цаас гаргагчийн танилцуулга

*Ард Даатгал ХХК нь 1994 оны 3 сарын 14-ний өдөр Монголын анхны хувийн даатгалын компани болж байгуулагдсан бөгөөд 2004 онд хөрөнгө, санхүүгийн зах зээл дээр зөвлөх үйлчилгээ үзүүлдэг Их Британийн Виттингтон групп тус компанид хөрөнгө оруулалт хийж хувь нийлүүлэгч болсноор улсдаа гадаадын хөрөнгө оруулалттай анхны даатгалын компани болж, Европын даатгалын зах зээлийн шилдэг туршлага, олон улсын Ноу Хау-г Монгол улсын даатгалын зах зээлд авчирсан юм. Энэ хугацаанд бид харилцагч-*

ARD INSURANCE COMPANY
АРД ДААТГАЛ ХХК
УЛААНБААТАР ХОТ

УЛААНБААТАР ХОТ
МХБ-ийн гишүүн Андеррайтер Брокер, дилерийн "ЭНДИКЕЙ" ҮЦК ХК

2018 05 11

СЭХ
2018 08. 29
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
0000014
БҮРТГЭВ 01



*даатгуулагч нарынхаа өвөрмөц хэрэгцээ шаардлагад нийцсэн даатгалын үйлчилгээг мэргэжлийн өндөр төвшинд хүргэж ажиллаж ирлээ. Бидний өнөөг хүртэл Монголын даатгалын зах зээл дээр явуулсан үйл ажиллагаанд харилцагч нарын маань эрэлт хэрэгцээ, бодит хүсэл шаардлага хөтөч нь болж, бид хамтдаа хөгжиж, хамтдаа боловсорч ирсэн юм..."*

**Эрхэм зорилго**

Даатгуулагчийн хэрэгцээ шаардлагад бүрэн нийцсэн, мэргэжлийн ёс зүйг баримталсан, даатгалын шилдэг үйлчилгээг бид үзүүлнэ.

**Алсын хараа**

Ард Даатгал ХХК нь даатгуулагчдын эрэлт хэрэгцээ, шаардлагад бүрэн нийцсэн, тэдний амар тайван амьдралын баталгааг хангасан үйлчилгээг үзүүлж, харилцагчдаа амжилтад хөтөлсөн, нийгмийн хариуцлагыг дээдлэгч, ил тод, итгэл төрүүлсэн тэргүүлэгч даатгагч, даатгалын үйлчилгээ үзүүлэгч байна.

### 1.3.1. Компанийн үнэт зүйлс

- Хүн – Компанийн явуулж буй бүхий л үйл ажиллагаанд оролцож буй хүн бүрд эрх тэгш, хүндэтгэлтэй хандаж, оролцогч талуудын харилцан ашигтай байдлыг эрхэмлэн дээдлэх
- Хариуцлагатай, ил тод байдал – Компанийн гүйцэтгэж буй ажил, үүрэг, үйлдэл бүрийнхээ өмнө хариуцлагатай байж, ил тод нээлттэй үйл ажиллагаа явуулах
- Үнэнч, шударга байдал – Компанийн бүхий л үйл ажиллагаа болон өөрийн ажилдаа ёс зүйтэй, үнэнчээр хандаж, шударга ёсыг эрхэмлэн дээдлэх
- Инноваци – Тодорхой асуудлыг шийдвэрлэх шинэлэг санал санаачилгыг үргэлж дэмжиж урам зориг өгөх.

### 1.3.2. Мөрддөг зарчим

- Монгол улсын хууль журмыг үйл ажиллагаандаа дээдлэн мөрдөж, үнэнч шударга хандан ажиллах
- Сайн засаглал, ил тод байдлыг байгууллагын бүх төвшинд нэвтрүүлэн ажиллах
- Ажилчид өөрийгөө болон бусдыг хөгжүүлэн ажиллахыг эрхэмлэх
- Хамт олны дунд харилцан итгэлцэл, хүндлэл, эерэг дулаан уур амьсгалыг бүрдүүлж, хамтын ажиллагааг дэмжих
- Зах зээлд шинийг санаачилж нэвтрүүлж ажиллах

2018-05-11

ARD INSURANCE COMPANY АРД ДААТГАЛ ХХК УЛААНБААТАР ХОТ

УЛААНБААТАР ХОТ
МХБ-ийн гишүүн Андеррайтер Брокер, дилерийн "ВИДИСЕК" ҮЦК ХК

- Хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг дээдэлж ажиллах
- Харилцагч үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамж, үйлчилгээг боломжит дээд хэмжээнд хүргэн ажиллах.

2011 оны 1 дүгээр улиралд Ард Даатгал ХХК болон "Гранд Даатгал" ХХК-иудын хувь нийлүүлэгчид нь албан ёсоор тус компаниудыг нэгтгэх шийдвэрийг гаргаж, энэхүү шийдвэрийг Монгол Улсын Санхүүгийн Зохицуулах Хорооноос баталгаажуулснаар 2011 оны 2 дугаар улирлаас эхлэн Ард Даатгал ХХК нь "Гранд Даатгал" ХХК-ийг албан ёсоор өөртөө нэгтгэж үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн.

"Ард Даатгал" компани нь 24 жилийн турш тасралтгүй тогтвортой үйл ажиллагаа явуулж, 24 салбар, 238 төлөөлөгчтэй, 100 гаруй ажиллагсадтай болж өргөжөөд байна.

2013 оны жилийн эцсээр Ард Даатгал ХХК-ийн томоохон хувьцаа эзэмшигч болох Интергрупп Интернэйшнл ХХК нь Ард Даатгал компани дахь өөрийн эзэмшил хувьцаагаа ИАйТи ХХК-ийн хувьцаагаар харилцан солилцох гэрээг байгуулсан. Улмаар ИАйТи ХХК нь нэрээ Ард Санхүүгийн Нэгдэл болгож, Ард Даатгал ХХК нь Ард Санхүүгийн Нэгдлийн охин компани болж, энэхүү группийн дор үйл ажиллагаа явуулж байгаа Монгол Шуудан ХК, Ард Кредит, Ард Секюритиз, Ард Лайф, Ард Менежмент, Ард Актив ХЗХ, Тэнгэр Системс зэрэг компаниудтай идэвхтэй хамтарч ажиллаж байна.

2017 оноос Ард Даатгал ХХК нь харилцагчиддаа шинээр газар тариалангийн даатгалын бүтээгдэхүүнийг санал болгож эхэлсэн нь бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулж, борлуулалтын орлогыг цаашид нэмэгдүүлэх боломж олгож байна. 2017 онд ургац алдсан 4 аж ахуйн нэгжид Хөдөө Аж Ахуйн Давхар Даатгал компанитай хамтран 211 сая төгрөгийн нөхөн төлбөрийг олгосон. Мөн тээврийн хэрэгслийн даатгалын бүтээгдэхүүнийг хялбаршуулан, хүртээмжтэй болгох үүднээс 2017 оны эцсээр Хүлэг нэртэй бүтээгдэхүүнийг харилцагчиддаа санал болгож эхэллээ.

Үнэт цаас гаргагч нь 2017 онд татварт нийтдээ 316 гаруй сая төгрөг, нийгмийн даатгалд 245 сая төгрөгийг төлсөн байна.

Аливаа даатгалын компанийн хувьд даатгуулагчдынхаа өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх чадамжийг илэрхийлдэг гол үзүүлэлт нь төлбөрийн чадварын үзүүлэлт юм. Үнэт цаас гаргагч нь Санхүүгийн Зохицуулах Хорооны 2016 оны 105 дугаар тогтоолоор батлагдсан "Ердийн даатгагчийн төлбөрийн чадварыг тооцох журам"-ын дагуу төлбөрийн чадварын үзүүлэлтийг байнга хангаж ирсэн байна.

СЗХ
он 2018 .08. 29 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ 01
0000016

## 1.3.3. Түүхэн замнал

*Схем 1. Үнэт цаас гаргагчийн түүхэн замнал*

**1994 он**
Монголын анхны хувийн даатгалын компани болж байгуулагдсан

**2004 он**
Гадаадын хөрөнгө оруулалттай анхны даатгалын компани болсон

**2011 он**
Гранд даатгал ХХК-г өөртөө нэгтгэж даатгалын салбарт хамгийн анхны нэгдлийг амжилттай хэрэгжүүлсэн.

**2015 он**
Ард Санхүүгийн Нэгдэл-ийн бүрэлдэхүүнд багтан үйл ажиллагаа явуулах боломж удирдлагын баг шинэчлэгдсэн

**2017 он**
Компани төлөвлөсөн зорилтуудаа хүрч,зах зээлд эзлэх байр сууриа улам бэхжүүлэн ажиллаж байна.

### Шагнал урамшуулал:

| | |
|---|---|
| **2000 он** | Ард Даатгал ХХК 5 дахь жилдээ ТОП зэрэглэлийн даатгалын компаниар шалгарав. |
| **2008 он** | СЗХ-ны гаргасан даатгалын компаниудын үнэлгээгээр 3-т шалгаран, Монгол Улсын шилдэг даатгагчдын нэгээр батламжлагдсан |
| **2010 он** | Дэлхийн бизнесийн шилдэг компаниудад олгодог Зууны Чанарын алтан цомыг Швейцар улсын Женев хотод гардан авав. |
| **2012 он** | Засгийн Газар, Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимтай хамтран зохион байгуулдаг ТОП-150 аж ахуй нэгж шалгаруулах шалгаруулалтын ТОП-5 даатгалын компанийн 2-т шалгарсан. Мөн тус онд Монголын Маркетинг, Менежментийн Хүрээлэнгээс зохион байгуулдаг “Гранд Экспо-2012” үндэсний бизнес фестивальд амжилттай оролцож Банк, санхүү, даатгалын салбарын ТОП-5 даатгалын компани номинацийн 1-р байрт шалгарсан. |
| **2013 он** | Засгийн Газар, Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимтай хамтран зохион байгуулдаг ТОП-150 аж ахуй нэгж шалгаруулах шалгаруулалтын ТОП-5 даатгалын компанийн 1-т шалгарсан. |
| **2014 он** | Засгийн Газар, Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимтай хамтран зохион байгуулдаг ТОП-150 аж ахуй нэгж шалгаруулах шалгаруулалтын ТОП-5 даатгалын компанийн 3-т шалгарсан. Мөн Монголын Маркетинг, Менежментийн Хүрээлэнгээс зохион байгуулдаг “Гранд Экспо-2012” үндэсний бизнес фестивальд амжилттай оролцож Банк, санхүү, даатгалын салбарын ГРАН-ПРИ-т шалгарсан. |

ARD INSURANCE COMPANY
АРД ДААТГАЛ ХХК
УЛААНБААТАР ХОТ

УЛААНБААТАР ХОТ
МХБ-ийн гишүүн Андеррайтер Брокер, дилерийн “БИДСЕК” ХХК

### 1.3.4. Нийгмийн хариуцлага

Ард Даатгал ХХК нь байгуулагдсан цагаасаа хойш боловсрол, нийгмийн сайн сайхны төлөөх үйлсийг бизнесийнхээ салшгүй нэг хэсэг болгож ирсэн бөгөөд "Хүүхэд залуус, эрүүл мэнд, эрүүл орчин бидний ирээдүй" гэсэн үндсэн бодлогод тулгуурлан нийгмийн үйл ажиллагааг дэмжин идэвхтэй оролцон ажилладаг. Нийгмийн хариуцлагын хүрээнд байгаль орчин хамгаалах, урлаг спорт дэмжих, хүүхэд өсвөр үеийн боловсрол, хөгжилд хувь нэмрээ оруулах чиглэлээрх ажлуудыг санаачлан зохион байгуулж амжилттай хэрэгжүүлсэн байна.

| **Байгаль орчин хамгаалах чиглэлээр хийгдсэн ажлууд:** | |
|---|---|
| **2013 он** | Ард Даатгал ХХК нь байгаль орчин хамгаалах үйл ажиллагааг компанийн нийгмийн хариуцлагын томоохон хэсэг гэж үздэг бөгөөд Дорноговь аймгийн нутагт байрлах Хамрын хийдэд мод, бутны 400 суулгацыг тус компанийн хамт олон суулган Ард Даатгал ХХК-ийн нэрэмжит цэцэрлэгт хүрээлэнг байгуулсан байна. |
| **2013 он** | Харилцагчдынхаа эрсдэлийг зөвхөн даатгаад зогсохгүй, даатгалын орчин нөхцөл бий болох эрсдэлээс хэрхэн урьдчилан сэргийлэх, тийм нөхцөл бий болбол хэрхэн хохирол багатай даван туулах зэрэг чиглэлээр сургалт, зөвлөгөөнүүдийг харилцагчтайгаа хамтран тогтмол зохион байгуулдаг. |
| **2014 он** | Албан Журмын Даатгагчдын Холбооноос санаачилсан Сэлэнгэ аймгийн нутагт байрлах "Тужийн Нарс" хэмээх газарт бусад даатгалын компаниудтай хамтран нийт 1000 модны суулгац суулгасан байна. |
| **2014 он** | Монгол улсад даатгалын салбар үүсч байгуулагдсаны 80 жил, Ард Даатгал ХХК-ийн 20 жилийн ойн ажлуудын хүрээнд Чингисийн талбайн урд цэцэрлэгт мөнх ногоон гацуурууд суулгасан байна. |
| **2014 он** | Даатгалын салбар үүсч хөгжсөний 80 жилийн ойн арга хэмжээг тохиолдуулан Санхүүгийн Зохицуулах Хорооноос даатгалын салбарын хамт олонтой "ЦЭЦЭЭ ГҮН"-ийн оргил руу явган аялал зохион байгуулсан бөгөөд нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлэгч ААН-ийн хувьд хүрээлэн буй орчноо цэвэрлэх аянд компанийн нийт ажилчид оролцжээ. |
| **2017 он** | Компанийн гүйцэтгэх захирал Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар Монгол орон даяар явагдсан "Ногоон дэлхий" арга хэмжээнд нэгдэн "Цэцэгт аян" хөтөлбөрийг зохион байгуулсан бөгөөд үүнд 150 гаруй даатгуулагчдад 30 |

СЗХ
2018.08.29
БҮРТГЭВ
№ 111

| | |
|---|---|
| | гаруй нэр төрлийн 450 гаруй таримал цэцэг, суулгацыг үнэгүй тараасан ба энэ аянг жил бүр уламжлал болгон зохион байгуулж байна. |

**Спортыг дэмжих чиглэлээр хийгдсэн ажлууд:**

| | |
|---|---|
| **2013 он** | Монголын сагсан бөмбөгийн холбооноос зохион байгуулсан үндэсний PEPSI доод лигт “Ийглс” нэртэй багийг ивээн тэтгэж ажилласан. |
| **2013 он** | “Монголын премиер лиг”-ийн хаврын болон намрын 2 улирал дараалан “ФС Ард Даатгал” хөл бөмбөгийн багийг ивээн тэтгэж тус багийн тэмцээний бооцоо, хувцас хэрэглэл, бэлтгэлийн талбай, тэмцээний үеэр хэрэглэх хангамж зэрэг бүхий л боломжоор хангаж ажилласан байна. |
| **2013 он** | 2013 оны 11 сарын 3-наас 7-ны өдрүүдэд Малайз Улсын Куала Лумпур хотод болсон IPC Powerlifting Asian Open Championships Азийн аварга шалгаруулах тэмцээнд оролцсон Параолимпийн Пауэрлифтингийн төрөлд 88 кг хүртэлх жинд дэлхийд 11-т эрэмбэлэгдэж буй Монгол Улсын аварга тамирчин Энхбаярын Содномпилжээг ивээн тэтгэж бүх зардлыг санхүүжүүлсэн. |
| **2015 он** | Жүдо бөхийн улсын шигшээ багийн гишүүн, Ард Санхүүгийн Нэгдлийн тамирчин О.Жавзмааг дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд оролцоход дэмжлэг туслалцаа үзүүлэн ивээн тэтгэжээ. |
| **2015 он** | Оффроуд автомашин сонирхогчдын клубтэй хамтран Зэрлэг 4x4 бартаат замын уралдааны ерөнхий спонсороор оролцож хамтран зохион байгуулсан. |
| **2016 он** | “Ахиллис Монгол” олон улсын байгууллага, Ариг банкнаас хамтран Олон нийтэд хөгжлийн бэрхшээлийн талаарх ухамсар, ойлголтыг дээшлүүлэх, спорт нь эрүүл мэнд, амжилтын үндэс гэдгийг олон нийтэд сурталчлах, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг спортоор хичээллүүлэх ажлыг санхүүжүүлэх хөрөнгө босгох, нийгмийн хариуцлагатай аж ахуйн нэгж, хувь хүнийг сурталчлах зорилготойгоор “Итгэл Найдвар, Боломж” уриан дор зохион байгуулсан Улаанбаатар хагас марафон “HOPE AND POSSIBILITY ULAANBAATAR 2016”-г зохион байгуулжээ.<br><br>Ард Даатгал ХХК тус гүйлтийн 3 болон 10 км-д гүйгчдийг гэнэтийн ослын даатгалаар даатгаж бүх нийтийн гүйлтийг дэмжин ажиллахын зэрэгцээ |

ARD INSURANCE COMPANY
АРД ДААТГАЛ ХХК
УЛААНБААТАР ХОТ

МХБ-ийн гишүүн Андеррайтер Брокер, Дилерийн “БИДИСЕК” ХХК

| | |
|---|---|
| | хамт олноороо гүйлтэд идэвхтэй оролцож өөрсдийн хувь нэмрээ оруулсан байна. |
| **Урлаг соёлыг дэмжих чиглэлээр хийгдсэн ажлууд:** | |
| 2013 он | "Домогт Анү Хатан" уран сайхны кино болон "Драмын урлагийн дээд шагнал гардуулах – Гэгээн муза" наадмыг тус тус ивээн тэтгэж ажилласан байна. |
| 2015 он | Улсын дуурь бүжгийн эрдмийн театрын Лучия Ди Ламмермур дуурийн цоо шинэ уран бүтээлийг ивээн тэтгэжээ. |
| 2015 ба 2016 он | ХБНГУ-ын Бюделсдөрф хотноо зохион байгуулагдсан Nord-Art 2015, 2016 Олон улсын дүрслэх урлагийн үзэсгэлэнгийн Монголын павильоны зохион байгуулалтыг ивээн тэтгэж хамтран ажилласан байна. |
| 2015 ба 2016 он | Улсын баяр наадмын өмнөх хамгийн том сорилго барилдаан болох "Чингэлтэй Хайрханы Хишиг" шилдэг 256 бөхийн барилдааны ерөнхий ивээн тэтгэгчээр 2 жил дараалан ажиллажээ. |
| 2017 он | Жил бүр зохиогддог Улаанбаатар марафон-2017 бүх нийтийн гүйлтэнд хамт олны төлөөлөл амжилттай оролцсон. |
| 2017 он | Уламжлалт "Чингэлтэй хайрханы хишиг" барилдааныг илүү өргөн хүрээнд Ард Санхүүгийн Нэгдэл, Хөрөнгө Оруулагч Үндэстэн компаниудтай хамтран зохион байгуулж, Ард Даатгал ХХК ерөнхий ивээн тэтгэгчээр ажиллав. |

| | |
|---|---|
| **Хүүхэд, өсвөр үеийн боловсрол, хөгжилд хувь нэмрээ оруулах чиглэлээр хийгдсэн ажлууд:** | |
| 2015 он | Түлэгдэлтэй охинд туслах аянд хамт олноороо нэгдэн, сайн дурын хандив тусламж цуглуулж мөнгөн тусламж үзүүлжээ. |
| 2015 он | Хөдөө орон нутгийн салбарын ажилтнууд Говь-Алтай, Говьсүмбэр, Сэлэнгэ аймгуудад зохиогдсон сургуулийн насны хүүхдэд замын хөдөлгөөнд аюулгүй оролцох дадал олгох "Ногоон гэрэл - Цагаан шугам 2015" арга хэмжээг ивээн тэтгэж идэвхтэй оролцсон. |
| 2014, 2015 он | 6 сарын 1-ний өдөр СОС – Хүүхдийн хотхонд хөгжөөнт тэмцээн зохион байгуулж, нийт 250 хүүхдэд гарын бэлэг бэлэглэсэн. |

СЗХ
2018.08.29-ний өдөр
БҮРТГЭВ
№ 01
0000020

| | |
|---|---|
| 2016 он | Сири улсад дайны хөлд нэрвэгдэж эцэг эх, гэр бүл, орон гэрээ алдсан хүүхдүүдэд туслах зорилгоор санаачлагдсан Өгөөмөр Үндэстэн – Giving Nation хандивын аянд хамт олноороо нэгдэж хандивын зүйлс цуглуулсан. |
| 2016- 2017 он | 11 дэх удаагийн "Дуулиан-2020" өсвөрийн заалны хөл бөмбөгийн тэмцээнээр Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 106, 107 дугаар сургуулийн багуудыг ивээн тэтгэж, дэмжин ажилласан. |
| 2016-2017 он | 2016-2017 оны хичээлийн шинэ жилд Монголын Сурагчдын Холбооны дэргэдэх "School Police-эцэг эхийн эргүүл"-ийн эргүүлийн үүрэг гүйцэтгэхэд хэрэглэгдэх хантааз болон ажиллах журам бүхий самбарыг нийслэлийн 7 дүүргийн нийт 35 сургуульд гардуулан өгчээ. |
| 2017 он | Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан хамт олноороо нэгдэн 3, 4-р хороололд байрладаг 0-1 насны хүүхдүүдэд шаардлагатай өдөр тутмын хэрэглээний зүйлсийг хандивласан. |
| 2017 он | Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан 29 дүгээр тусгай дунд сургуулийн 1-5 дугаар ангийн 150 сурагчдад бэлэг гардуулсан ба Баянгол дүүргийн хүүхдийн асрах төвд зайлшгүй хэрэгцээтэй хүүхдийн тэрэг, хөлд оруулагч, хүүхдийн бассейн, тоглоом зэргийг бэлэглэж, Сонгинохайрхан дүүргийн гал унтраах ангид мөнгөн тусламж үзүүлсэн. |
| 2017 он | Компанийн түнш болох Монгол Коосен сургуулийн Моко багт Робокон-2017 тэмцээнд оролцоход нь дэмжлэг үзүүлж ажилласан бөгөөд тус баг нь тэмцээндээ амжилттай оролцож 4-р байрын шагнал, шилдэг баг өргөмжлөл хүртсэн байна. |

Дээрх ажлуудаас гадна үнэт цаас гаргагч нь дараах ажлуудыг мөн амжилттай санаачлан гүйцэтгэсэн байна:

- Даатгалын ач холбогдол, гамшгийн үед иргэдийн эрсдэлийг даван туулах чадвар, туршлагыг хөгжүүлэх, мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор Нийслэлийн Онцгой Байдлын Газар болон М-Си-Эс Холдинг ХХК-тай хамтран Монголд анх удаа Гамшгаас хамгаалах дадлага сургууль, Гал унтраах тактикийн сургуулийг семинарын болон дадлагаар амжилттай зохион байгуулсан.
- Монгол Шуудан ХК болон what3words-тэй хамтран 2017 оны 12 сарын 1-нээс 22-ны хооронд аймаг, хотын ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд "Өвлийн өвгөний шуудан" захидал, шүлэг, гар зургийн уралдаан зохион байгуулав. Уг

ARD INSURANCE COMPANY АРД ДААТГАЛ ХХК УЛААНБААТАР ХОТ
МХБ-ийн гишүүн Андеррайтер Брокер, дилерийн "БИДИСЕК" ҮЦК ХК

СЗХ
2018 .08 р 29 өдөр
БҮРТГЭВ
№ 01
0000021
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ 01

уралдаанд нийт 15,000 хүүхэд оролцсоноос 100 бүтээлийг шалгаруулан, зохион байгуулагч нар бүтээлийн эздийг урамшуулсан.

## 1.4. Үнэт цаас гаргагчийн эрхэлж буй үйл ажиллагаа

Үнэт цаас гаргагч нь СЗХ-ны 2007 оны 12 сарын 26-ны өдрийн 211 дугаар тогтоолоор ердийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг авсан. Даатгалын үйл ажиллагаа нь гэрээний үндсэн дээр даатгуулагч зохих хураамж төлж өөрийн эд хөрөнгө, ашиг сонирхлоо болзошгүй эрсдэлээс учирч болох хохирлоо нөхөх баталгаатай эх үүсвэртэй байх болон даатгагч хураамж авсны үндсэн дээр даатгуулагчийн даатгуулсан зүйлд учирч болох хохирлыг бүрэн буюу хэсэгчлэн нөхөн төлөх үүрэг хүлээх, эрх эдлэх харилцаа юм.

Үнэт цаас гаргагч нь СЗХ-ны 2012 оны 12 сарын 12-ны өдрийн 356 дугаар тогтоолын дагуу Сайн дурын даатгалын хэлбэрийн ердийн даатгалын ангилалд хамаарах 13, албан журмын даатгалын хэлбэрт хамаарах 1 даатгалын хэлбэрээр үйл ажиллагаа явуулдаг. Ард Даатгал ХХК-ийн мэргэшсэн даатгалын баг нь байгууллагын болон иргэдэд зориулсан даатгалын 13 хэлбэрээр бүтээгдэхүүн, үйлчилгээг 24 салбар нэгжээрээ дамжуулан харилцагч, үйлчлүүлэгчдээ үзүүлж байна.

Даатгуулагчдынхаа эд хөрөнгө, эрүүл мэнд, хариуцлагын эрсдэлийг хамгаалах гэрээний үүргээ биелүүлэхдээ дэлхийн томоохон даатгалын группууд болох Alliance, Munich Re, Swiss Re, Hannover Re, ОХУ-ын Ингосстрах, Lloyd’s Syndicates зэрэг давхар даатгагч болон давхар даатгалын брокерууд болох AON, Marsh, Willis, UIB, JB Boda, Faber, Malakut, Sompo, Tokyo Marine, Galaxy Insurance түүнчлэн эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлдэг Францын “Europ assistance” байгууллагуудтай олон жилийн турш хамтран ажиллаж байгаа.

Үнэт цаас гаргагч нь Монголын Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимаас шалгаруулдаг шилдэг 100 компанийн 70 гаруй компанитай хамтран ажилладаг. Нийт харилцагчдын 17 хувь нь төрийн байгууллагууд ба үүнд Оюу Толгой, Эрдэнэс Таван Толгой, Хөшигтийн Хөндийн олон улсын нисэх онгоцны буудал зэрэг томоохон төслүүд, Энержи Ресурс, Монцемент, Шангри-Ла зэрэг ААН, байгууллага болон сэргээгдэх эрчим хүч, уул уурхай, зам тээврийн салбаруудтай хамтран ажилласан байна. Компани нь харилцагч, даатгуулагчдын эрх ашгийг тэргүүн зэрэгт хүндэтгэн үзэж, даатгалын зах зээлд шударгаар өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэн, өрсөлдөөнд харш үйл ажиллагааг хориглон, эрх зүйн харилцааны хэм хэмжээг мөрдөн, зүй бус хэлцэлд оролцохоос татгалзаж, үйл ажиллагаандаа нээлттэй, шударга ёс зүйг баримтлан ажилладаг.

ARD INSURANCE COMPANY
АРД ДААТГАЛ ХХК
УЛААНБААТАР ХОТ
УЛААНБААТАР ХОТ
МХБ-ийн гишүүн Андеррайтер Брокер, дилерийн "БИДИСЕК" ҮЦК ХК

СЗХ
2018 .08 сар 29 өдөр
БҮРТГЭВ
№ 01

0000022

## 1.4.1. Даатгалын үйлчилгээний процесс

*Схем 2. Даатгалын үйлчилгээний процесс*




2018.05-11

### 1.4.2. Бүтээгдэхүүн, үйлчилгээ

*Схем 3. Компанийн үзүүлдэг бүтээгдэхүүн үйлчилгээ*




БАЙГУУЛЛАГЫН ДААТГАЛ

#### Ачаа тээвэр, ложистик:

**Ачаа тээврийн даатгал** – Даатгуулагчийн тээвэрлэж буй бусдын эзэмшлийн ачаа, бараа тээвэрлэлтийн үеэр аливаа гэнэтийн ослын улмаас гэмтэж бэртсэн тохиолдолд ачаа барааны хохирлыг нөхөн төлөх ач холбогдолтой даатгал.

**Бараа материалын үлдэгдэл** - Даатгуулагч байгууллагын эзэмшлийн эсхүл түрээсийн агуулах, бараа бүтээгдэхүүн хадгалах зориулалтын байранд байгаа бэлэн болон хагас боловсруулсан бүтээгдэхүүн, бусад төрлийн материаллаг эд хөрөнгөнд гэнэтийн эвдрэл гэмтэл, хохирол үүссэн тохиолдолд нөхөн төлбөр олгох ач холбогдолтой даатгал.

СЗХ
2018 .08. 29 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN
0000024
БҮРТГЭВ 01

**Барилга байгууламж, агуулахын даатгал** - Даатгуулагч байгууллагын эзэмшиж /хариуцаж/ түрээслэж буй бүх төрлийн зориулалтаар үйл ажиллагаа явуулж байгаа барилга байгууламжид аливаа гэнэтийн үйл явдлын улмаас эвдрэл, гэмтэл, хохирол гарсан тохиолдолд сэргээн засварлах эсвэл нөхөн төлөх ач холбогдолтой даатгал.

**Ерөнхий хариуцлагын даатгал** - Даатгуулагч байгууллагын явуулж буй үйл ажиллагаа, бүтээгдэхүүн үйлчилгээний нөлөөгөөр гуравдагч этгээдийн эд хөрөнгө, амь нас, эрүүл мэндэд хохирол учруулсан тохиолдолд нөхөн төлөх, сэргээн засварлах ач холбогдолтой бүтээгдэхүүн юм. Мэргэжлийн хариуцлагын, ажил олгогчийн хариуцлагын, ачаа тээвэрлэгчийн хариуцлагын, ажиллагсдын хариуцлагын, эмчийн мэргэжлийн хариуцлагын, бүтээгдэхүүн үйлчилгээний хариуцлагын, түрээслэгчийн хариуцлагын, удирдах ажилтны хариуцлагын даатгал зэрэг багтдаг.

**Жолоочийн албан журмын даатгал** - Жолооч замын хөдөлгөөнд оролцох үедээ гуравдагч этгээдийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөнд учруулж болзошгүй хохирлыг нөхөн төлөх зорилготой бүтээгдэхүүн. 2011 оны 10 сарын 6-ны өдөр Жолоочийн албан журмын даатгалын хууль батлагдсан.

Тус даатгалд даатгуулснаар замын хөдөлгөөнд оролцох эрхтэй болох бөгөөд даатгуулагч байгууллага хөдөлмөрийн гэрээтэй ажилчдаа өмчлөгч эсэхээс үл хамааран мэргэшсэн жолооч болон бүх ангиллын жолооч нараа даатгалд хамруулах боломжтой.

**Тусгай машин механизмын даатгал** – Байгууллагын эзэмшиж буй, хариуцаж буй бүх төрлийн хүнд болон тусгай зориулалтын машин механизм (барилга угсралт, зам засвар хөдөө аж ахуй, уул уурхайн үйл ажиллагаанд ашигладаг) аливаа гэнэтийн явдлын улмаас хохиролд өртвол тус даатгал нь гарсан хохирлыг сэргээн засварлах эсвэл хохирлыг барагдуулан нөхөн олгох зорилготой.

**Тээврийн хэрэгслийн даатгал** - Байгууллагын эзэмшлийн болон хариуцаж буй бүх төрлийн зориулалтанд ашигладаг тээврийн хэрэгсэлд аливаа гэнэтийн явдлын улмаас хохиролд өртсөн тохиолдолд тус даатгал нь гарсан хохирлыг сэргээн засварлах эсвэл хохирлыг барагдуулан нөхөн олгох зорилготой. Тус

ARD INSURANCE COMPANY
АРД ДААТГАЛ ХХК
УЛААНБААТАР ХОТ

УЛААНБААТАР ХОТ
МХБ-ийн гишүүн
Андеррайтер
Брокер, дилерийн
"БИДНСЕК"
ҮЦК ХК

2018 05-111

СЗХ
он 2018 сар 08. 29 өдөр
БҮРТГЭВ
№ 01

0000025
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭ 01

даатгалд бүх төрлийн авто тээврийн хэрэгсэл болон зөвшөөрөгдсөн нэмэлт тоноглолыг даатгуулж болно.

## Банк санхүү

**Хөрөнгийн даатгал** - Даатгуулагч байгууллагын эзэмшлийн болон түрээсийн бүх төрлийн хөдлөх хөрөнгөнд гэнэтийн хохирол учирхад засан сэргээх эсвэл нөхөн төлөх ач холбогдолтой бүтээгдэхүүн.

## Барилга, зам тээвэр

**Барилга угсралтын даатгал** - Даатгуулагчийн барьж буй зам барилга байгууламж болон түүний угсралт, барилга баригдаж буй орчинд хамааралтай эд хөрөнгөнд учирч болох хохирлыг нөхөн сэргээх, засварлах, нөхөн төлөх ач холбогдолтой бүтээгдэхүүн.

Уг даатгалд гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийж гүйцэтгэж байгаа бүх барилга байгууламж, барилгын угсралтын ажлын талбайд байгаа бүх төрлийн бараа материал, техник тоног төхөөрөмж, машин механизм, барилгын ажилчдын түр сууц, агуулах, усан хангамжийн суваг хоолой, инженерийн шугам сүлжээ багтана.

**Барилга угсралтын хариуцлагын даатгал** - Даатгуулагчийн хийж гүйцэтгэж буй барилгын ажлын улмаас гуравдагч этгээдийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөнд осол, гэмтэл учруулсан тохиолдолд сэргээн засварлах болон нөхөн төлөх ач холбогдолтой даатгал юм.

**Тоног төхөөрөмжийн даатгал** - Байгууллагын эзэмшиж, хариуцаж буй бүх төрлийн тоног төхөөрөмж аливаа гэнэтийн явдлын улмаас хохиролд өртвөл тус даатгал нь гарсан хохирлыг сэргээн засварлах эсвэл хохирлыг барагдуулан нөхөн олгох зорилготой. Үйлдвэрийн тоног төхөөрөмжийн даатгал мөн багтана.

## Уул уурхайн салбар

ARD INSURANCE COMPANY
АРД ДААТГАЛ ХХК
УЛААНБААТАР ХОТ
2018 05-11

УЛААНБААТАР ХОТ
МХБ-ийн гишүүн Андеррайтер брокер, дилерийн "БАГАНУУР" ҮЦК ХК
1115205447 2052481

СЭХ
2018 08 29
БҮРТГЭВ
№ 01
0000026

**Ашигт малтмал, газрын тосны бүтээгдэхүүний даатгал** - Даатгуулагч байгууллагын эзэмшлийн агуулах зориулалтын байранд байгаа ашигт малтмал, газрын тосны бүтээгдэхүүнд аливаа урьдчилан тооцоолоогүй гэнэтийн үйл явдлын улмаас хохирол учирсан тохиолдолд нөхөн төлөх зорилготой бүтээгдэхүүн. Бүх төрлийн шатах, тослох материал, нефть бүтээгдэхүүний сав, тоног төхөөрөмж, шахуурга, түгээгүүр, ил, далд шугам хоолойг даатгуулах боломжтой.

## Үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээ

**Ачаа тээврийн даатгал /дотоод/** - Даатгуулагч байгууллагын өөрийн эсвэл гэрээний дагуу бусдын ачаа, бараа бүтээгдэхүүн, эд материалыг монгол орны нутаг дэвсгэр дээр бүх төрлийн тээврийн хэрэгслээр /авто тээврийн хэрэгсэл, галт тэрэг/ тээвэрлэж байх явцад тохиолдож болох эрсдэлийн улмаас хохирол, зардал гарсан тохиолдолд даатгагч нөхөн төлөх ач холбогдолтой бүтээгдэхүүн.

**Ачаа тээврийн даатгал /гадаад/** - Даатгуулагч байгууллагын гэрээний дагуу бусдын ачаа, бараа бүтээгдэхүүн, эд материалыг монгол улсын хилийг давуулан бүх төрлийн тээврийн хэрэгслээр /авто тээврийн хэрэгсэл, галт тэрэг, онгоц, усан онгоц/ тээвэрлэж байх явцад тохиолдож болох эрсдэлийг даатгуулах боломжтой.

**Бизнесийн тасалдлын даатгал** - Даатгуулагч байгууллагын даатгалтай хөрөнгөд учирсан хохирлоос үүдэн түүний бизнесийн үйл ажиллагаа зогссоны улмаас тогтмол зардлаа /ажилчдын цалин болон бусад үйл ажиллагааны зардал/ болон тогтмол орлогоо алдаж байгаа тохиолдолд даатгагчийн зүгээс нөхөн төлбөр олгох ач холбогдолтой бүтээгдэхүүн.

**Зээлийн даатгал** - Орон сууцны урт хугацааны зээл (моргэйж)-ийн гэрээний зээлдэгчээс бусад зээлдэгчийн амь нас, эрүүл мэндэд хохирол учрахад даатгагч даатгалын гэрээнд заасан эрх бүхий этгээдэд мөнгөн төлбөр төлөх нөхцөл бүхий даатгал. Мөн үүнд зээлийн санхүүжилтээр авсан автомашин, үл хөдлөх эд хөрөнгө хамаарна. Зээлдэгч зээлийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйн улмаас зээлдүүлэгч талд төлөх төлбөрийг тасалдсанаас үүсэх эрсдэлийг хамгаалах даатгал мөн байдаг.

ARD INSURANCE COMPANY АРД ДААТГАЛ ХХК УЛААНБААТАР ХОТ
УЛААНБААТАР ХОТ МХБ-ийн гишүүн Андеррайтер Брокер, дилер "БИДИСЕК" ҮЦК ХК
2018 05-11

СЗХ
2018 .08. 29 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK
БҮРТГЭВ
0000027

Санхүүгийн даатгал - Санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой хохирол учрахад даатгагч даатгалын гэрээнд заасан эрх бүхий этгээдэд мөнгөн төлбөр төлөх нөхцөл бүхий даатгал. Бизнес тасалдлын даатгал, төлбөр тасалдлын, гэрээний хариуцлагын даатгал үүнд мөн хамаарна.

Итгэлцлийн даатгал - Аливаа гэрээ, хэлцлээр хүлээсэн үүрэг зөрчигдсөнтэй холбоотой үүсэх алдагдал, зардлыг даатгагч даатгалын гэрээнд заасан эрх бүхий этгээдэд мөнгөн төлбөр төлөх нөхцөл бүхий даатгал. Гүйцэтгэлийн баталгааны даатгал /performance insurance/ - аливаа төслийн гүйцэтгэлтэй холбоотой, чин шударгын баталгааны /fidelity guarantee insurance/ даатгал – байгууллагын ажилтан хууран мэхлэх зэргээр байгууллагад учирч болох хохирлыг даатгах даатгал зэрэг үүнд хамаарна.

ИРГЭДИЙН ДААТГАЛ

Жолооч нарт зориулагдсан бүх төрлийн даатгал – Жолоочийн албан журмын даатгал, жолоочийн хариуцлагын даатгал, тээврийн хэрэгслийн даатгал багтана.

Хариуцлагын даатгал – Жижиг, дунд бизнес эрхлэгчдийн хариуцлагын даатгал, мэргэжлийн хариуцлагын даатгал, орон сууц эзэмшигчдийн иж бүрэн даатгал юм.

Эд хөрөнгийн даатгал – Гэр ахуйн хэрэгсэл, тавилгын даатгал, ачаа тээврийн даатгал /гадаад, дотоод/, гэр, хашаа байшингийн даатгал, жижиг дунд бизнес эрхлэгчдийн хөрөнгийн даатгал, малын индексжүүлсэн даатгал зэрэг даатгалууд багтана.

Эрүүл мэнд, гэнэтийн ослын даатгал – Гадаадад зорчигчдын даатгал, иргэдийн гэнэтийн ослын даатгал, Монгол улсад зорчигчийн даатгал, Нандин эрдэнэ хүүхдийн даатгал, олон улсын эрүүл мэндийн даатгал, хөдөлмөрийн чадвар түр алдалтын даатгал, хурдан морины уралдаанч хүүхдийн гэнэтийн ослын даатгал, эрүүл мэнд, гэнэтийн ослын даатгал зэрэг.

Ард Даатгал ХХК-ийн ослын дуудлагын шуурхай алба даатгуулагчиддаа 365 хоногт 24 цагийн үйлчилгээ үзүүлж байна. 2017 онд 500 мянган төгрөг хүртэлх нөхөн төлбөрийг ажлын 3 өдөрт багтаан шийдвэрлэдэг болсон. Цаашид даатгуулагчдын цагийг хэмнэн интернет орчинд ашиглах боломжтой нөхөн төлбөрийн үйлчилгээг шуурхай үзүүлэх цахим программ үйлчилгээг нэвтрүүлэхээр ажиллаж байна.

АРД ДААТГАЛ ХХК
УЛААНБААТАР ХОТ

УЛААНБААТАР ХОТ
МХБ-ийн гишүүн Андеррайтер Брокер, дилерийн "БИДНЭЕК" ҮЦК
1115205447

СЗХ 2018.08.29 өдөр БҮРТГЭВ № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 0000 28 БҮРТГЭВ 01

### 1.4.3. Группын хамтын ажиллагаа

Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн хөрөнгө оруулалттай болон хараат, охин компаниуд болох Монгол Шуудан ХК, Ард Даатгал, Ард Кредит, Ард Секюритиз, Ард Лайф, Ард Менежмент, Ард Актив ХЗХ, Тэнгэр Системс зэрэг компаниудтай идэвхтэй хамтарч ажиллахын зэрэгцээ санхүүгийн цогц үйлчилгээ, үйл ажиллагааг харилцагчиддаа санал болгож байна.

*Монгол Шуудан ХК-тай явуулж буй хамтын ажиллагаа*

Монгол Шуудан ХК-тай хамтран ажиллах гэрээний хүрээнд хөдөө орон нутгийн салбарууд Монгол Шуудан ХК-ийн эзэмшлийн байрыг түрээслэн хамтын ажиллагааг ойртуулсан.

*Ард Кредит ББСБ-тай явуулж буй хамтын ажиллагаа*

Ард Кредит ББСБ-ын ажиллагсад нь мөн даатгалын бүтээгдэхүүн үйлчилгээг өөрийн харилцагчдад санал болгож, даатгалын борлуулалтад нөлөөлж байгаа бөгөөд Ард Кредитийн зээлийн эрсдэлийн даатгал, кредит картын болон картын үлдэгдлийн эрсдэлийн даатгалыг нэвтрүүлэхээр ажиллаж байна.

*Ард Лайф ХХК-тай явуулж буй хамтын ажиллагаа*

Ард Лайф ХХК нь 2016 оноос Ард Даатгал ХХК-тай хамтран тэтгэврийн хуримтлалын үйлчилгээг гэнэтийн осол, эрүүл мэндийн даатгалын бүтээгдэхүүнтэй хослуулан, тэтгэврийн дансны үйлчилгээ авч буй харилцлагчиддаа санал болгож байна.

*Ард Менежмент ХХК-тай явуулж буй хамтын ажиллагаа*

Ард Менежмент ХХК нь хөрөнгө оруулалтын сангийн удирдлагын үйлчилгээ үзүүлдэг мэргэжлийн зөвлөх компани бөгөөд Ард Санхүүгийн Нэгдлийн хүрээнд тус компанитай хамтран ажиллаж байна.

### 1.4.4. Борлуулалт

Үнэт цаас гаргагч нь 50 гаруй төрлийн даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээг харилцагчиддаа санал болгодог. Даатгалын салбарт өрсөлдөөн ширүүсэж хураамжийн хувь буурч байгаа хэдий ч үнэт цаас гаргагч нь 2017 онд нийт 10.3 гаруй тэрбум төгрөгийн даатгалын хураамжийг төвлөрүүлж 2017 онд өмнөх оны гүйцэтгэлээс 44 хувиар давсан үзүүлэлтийг үзүүлжээ.

Байгууллагын борлуулалтын албанаас нийт 52 тендер шалгаруулалтанд оролцож 18 тендерт гэрээ байгуулах эрх авч шалгарсан.

2018 05 11

АРД ДААТГАЛ ХХК УЛААНБААТАР ХОТ

МХБ-ийн гишүүн Андеррайтер Брокер, диллер ... БИДИЭС ... ҮЦК

Иргэдийн борлуулалтын албанаас олон улсын жишгийг даган банкашуранс /bancassurance/ буюу банкны зуучлал, зуучлагч брокерийн байгууллагуудтай хамтран ажиллаж, борлуулалтын сувгийг нэмэгдүүлэх ажлыг идэвхтэй хийж байгаа бөгөөд Төрийн банк, Хаан банк, Худалдаа Хөгжлийн банк, Капитрон, Үндэсний Хөрөнгө Оруулалтын банкууд болон 12 даатгалын зуучлагч нартай хамтран ажилласан байна. 2017 онд зуучлагчдаар дамжуулан 1.8 тэрбум төгрөгийн хураамжийн орлого төвлөрүүлжээ.

Даатгалын зуучлалаар хамтран ажиллаж байгаа арилжааны банкууд нь зээлийн болон барьцаа хөрөнгийн даатгалыг санал болгодог бөгөөд хөдөө орон нутагт малын даатгалыг мөн идэвхтэй санал болгож ажилласан байна.

Эдгээр зуучлагчид нь Улаанбаатар хот, алслагдсан дүүргүүд, автомашин оношилгооны цэг болон худалдааны төвүүд дээр төвлөрөн Ард Даатгал ХХК-ийн борлуулалтыг хийдэг байна. Мөн банк бус санхүүгийн байгууллагуудтай хамтран гэрээний хүрээнд борлуулалт хийсэн.

Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын зах зээлд Үнэт цаас гаргагч нь 15 компаниас 8 дугаарт жагсаж байна.

Мөн даатгалын ач холбогдлыг ард иргэдэд ойлгуулан таниулахад энэхүү бүтээгдэхүүний үүрэг маш их бөгөөд Монголын Даатгагчдын Холбоогоор дамжуулан албан журмын даатгалын нэр төрлийг олшруулах, даатгалын зах зээлийг тэлэх чиглэлээр тодорхой ажлуудыг төлөвлөөд байна.

*Борлуулалтын орлогыг даатгалын төрлөөр ангилбал:*

*График 1. Борлуулалтын орлогын бүтэц*




2017 оны байдлаар нийт даатгалын хураамжийн орлогын 40.9 хувийг Хөрөнгийн даатгал,

17.2 хувийг жолоочийн хариуцлагын албан журмын даатгал, 12.8 хувийг авто тээврийн хэрэгслийн даатгал, 10.6 хувийг гэнэтийн осол, эмчилгээний даатгал зэрэг тус тус эзэлж байгаа бол бусад хэсэгт газар тариалангийн даатгал, мал, амьтдын даатгал, агаарын хөлгийн даатгал, авто тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал, санхүүгийн даатгал, итгэлцлийн даатгал, агаарын хөлгийг өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой хариуцлагын даатгал багтана.

## Үйл ажиллагааны үзүүлэлт

*График 2. Нийт хөрөнгө /сая.төг/*




Компанийн нийт хөрөнгө нь 2015 оноос хойш жил бүр өссөөр ирсэн ба 2017 онд 11.7 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 22.9 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Хөрөнгийн бүтцэд дийлэнх хувийг мөнгөн хөрөнгө, түүнтэй адилтгах зүйлс болон хөрөнгө оруулалт эзэлнэ. Эх үүсвэрийн бүтцэд 47.4 хувийг орлогод тооцоогүй хураамжийн нөөц болон нөхөн төлбөрийн нөөцийн сан эзэлж байгаа бол 44.6 хувийг эзэмшигчдийн өмч, үлдэх 8 хувийг даатгалын, санхүүгийн, санхүүгийн бус өр төлбөрүүд эзэлж байна.

*График 3. Нийт хураамжийн орлого /сая.төг/*




Хураамжийн орлогын хувьд 2016 онд 21.7 хувиар буурсан, 2017 онд 44.4 хувиар өссөн үзүүлэлттэй байна. 2016 онтой харьцуулахад агаарын хөлгийн даатгал, хариуцлагын даатгал, ачаа тээврийн даатгалууд буурсан.

2017 онд газар тариалангийн даатгал, малын индексжүүлсэн даатгалыг шинээр борлуулж эхэлсэн, Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн хараат, охин компаниудтай хамтран ажиллаж тэдгээрийн харилцагч болон ажиллагсдад даатгалын үйлчилгээг танилцуулан хүргэж эхэлсэн зэрэг нь 2017 оны хураамжийн орлогын өсөлтөд нөлөөлсөн.

*График 4. Нөхөн төлбөр /сая.төг/*




Нөхөн төлбөрийн зардал нь хураамжийн орлоготой хамааралтайгаар үүснэ. 2016 онд нөхөн төлбөрийн зардал хураамжийн орлогын харьцаа нь 37 хувь байсан бол 2017 онд 39 хувьтай байна. 2017 онд давхар даатгагчаас 1.5 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр төлөгдсөнийг хасвал нөхөн төлбөрийн цэвэр зардал 2.51 тэрбум төгрөг болно.

*График 5. Цэвэр ашиг /сая.төг/*




2015 онд алдагдалтай гарсан нь давхар даатгалын хураамж төлсөн боловч давхар даатгагчийн төлсөн нөхөн төлбөр байхгүй, хураамжийн буцаалт өндөр, даатгалын гэрээний зардал өндөр байсантай холбоотой. 2017 онд 1.5 тэрбум төгрөгийн давхар даатгалын нөхөн төлбөр авсан байна.

*График 6. Хөрөнгө оруулалт болон хөрөнгө оруулалтын олз /сая.төг/*




Компани нь СЗХ-ны даатгалын компанийн хөрөнгө оруулалт хийхэд тавигдах шаардлагыг хангаж өөрийн хөрөнгө болон байгуулсан нөөц сангаас дийлэнхийг арилжааны банкны хугацаатай хадгаламж, өрийн хэрэгсэл болон хувьцаагаарх хөрөнгө оруулалт хийн үр ашигтай ашиглаж, өгөөж хүртдог байна. 2017 онд хөрөнгө оруулалт 74.7 хувиар, хөрөнгө оруулалтын олз 31.6 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна. 2017 оны өсөлтөд банкны хадгаламж, засгийн газрын үнэт цаас, хөрөнгийн бирж дэх хувьцааны арилжаа зэрэг мөн үл хөдлөхийн арилжаа, компанийн бондууд зэрэг өгөөж өндөртэй арилжаанд оролцсон нь гол нөлөө үзүүлжээ.

*График 7. Үйл ажиллагааны зардал /сая.төг/*




2017 онд үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны зардал 3.8 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оноос 0.4 хувиар буурсан үзүүлэлт бөгөөд сүүлийн 3 жилд үйл ажиллагааны зардлыг 3.8 тэрбум төгрөгт барьж, зардлын хяналтыг сайжруулж компанийн үр өгөөжийг дээшлүүлсэн байна.

*График 8. Эх үүсвэрийн бүтэц /сая.төг/*




2017 онд эздийн өмч 1 тэрбум төгрөгөөр, нийт нөхөн төлбөрийн нөөц сан 322 сая төгрөгөөр, өр төлбөр 870 сая төгрөгөөр өссөн байна. Өр төлбөрт орлогод тооцоогүй хураамжийн нөөц сан багтсан байдаг. Нийт эздийн өмч болон өр төлбөрийн өсөлтөд эздийн өмч буюу хуримтлагдсан ашиг хамгийн ихээр нөлөөлжээ.

### 1.4.5. Даатгалын хэлбэрүүд

*Малын индексжүүлсэн даатгал /МИД/*

Энэ төрлийн даатгал нь нэг малчны хотонд гарсан хохиролд биш, нийт сумын малын төрөл тус бүрийн хорогдлоос хувь тооцож нөхөн төлбөр олгодог онцлогтой даатгал юм. Үнэт цаас гаргагч нь 2016 оноос уг даатгалыг санал болгож эхэлснээс хойш давхардсан тоогоор 889 малчдын 239,000 толгой малыг даатгалд хамруулж зуд болон байгалийн бусад төрлийн эрсдэлийг даатгасан байна.

Тухайн малчны даатгуулсан жилийнх нь жилийн эцсийн мал тооллогоос дараа жилийнх нь хагас жилийн мал тооллого болох хугацаанд гарсан малын хорогдлыг тооцон нөхөн төлбөр олгоно. Ингэхдээ даатгуулагч малчдын сумын малын төрөл тус бүрийн 5 эсвэл 6 хүртэл хувийг малчдын хариуцах эрсдэлийн хувь буюу босго үзүүлэлт гэж тооцдог.

СЗХ
2018 .08 29 өдөр
БҮРТГЭВ
№ 01



25-30 хувь хүртэлх малын хорогдлыг даатгалын компаниуд болон давхар даатгалын компани хамтран, 30-100 хувь хүртэлх малын хорогдол гарвал гамшиг гэж үзэн даатгалын компани, давхар даатгалын компани, Засгийн газар хариуцдаг.

Ард Даатгал ХХК нь МИД-ын борлуулалтаар 2017 онд 598 малчны 173.2 мянган толгой малыг даатгаж 113.4 сая төгрөгийн хураамжийн орлого төвлөрүүлсэн нь өмнөх жилийн борлуулалтаас 3 дахин өссөн үзүүлэлт ба 1.77 сая төгрөгийн нөхөн төлбөрийг даатгуулагчиддаа олгожээ. Уг даатгалыг давхар даатгалд хамруулан 36.1 сая төгрөгийг давхар даатгагчид төлсөн байна.

Нийт даатгуулсан мал сүргийн 40.6 хувийг ямаа, 40.5 хувийг хонь, 15.4 хувийг үхэр, 3.3 хувийг адуу, 0.2 хувийг тэмээ тус тус эзэлж байна.

*Газар тариалангийн даатгал*

Анх 2016 онд Сэлэнгэ болон Төв аймгийн сумдад Монгол улсын газар тариалангийн нийт бүтээгдэхүүний 60 хувийг дангаар эзэлдэг улаан буудайг туршилтын журмаар даатгуулах үйлчилгээг нэвтрүүлж байсан бол 2017 оноос бүхий л орон нутгийг хамруулан борлуулалт хийж байна. Ард Даатгал ХХК нь газар тариалангийн даатгал хийх зөвшөөрлийг 2017 онд авсан бөгөөд зөвшөөрөл авсан анхны компаниудын нэг юм.

Уг даатгалын хэлбэр нь улаан буудай тариалж буй этгээдийг байгаль, цаг уурын болон бусад урьдчилан сэргийлэх боломжгүй нэр бүхий эрсдэлээс шалтгаалан ургац алдах, улмаар эдийн засгийн хохирол хүлээх эрсдэлээс хамгаалах зорилготой юм.

2017 онд Ард Даатгал ХХК нь Хөдөө Аж Ахуйн Давхар Даатгал болон SCOR RE олон улсын давхар даатгалын компаниудтай хамтран есөн аж ахуйн нэгжийн 817.07 га талбайг даатгасан нь компанийн анхны газар тариалангийн даатгал юм. Уг даатгалаар нийт 817.07 га талбайг даатгаж, 42.8 сая төгрөгийн хураамжийг төвлөрүүлсэн бөгөөд 4 аж ахуйн нэгжид 211 сая төгрөгийн нөхөн төлбөрийг олгосон. 2017 онд уг даатгалаар давхар даатгагчид 37.4 сая төгрөгийн даатгалын хураамж шилжүүлсэн бол давхар даатгагчаас 204.8 сая төгрөгийн нөхөн төлбөр төлсөн. Үнэт цаас гаргагч нь уг даатгалын хэлбэрийг давхар даатгуулснаар өөрийн эрсдэлийг бууруулж чадсан байна.

*Олон улсын эрүүл мэндийн даатгал*

Ard Medicare нь Ард Даатгал ХХК-ийн зүгээс үзүүлж байгаа өндөр төвшний эрүүл мэндийн даатгал бөгөөд энэ бүтээгдэхүүний давхар даатгагчаар Hannover Re, эмнэлгийн үйлчилгээ

ARD INSURANCE COMPANY
АРД ДААТГАЛ ХХК
ТН380 № 2062089
УЛААНБААТАР ХОТ

МХБ-ийн гишүүн Андеррайтер Брокер, дилерийн "БИДИСЕК" ҮЦК ХК
1115205447 № 2012487

2018-05-11

үзүүлэгч компаниар MSH International хамтран ажиллаж, харилцагчиддаа санал болгохоор ажиллаж байна.

Уг даатгалаар дотоодын хамгийн чанартай эмнэлгүүд болон гадаадын 200 орны 330,000 гаруй эмнэлгүүдээр үйлчлүүлэхэд шаардлагатай хэвтэн эмчлүүлэх, амбулатори эмчилгээ зэрэг зардлуудыг даатгагч хариуцна.

Компани нь International SOS байгууллагатай хамтран үйлчлүүлэгчдийг шаардлагатай үед агаараар болон газраар хамгийн ойр байрших эмнэлэгт даатгуулагчийг хүргэж, хамгийн чанартай эмнэлгийн үйлчилгээ үзүүлнэ. Энэхүү хамгаалалтад асран хамгаалагчийн онгоцны тийз болон зочид буудлын зардлыг бүрэн хариуцахаар багтаасан.

Компанийн харилцагчид MSH International –ийн Францын Парис, Канадын Калгари, Арабын Нэгдсэн улсын Дубай, Хятадын Шанхай хотод орших 4 төв оффисоор дамжуулан эрүүл мэндийн цогц үйлчилгээг авах боломжтой ба үйлчлүүлэгчиддээ 24 цагийн турш эрүүл мэндийн зөвлөгөөг үзүүлдэг.

MSH нь 2008 болон 2011 онуудад ISO 2001 стандартыг хангасан байгууллага болсон ба 2013 оны 8 сард ISO 27001 стандартыг авсан. Энэ стандартыг хэрэгжүүлснээр MSH нь үйлчлүүлэгчийн мэдээллийг чандлан нууцалж, бусдад дамжуулах, хэвлэн нийтлэхгүй байх үүрэгтэй бөгөөд энэхүү стандартыг хангасан анхны даатгалын эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлдэг компани болсон юм.

### 1.4.6. Даатгуулагчдын тоо

*Хүснэгт 1. Даатгуулагчдын тоо*

| | 2015 | 2016 | 2017 |
|---|---|---|---|
| Даатгуулагчийн тоо /хувь хүн/ | 49,848 | 53,044 | 25,280 |
| Даатгуулагчийн тоо /хуулийн этгээд/ | 11,289 | 1,375 | 1,699 |
| Байгуулсан даатгалын гэрээний тоо /хувь хүн/ | | 36,372 | 52,833 |
| Байгуулсан даатгалын гэрээний тоо /хуулийн этгээд/ | | 9,129 | 10,800 |
| Нөхөн төлбөр авсан даатгуулагчийн тоо /хувь хүн/ | 5,351 | 2,422 | 1,406 |
| Нөхөн төлбөр авсан даатгуулагчийн тоо /хуулийн этгээд/ | 1,379 | 1026 | 1,994 |

2017 оны байдлаар нийт 52,833 хувь хүн, 10,800 хуулийн этгээд Ард Даатгал компанитай даатгалын гэрээ байгуулсан байна. Даатгуулсан хувь хүмүүсийн 61.8 хувь жолоочийн

ARD INSURANCE COMPANY
УЛААНБААТАР ХОТ

УЛААНБААТАР ХОТ
МХБ-ийн гишүүн Андеррайтер Брокер, Дилер
2018 05-11

СЗХ
2018 .08. 29 өдөр
БҮРТГЭВ
№ 01

хариуцлагын даатгалд, 20 хувь нь зээлийн даатгалд хамрагджээ. Мөн дээрх даатгалын гэрээний хүрээнд нийт 263,046 даатгалын зүйл хамгаалалттай болсон байна.

## Даатгасан зүйлийн тоо /2017 оны байдлаар/

*Хүснэгт 2. Даатгасан зүйлийн тоо*

| Даатгалын зүйл | Хэмжих нэгж | Даатгасан даатгалын зүйлийн тоо |
|---|---|---|
| Хүний амь нас, эрүүл мэнд | хүн | 72,724 |
| Жолоочийн хариуцлагын даатгалд хамрагдсан жолоочийн тоо | хүн | 54,895 |
| Байшин барилга | ш | 15,529 |
| Тоног төхөөрөмж | ш | 12,931 |
| Бараа материал | ш | 27,236 |
| Авто тээврийн хэрэгсэл | ш | 5,863 |
| Ачаа | тн | 49,356 |
| Газар тариалан | га | 13 |
| Мал амьтад | толгой | |
| Агаарын хөлөг | ш | 5 |
| Мөнгөн хөрөнгө | төгрөг | 600 |
| Бусад | | 23,894 |
| **Нийт** | | **263,046** |

## 1.4.7. Компанийн салбарын үзүүлэлт

Компани аймаг, орон нутгийн даатгуулагч нартаа өөрийн 24 салбар, 238 төлөөлөгч, зуучлагч банкны салбарууд, 20 гаруй зуучлагч компаниудаар үйлчилдэг. 2017 онд нийт 1.4 тэрбум төгрөгийн төлөвлөгөөт даатгалын хураамжийн орлогыг бүрдүүлж, 230 сая төгрөгийн нөхөн төлбөрийг шийдвэрлэсэн байна.

Санхүүгийн зохицуулах хорооноос аймгийн салбаруудад хийсэн хяналт шалгалтаар үйл ажиллагаа хэвийн, холбогдох хууль тогтоомжийн дагуу даатгалын үйл ажиллагаа эрхэлж байгааг батлан тогтоосон.

Мөн орон нутгийн байгууллага, ААН-үүдэд хандсан даатгалын зөвлөгөө, сургалтыг явуулдаг бөгөөд тэдгээрийн даатгалын хэрэгцээ, санхүүгийн чадварт нь тохируулсан уян хатан үнийн бодлого баримтлан ажиллаж байна.

ARD INSURANCE COMPANY
АРД ДААТГАЛ ХХК
ТТД 2062089
УЛААНБААТАР ХОТ

УЛААНБААТАР ХОТ
МХБ-ийн гишүүн Андеррайтер Брокер, Дилер
"БИДИСИ" ҮЦК ХК

2018-05-11

Иргэдэд хүрч үйлчлэх борлуулалт, мэдээллийн сувгуудыг өргөжүүлэхээр орон нутгийн 60 гаруй Хадгаламж Зээлийн Хоршоодыг нэгтгэсэн Хөдөөгийн Бичил Санхүүгийн Хөгжлийг Дэмжих Холбоотой стратегийн түншлэлийг бий болгон ажиллаж байна.

Компани нь салбаруудынхаа байршлыг даатгуулагч нартаа илүү ойртуулах зорилгоор 11 салбарын байршлыг өөрчилж, тохижуулжээ.

*График 9. Орон нутгийн салбарын үзүүлэлт /сая.төг/*




## 1.4.8. Нөхөн төлбөр

Даатгалын тохиолдол үүсэх (даатгуулсан зүйлд хохирол учирсан, гэрээгээр тохирсон болзол бүрдсэн) үед даатгагч компани даатгуулагчид нөхөн төлбөр өгөх үүрэг хүлээнэ.

Даатгалын тохиолдол үүсэх үед даатгуулагч нь даатгагчид нэн даруй мэдэгдэж дуудлага өгөх шаардлагатай ба хөдөө орон нутагт хохирлын газар очиж үзэх боломжгүй тохиолдолд зураг, бичлэг зэргээр баталгаажуулах эсвэл даатгалын шуурхай алба руу утасдаж мэдэгдэх мөн шаардлагатай тохиолдолд мэргэжлийн байгууллагад мэдэгдэнэ.

Даатгагч компанийн шуурхай дуудлагын ажилтан дуудлагыг хүлээн авч хохирлын газар биеэр очиж, нөхцөл байдлыг баталгаажуулах, зөвлөгөө өгнө.

Даатгуулагч этгээд нь тохиолдлын тухай дүгнэлт гаргасан мэргэжлийн байгууллагын тодорхойлолт, хохирол үнэлгээний компаниар үнэлгээ хийлгэх болон хууль болон гэрээнд заагдсан баримт, материалыг бүрдүүлж өгснөөр даатгагч нь нөхөн төлбөрийн материал бүрэн гүйцэд хүлээн авснаас хойш ажлын 14 хоногт багтаан дүгнэлт, шийдвэрийг гаргаж хохирогч эсвэл даатгуулагчид нөхөн төлбөрийг олгоно эсвэл татгалзсан шийдвэрийг тайлбар албан бичгийн хамт гаргаж болно.

*График 10. Нөхөн төлбөрийн хэмжээ /сая.төг/*




Ард Даатгал ХХК нь 2017 онд нийт 3,400 даатгуулагчдад 4.06 тэрбум төгрөгийн хохирлыг төлж барагдуулсан. Энэ нь өмнөх оны үеэс 1.4 тэрбум төгрөгөөр буюу 57 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

*Нөхөн төлбөрийг бүтээгдэхүүний төрлөөр дараах бүтэцтэй олгосон байна:*

*График 11. Нөхөн төлбөрийн бүтэц*




Барилга угсралтын даатгал нь хамгийн их буюу нийт нөхөн төлбөрийн 32.10 хувийг эзэлж байна. Барилга угсралтын даатгалаар гүйцэтгэж буй бүх барилга байгууламж, барилга угсралтын ажлын талбайд байгаа бүх төрлийн бараа материал, техник тоног төхөөрөмж, машин механизм, ажилчдын түр сууц, агуулах, усан хангамжийн суваг хоолой, инженерийн шугам сүлжээг даатгуулах боломжтой юм. Даатгагч галын, байгалийн, цахилгаан эрчим хүч, ус чийг, гадны нөлөөлөл зэрэг эрсдэлийг даатгуулах боломжтой.

*Давхар даатгалын нөхөн төлбөрийг ангилбал:*

*График 12. Давхар даатгагчаас төлсөн нөхөн төлбөр*




2017 онд Ард Даатгал ХХК-ийн даатгалын нөхөн төлбөр болон давхар даатгагчаас төлсөн нөхөн төлбөрийн дийлэнх хувь нь барилга угсралтын даатгалаар гарсан ба уул уурхайн салбараас гадна барилга угсралт, инжинерингийн салбар хурдацтай хөгжиж буйн илэрхийлэл болж байна.

СЗХ
2018.08.29 өдөр
БҮРТГЭВ
№ 01

### 1.4.9. Хохирлын харьцаа

Хохирлын харьцаа нь даатгалын компанийн ашигт байдал болон бат бөх байдлыг илтгэдэг Хохирлын харьцааг нөхөн төлбөрийн зардлыг даатгалын хураамжийн орлогод харьцуулан тооцдог. Даатгал төрөл, хэлбэрээс хамааран хохирлын харьцаа оор оор гардаг. Жишээ нь, эрүүл мэндийн даатгалын тохиолдол тохиолдох магадлал бусад төрлийн даатгалаас давтамж өндөртэй байдаг тул нөхөн төлбөрийн зардал өндөр байдаг.

*График 13. Хохирлын харьцаа /нийт/*




Нийт хохирлын харьцааг нөхөн төлбөрийн зардал болон орлогод тооцсон хураамж, давхар даатгалын хураамжийн зардлын нийлбэрээр харьцуулан тооцоолсон. 2017 онд Ард Даатгалын нийт хохирлын харьцаа 43.55 хувь, салбарын нийт хохирлын харьцаа нь 35.4 хувь гарсан байна.

*График 14. Хохирлын харьцаа /цэвэр/*




Цэвэр хохирлын харьцааг цэвэр нөхөн төлбөрийн зардал болон орлогод тооцсон хураамжид харьцуулан тооцоолсон. 2017 онд Ард Даатгалын цэвэр хохирлын харьцаа 41.65 хувь, салбарын цэвэр хохирлын харьцаа нь 38.5 хувь гарсан. Сүүлийн 3 жилийн үзүүлэлтээр Ард Даатгалын цэвэр хохирлын харьцаа салбарын харьцаа үзүүлэлттэй харьцуулахад илүү хэмжээгээр буурсан нь давхар даатгалд эрсдэлээ тараан байршуулж, харилцагчиддаа давхар даатгалын нөхөн төлбөрийг амжилттай хүргэснийг илтгэж байна.

### 1.4.10. Давхар даатгал

Давхар даатгал нь даатгагч компани даатгуулагчийн өмнө хүлээсэн үүргээ бүрэн буюу хэсэгчлэн дахин даатгуулахыг хэлнэ. Үнэт цаас гаргагч нь анх 2004 оноос давхар даатгалын

УЛААНБААТАР ХОТ
МХБ-ийн гишүүн Андеррайтер Брокер, дилерийн "БИДИСЕК" ҮЦК ХК

СЭХ
2018 08 29
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
0000039
БҮРТГЭВ 01

гэрээ байгуулж эхэлсэн бөгөөд 2010 оноос давхар даатгалын гэрээний тоо болон хамтран ажилладаг брокер, давхар даатгалын компаниудын тоо эрс нэмэгдсэн.

Өнөөдрийн байдлаар үнэт цаас гаргагч нь Hannover re, Munich re, Scor re, Allianz зэрэг 20 гаруй дэлхийн топ давхар даатгалын компаниуд Marsh, AON, Willis, UIB зэрэг 10 гаруй давхар даатгалын брокеруудтай хамтран ажиллаж байна. 2018 онд Марш, Малакут, Виллис зэрэг 6 брокерын компанитай хамтран ажиллахаар төлөвлөсөн байна.

Мөн харилцагчдынхаа үйл ажиллагааны чиглэлээс хамаарч давхар даатгалтай бүтээгдэхүүний багцаа төрөлжүүлэхэд чиглэсэн стратегийг хэрэгжүүлэн давхар даатгагч нартай хийсэн стратегийн түншлэлийн туслалцаатайгаар шинэ зах зээл рүү нэвтрэх аргачлал туршлага хуримтлуулсан ба үүний үр дүнд давхар даатгалтай бүтээгдэхүүний хураамжийн орлого өнгөрсөн оны мөн үеэс 3 дахин нэмэгдэж 2.8 тэрбум төгрөгт хүрсэн байна.

Ард Даатгал ХХК нь гадаадын давхар даатгалын компаниудтай идэвхтэй хамтран ажиллахын зэрэгцээ дотоодын давхар даатгагч Хөдөө Аж Ахуйн Давхар Даатгал ХК-тай хамтран Монгол улсын газар тариалангийн даатгалыг анх удаа амжилттайгаар хэрэгжүүлж дөрвөн аж ахуйн нэгжид 211 сая төгрөгийн нөхөн төлбөр олгосон. Мөн малын индексжүүлсэн даатгалын үйлчилгээг ХААДД-ын компанитай хамтран өөрийн салбаруудаар дамжуулан малчдад хүргэж байна.

Үнэт цаас гаргагч нь Монгол улсын даатгалын зах зээлд эрсдэлийн менежментийг нэвтрүүлж, трити гэрээгээр (treaty reinsurance- давхар даатгуулах гэрээ) эрсдэл даах чадамжаа өсгөж, түргэн шуурхай үйлчилгээгээр хангаж ирсэн. Трити гэрээний давхар даатгагч нь дэлхийн тэргүүлэх давхар даатгалын Hannover Re компани юм. Уг гэрээ нь компанийн эрсдэл даах чадавхыг нэмэгдүүлэхээс гадна харилцагчдад хамгийн найдвартай, өндөр түвшний даатгалын хамгаалалт болдог.

A.M. Best, Standard & Poor's үнэлгээний байгууллагын Hannover Re компанид өгсөн үнэлгээ:

*Хүснэгт 3. Давхар даатгагч компанийн үзүүлэлт*

| Компанийн нэр | A.M. Best Rating | A.M. Best Outlook | Standard & Poor's Rating | Standard & Poor's Outlook |
|---|---|---|---|---|
| Hannover Rück SE | A+ | stable | AA- | stable |

ARD INSURANCE COMPANY АРД ДААТГАЛ ХХК ТТН380 рд.2062089 УЛААНБААТАР ХОТ

УЛААНБААТАР ХОТ МХБ-ийн гишүүн Андеррайтер Брокер, дилерийн "БИДНСЕК" ҮЦК ХХК 1115205441 р 2052482

2018 05 11

А+, АА- үнэлгээ нь урт хугацаанд зээлийн өр төлбөрөө төлөхгүй байх эрсдэл маш бага, чанартай, богино хугацааны өр төлбөрийг эргэн төлөх чадвар хамгийн сайн үзүүлэлт гэдгийг илтгэнэ.

Трити гэрээний хүрээнд үнэт цаас гаргагчийн хөрөнгө, барилга угсралт/тоног төхөөрөмж угсралт, гуравдагч этгээдийн өмнө хүлээх хариуцлага, тээвэрлэгчийн хариуцлага, олон нийтийн өмнө хүлээх хариуцлага, бүтээгдэхүүний хариуцлага, ачаа тээвэр, хүнс машин механизм зэрэг бүтээгдэхүүнийг давхар даатгалд хамрууулжээ.

*График 15. Давхар даатгалын хураамжийн зардал /сая.төг/*




Уул уурхай, зам барилга, хүнд үйлдвэрийн томоохон компаниудтай хамтын ажиллагааг эрчимжүүлснээр давхар даатгалын зардал өссөн байна.

*График 16. Давхар даатгалын хураамжийн зардалын бүтэц*




*График 17. Давхар даатгалын үзүүлэлт*

| /мян.төг/ | Даатгалын хураамжийн орлого | Нөхөн төлбөрийн зардал | Давхар даатгалын хураамжийн зардал | Давхар даатгалын нөхөн төлбөр | Зөрүү |
|---|---|---|---|---|---|
| Барилга угсралтын даатгал | 450,588.6 | 1,304,410.6 | 282,049.1 | 1,278,169.3 | **142,298.2** |
| Газар тариалангийн даатгал | 42,834.1 | 211,173.4 | 37,394.3 | 204,838.2 | **-895.4** |

СЗХ 2018.08.29 өдөр БҮРТГЭВ № 01
0000041 БҮРТГЭВ 01

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| Санхүүгийн даатгал | 12,066.9 | 314,492.5 | 1,242 | | **-303,667.6** |

Дээрх даатгалуудад үнэт цаас гаргагч нь авсан хураамжийн орлогоосоо илүү хэмжээний нөхөн төлбөрийн зардал төлсөн. Харин давхар даатгалд хамрагдсанаар төлөөн хураамжийн зардлаас илүү нөхөн төлбөрийг давхар даатгагч байгууллагаас төвлөрүүлж уг эрсдэлийг бууруулж тараан байршуулсан байна.

Санхүүгийн даатгалын хувьд 2011-2013 онд хийгдсэн гэрээний үүргийн гүйцэтгэлийн нөхөн төлбөр 2015-2017 онд хийгдсэн байна.

## 1.4.11. Нөөц сан

*График 18. Нөөц сангийн бүтэц*




Үнэт цаас гаргагчийн нөөц сан сүүлийн 3 жилийн турш тогтвортой байсан бөгөөд 2017 оны байдлаар нийт нөөц сангийн 38.5 хувийг тусгай нөөц сан, 27.8 хувийг учирч болзошгүй нөөц сан, 31.9 хувийг учирсан боловч мэдэгдээгүй нөөц сан эзэлж байна. Үлдэх 1.8 хувийг мэдсэн боловч төлөөгүй ХНС эзэлж байна.

## 1.5. Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа явуулдаг зах зээлийн талаарх мэдээлэл

Даатгалын компанийг ердийн, урт хугацааны, давхар даатгал гэж ангилдаг бөгөөд Монгол Улсын даатгалын зах зээлд 2017 оны жилийн эцсийн байдлаар

- Ердийн даатгалын 15
- Урт хугацааны даатгалын 1
- Давхар даатгалын 1
- Даатгалын төлөөлөгч 2893
- Даатгалын зуучлагч 42
- Даатгалын хохирол үнэлэгч 29
- Даатгалын үйл ажиллагаанд аудит хийх эрх бүхий аудитын 42 компани

Аудитор 130 тус тус тусгай зөвшөөрөлтэйгээр үйл ажиллагаагаа эрхэлж байна.

2018.05.11
ARD INSURANCE COMPANY АРД ДААТГАЛ ХХК УЛААНБААТАР ХОТ
УЛААНБААТАР ХОТ МХБ-ийн гишүүн Андеррайтер Брокер Дилер компани "БОДЛОГО" ҮЦК ТӨХК

*Салбарын нийт хөрөнгө*

Даатгалын компанийн санхүүгийн тайлангийн эх үүсвэрийн тал нь нийт өр төлбөр, нөөц сан, эзэмшигчдийн өмч гэсэн хэсгээс бүрддэг. Салбарын хэмжээнд нийт хөрөнгө 2017 оны жилийн эцсийн байдлаар 195.05 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 17.6 хувиар өссөн байна. Үүний 49.8 хувь буюу 97.20 тэрбум төгрөг нь даатгалын компанийн нөөц сан бол 30.9 хувь буюу 60.33 тэрбум төгрөг нь даатгалын компанийн дүрмийн санг бүрдүүлж байна.

Зах зээлд эзлэх байр суурь

*График 19. Нийт хөрөнгөөр зах зээлд эзлэх байр суурь /сая.төг/*




2017 оны жилийн эцсийн байдлаар Ард Даатгал ХХК нь зах зээл дээрх ердийн 15 даатгалын компаниас нийт хөрөнгийн дүнгээрээ 7 дугаарт эрэмбэлэгдэж байна.

*График 20. Нийт хураамжийн орлогоор зах зээлд эзлэх байр суурь /сая.төг/*




2017 оны жилийн эцсийн байдлаар Ард Даатгал ХХК нь зах зээл дээрх ердийн даатгалын 15 компаниас нийт хураамжийн орлогын дүнгээрээ 6 дугаарт эрэмбэлэгдэж байна.

СЗХ
2018 .08.29 өдөр
БҮРТГЭВ
№ 01
0000043



*График 21. Цэвэр ашгийн хэмжээгээр зах зээлд эзлэх байр суурь /сая.төг/*




2017 оны жилийн эцсийн байдлаар салбарын хэмжээгээр Ард Даатгал ХХК 3 дугаарт эрэмбэлэгдэж байна.

Салбарын өсөлт ба Ард Даатгалын өсөлт

*График 22. Нийт хөрөнгийн өсөлтийн хувь /2013-2017/*




Салбарын нийт хөрөнгийн өсөлт 2015 онд 21 хувь орчим байсан бол 2016 онд огцом буурч -4.5 хувьд хүрсэн ба 2016 онд эргээд 18.9 хувь хүртэл өссөн байна. Ард Даатгал ХХК-ийн 2015 оноос хойших нийт хөрөнгийн өсөлт салбарын трендтэй ойролцоо өсөлттэй байсан бол 2017 онд салбарын өсөлтөөс өндөр өсөлттэй гарсан байна.

*График 23. Хураамжийн орлогын өсөлтийн хувь /2013-2017/*




Салбарын хэмжээнд 2014 оноос хураамжийн орлого аажмаар буурсаар 2016 онд -0.5 хувийн бууралттай байсан ба 2017 оноос сэргэж 26.4 хувийн өсөлтийн үзүүлэлттэй байна. Ард Даатгал ХХК-ийн хувьд хураамжийн орлогын өсөлт нь 2014 оноос зах зээлийн трендтэй ижил байсан хэдий ч зах зээлийн өсөлтийн хэмжээнээс бага өсөлтийн хувьтай байсан бол 2017 онд зах зээлийн өсөлтийн хувийг давж 44.4 хувийн хураамжийн орлого төвлөрүүлжээ.

ARD INSURANCE COMPANY
АРД ДААТГАЛ ХХК
УЛААНБААТАР ХОТ
УЛААНБААТАР ХОТ
МХБ-ийн гишүүн Андеррайтер Брокер, дилерийн "БИДИ СЕК" ҮЦК ХХК

СЗХ 2018.08.29 өдөр БҮРТГЭВ № 01
0000044 БҮРТГЭВ 01 ...... он .... сар ... өдөр

*График 24. Цэвэр ашгийн өсөлт өсөлтийн хувь /2013-2017/*




Цэвэр ашгийн хувьд 2017 оны жилийн эцсийн байдлаар ердийн даатгалын компаниуд 2014 онд өмнөх оноос бууралттай байсан бол 2015 онд өсөж, 2015 оноос цэвэр ашгийн өсөлтийн хувь аажмаар буурсаар 2017 онд 2.9 хувьд хүрчээ. "Ард Даатгал"-ийн нийт хөрөнгө, хураамжийн орлогын үзүүлэлт салбарын трэндтэй ижил байсан бол цэвэр ашгийн үзүүлэлт нь салбарын трэндээс өөр байна. Тухайлбал, 2015 онд алдагдалтай ажиллаж 2016 онд хурдацтай өсөж, 2017 онд өмнөх оны ашгаас 160.7 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

*График 25. Үнэт цаас гаргагчийн зах зээлд эзлэх хувь*













2018 05 11
ARD INSURANCE COMPANY АРД ДААТГАЛ ХХК ТН3802062088 УЛААНБААТАР ХОТ
УЛААНБААТАР ХОТ МХБ-ийн гишүүн Андеррайтер Брокер, дилерийн "БИДИСЕК" ҮЦК ХК

СЗХ
он 2018 08. 29 өдөр
БҮРГГЭВ
№ 01

0000045
БҮРТГЭВ 01
...... он .... сар .... өдөр

*График 26. Салбарын нийт хураамжийн орлогын бүтэц*




Салбарын хэмжээнд хураамжийн орлогын 25 хувийг хөрөнгийн даатгал, 21 хувийг жолоочийн хариуцлагын даатгал, 13 хувийг авто тээврийн хэрэгслийн даатгал эзэлж байгаа бол бусад хэсэгт ачааны, газар тариалангийн, итгэлцлийн, санхүү, зээлийн зэрэг даатгалууд багтана.

*График 27. Салбарын нийт нөхөн төлбөрийн бүтэц*




Нийт нөхөн төлбөрийн 34 хувийг жолоочийн хариуцлагын даатгал, 19 хувийг авто тээврийн хэрэгслийн даатгал, 15 хувийг хөрөнгийн даатгал эзэлж байгаа ба бусад хэсэгт газар тариалангийн, мал амьтдын, агаарын хөлгийн зэрэг даатгалууд багтаж байна.

## Даатгалын нөөц сан

Даатгалын компаниудын нөөц сангийн хэмжээ 2017 оны 4 дүгээр улиралд 65.3 тэрбум төгрөг болж өнгөрсөн оны мөн үеэс 26.1 хувиар өссөн байна. Сүүлийн 5 жилийн хугацааны даатгалын нөөц сангийн өсөлтийг дараах дүрслэлээр харуулав.

*График 28. Даатгалын салбарын нийт нөөц сан*

2018 08 05 11

ARD INSURANCE COMPANY АРД ДААТГАЛ ХХК УЛААНБААТАР ХОТ

УЛААНБААТАР ХОТ МХБ-ийн гишүүн Андеррайтер Брокер, дилерийн "БИ ДИ СЕК" ХХК

СЭХ 2018.08.29 БҮРТГЭВ № 01
0000046 БҮРТГЭВ 01




2016 онд нөөц сангийн дүн 28.9 хувиар буурсан нь 2016 оноос мөрдөж эхэлсэн Нягтлан бодох бүртгэлийн зааврын дагуу "Орлогод тооцоогүй хураамжийн нөөц"-ийг санхүүгийн тайланд нөөц сангаас тусад нь тусган бүртгэж байгаатай холбоотой байна.

*График 29. Даатгалын салбарын хураамжийн орлого төвлөрүүлэлт*




2017 оны байдлаар салбарын хэмжээнд даатгалын хураамжийн орлогын 47 хувийг даатгалын компани, 29.6 хувийг даатгалын зуучлагч, 24.7 хувийг даатгалын төлөөлөгч бий болгож байна.

*Салбарын харьцаа үзүүлэлт*

*Хүснэгт 4. Салбарын харьцаа үзүүлэлт*

| | 2015 | 2016 | 2017 |
|---|---|---|---|
| Хохирлын харьцаа /нийт хураамжийн орлого/ | 0.32 | 0.30 | 0.31 |
| Зардлын харьцаа | 0.42 | 0.41 | 0.38 |
| Хосолсон харьцаа | 0.73 | 0.71 | 0.70 |
| | | | |
| Хохирлын харьцаа /цэвэр хураамжийн орлого/ | 0.52 | 0.47 | 0.49 |
| Зардлын харьцаа | 0.69 | 0.64 | 0.59 |
| Хосолсон харьцаа | 1.21 | 1.11 | 1.08 |

*Ард Даатгал ХХК-ийн харьцаа үзүүлэлт*

*Хүснэгт 5. Ард Даатгал ХХК-ийн харьцаа үзүүлэлт*

ARD INSURANCE COMPANY АРД ДААТГАЛ ХХК УЛААНБААТАР ХОТ
УЛААНБААТАР ХОТ МХБ-ийн гишүүн Андеррайтер, Брокер, Дилерийн "БИДИСЕК" ҮЦК ХК
2018 05-11

СЗХ
2018.08.29 өдөр
БҮРТГЭВ
№ 01



0000047
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ
01

| | 2015 | 2016 | 2017 |
|---|---|---|---|
| Хохирлын харьцаа /нийт хураамжийн орлого/ | 0.42 | 0.36 | 0.39 |
| Зардлын харьцаа | 0.42 | 0.53 | 0.37 |
| Хосолсон харьцаа | 0.84 | 0.89 | 0.76 |
| Хохирлын харьцаа /цэвэр хураамжийн орлого/ | 0.54 | 0.46 | 0.59 |
| Зардлын харьцаа | 0.54 | 0.67 | 0.55 |
| Хосолсон харьцаа | 1.09 | 1.12 | 1.14 |
| Хохирлын харьцаа /орлогод тооцсон хураамж/ | 0.60 | 0.44 | 0.67 |
| Зардлын харьцаа | 0.60 | 0.65 | 0.63 |
| Хосолсон харьцаа | 1.20 | 1.10 | 1.30 |

*Хохирлын харьцаа*

Хохирлын харьцааг нөхөн төлбөрийн зардлыг нийт хураамжийн орлого, цэвэр хураамжийн орлого, орлогод тооцсон хураамжид харьцуулан тооцсон.

Хохирлын харьцаа нь даатгагчийн ашигт ажиллагаа болон хураамжийн орлогоос нөхөн төлбөрт төлж буй үзүүлэлтүүдийг харуулдаг. Хохирлын харьцаа бага байх нь даатгагчийн ашигтай ажиллаж байгааг илэрхийлдэг. Даатгал бүрд хохирол учрах магадлал, хураамжийн орлого зэргээс хамааран хохирлын харьцаа өөр өөр гардаг.

Салбарын хэмжээнд хохирлын харьцаа нь сүүлийн 3 жилд тогтвортой байсан ба нийт хураамжийн орлогын ойролцоогоор 30-аад хувийг нөхөн төлбөрт өгснийг илэрхийлж байна.

Үнэт цаас гаргагчийн хохирлын харьцаа нь 2015 оноос буурсан ба салбарын харьцаатай ойролцоо төвшинд байна.

*Зардлын харьцаа*

Зардлын харьцааг үйл ажиллагааны зардлыг нийт хураамжийн орлого, цэвэр хураамжийн орлого, орлогод тооцсон хураамжид харьцуулан тооцоолсон. Уг харьцаа үзүүлэлт нь даатгагч 1 төгрөгний орлого олохын тулд хэдэн төгрөгийн зардал гаргаж буйг илэрхийлдэг.

Салбарын хэмжээнд зардлын харьцаа нь сүүлийн 3 жилд тогтвортой байсан бол Ард Даатгал ХХК-ийн зардлын харьцаа нь 2017 онд 2015 болон 2016 оны үзүүлэлтээс буурсан байна. Энэ нь үнэт цаас гаргагч нь зардлыг бууруулж ашигт ажиллагаа нэмэгдүүлснийг

2018 05 11

ARD INSURANCE COMPANY
АРД ДААТГАЛ ХХК
УЛААНБААТАР ХОТ

УЛААНБААТАР ХОТ
МХБ-ийн гишүүн Андеррайтер Брокер, дилерийн "ББСБ" ҮЦК ХК

СЗХ
2018 .08. 29 өдөр
БҮРТГЭВ
№ 01

илтгэж байна. Тухайлбал Ард Даатгал ХХК нь 2015 онд 1 төгрөгийн орлого олохын тулд 0.42 төгрөгийн зардал гаргадаг байсан бол 2017 онд 0.33 төгрөг болж буурсан байна.

Бусад харьцаа үзүүлэлт

Салбарын болон Ард Даатгал ХХК-ийн эзэмшигчдийн өмчийн өгөөж /ROE/ харьцааг Дупонт шинжилгээ /Dupont Analysis/-ний дагуу 3 бүтцэд задлан дараах хүснэгтэд тооцооллоо.

*Хүснэгт 6. Салбарын болон Ард Даатгал ХХК-ийн харьцаа*

| | *Салбар* | | | *Ард Даатгал* | | |
|---|---|---|---|---|---|---|
| | *2015* | *2016* | *2017* | *2015* | *2016* | *2017* |
| Цэвэр ашгийн маржин | 4.10% | 7.57% | 6.16% | -2.34% | 6.01% | 10.85% |
| Нийт хөрөнгийн эргэц | 0.79 | 0.73 | 0.79 | 1.05 | 0.78 | 0.97 |
| Санхүүгийн хөшүүрэг | 1.69 | 1.53 | 1.63 | 2.17 | 2.27 | 2.24 |
| Эзэмшигчдийн өгөөж /ROE/ | 5.44% | 8.45% | 7.89% | -5.32% | 10.71% | 23.71% |
| Нийт хөрөнгийн өгөөж /ROA/ | 3.22% | 5.54% | 4.84% | -2.45% | 4.71% | 10.57% |

2015 онд Ард Даатгал ХХК-ийн хувьд алдагдалтай ажилласнаас үүдэлтэй цэвэр ашгийн маржин болон эзэмшигчдийн өмчийн өгөөж сөрөг утгатай гарсан байна. Харин салбарын хэмжээнд цэвэр ашгийн маржин 4.10 хувь байсан байна. Үнэт цаас гаргагчийн нийт хөрөнгийн эргэц 1.05 нь салбарын дүн 0.79-өөс өндөр байгаа нь үнэт цаас гаргагчийн хөрөнгөө ашиглан борлуулалтын орлого олох чадвар өндөр байгааг илтгэж байна. Санхүүгийн хөшүүргийн хувьд үнэт цаас гаргагчийн санхүүгийн хөшүүрэг 2.17 салбарын хувьд 1.69 байна. Энэ үзүүлэлт нь үнэт цаас гаргагч нь салбарын дунджаасаа өндөр нөөц сантай байгааг илтгэж байна.

2016 онд Ард Даатгал ХХК-ийн эзэмшигчдийн өмчийн өгөөж /ROE/ 10.71 хувь гарсан үзүүлэлт нь салбарын 8.45 хувийн эзэмшигчдийн өмчийн өгөөжөөс өндөр байгаа юм. Энэ нь санхүүгийн хөшүүрэг өндөр байснаас ихээхэн хамаарсан ба салбарын дундаж санхүүгийн хөшүүрэг 1.53 байхад үнэт цаас гаргагчийн санхүүгийн хөшүүрэг 2.27 байсан байна. Цэвэр ашгийн маржин 6.01 хувь нь салбараас бага, нийт хөрөнгийн эргэц 0.78 гарсан нь салбартай ойролцоо байна.

2017 онд үнэт цаас гаргагчийн эздийн өмчийн өгөөж /ROE/ 23.7 хувь байсан бол даатгалын зах зээлийн эздийн өмчийн өгөөж /ROE/ 7.9 хувь байсан байна. Үнэт цаас гаргагчийн ашигт ажиллагаа нь тун ихээхэн нөлөөлсөн ба салбарын хэмжээнд цэвэр ашгийн маржин 0.2 хувь байсан бол үнэт цаас гаргагч нь 10.9 хувийн цэвэр ашгийн маржинтай ажилласан

МХБ-ийн гишүүн Андеррайтер Брокер дилер «БИДИСЕК» ХХК

СЗХ 2018.08.29 өдөр БҮРТГЭВ № 01
0000049

байна. Мөн даатгалын зах зээлийн нийт хөрөнгийн эргэц 0.79 байсан бол үнэт цаас гаргагчийн эргэц 0.97 байсан байна. Энэ нь үнэт цаас гаргагч нь хөрөнгөө илүү үр өгөөжтэй ашигласныг илэрхийлж байна. Үнэт цаас гаргагчийн санхүүгийн хөшүүрэг 2.24 байсан бол зах зээлийн харьцаа 1.63 байна. Даатгалын зах зээлийн нэгэн онцлог нь хөшүүрэг буюу даатгалын компанийн өр төлбөрийн томоохон хувийг нөөцийн сан эзэлдгээрээ онцлог юм. Үнэт цаас гаргагчийн санхүүгийн хөшүүрэг өндөр байгаа нь компанийн нөөц сан зах зээлийн дунджаас өндөр байгааг харуулж байна.

Дупонт шинжилгээний задаргаанаас нэгтгэн үзэхэд үнэт цаас гаргагчийн эзэмшигчдийн өмчийн өгөөж /ROE/ нь салбарын хэмжээнээс өндөр байна. Үүнд үнэт цаас гаргагчийн ашигт ажиллагаа болон хөрөнгийн үр өгөөж нь нөлөөлжээ.

Нийт хөрөнгийн өгөөжийн хувьд 2015 онд үнэт цаас гаргагч нь алдагдалтай ажилласантай холбоотой уг харьцаа нь сөрөг утгатай гарсан бол салбарын хэмжээнд 3.22 хувьтай байсан байна. 2016 онд үнэт цаас гаргагчийн ашигт ажиллагаа өмнөх оноос сайжирч салбарын нийт хөрөнгийн өгөөжтэй ойролцоо буюу 4.71 хувь гарсан байна. 2017 онд үнэт цаас гаргагчийн нийт хөрөнгийн өгөөж ойролцоогоор 2 дахин их буюу 10.57 хувьтай гарсан нь үнэт цаас гаргагчийн ашигт ажиллагаа сайжирсныг илтгэж байна.

## 1.6. Үнэт цаас гаргагчийн хувь нийлүүлсэн хөрөнгө

Ард Даатгал ХХК-ийн нийт зарласан болон гаргасан хувьцаа нь нэг бүр нь 200 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 17,500,000 ширхэг энгийн хувьцаанаас бүрдэх 3,500,000,000 (гурван тэрбум таван зуун сая) төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй.

Ард Даатгал ХХК нь Монголын Хөрөнгийн биржид бүртгэлгүй бөгөөд анх удаагаа хувьцаагаа бүртгүүлж, олон нийтэд санал болгох гэж байгаа болно.

*Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн өөрчлөлт:*

- 2009 онд Иргэн Б.Мөнхөөгөөс иргэн Д.Чулуунцэцэгт Ард Даатгал ХХК-ийн нийт хувьцааны 20 хувийг №09/030/01 тоот Хувьцаа шилжүүлэх, худалдах, худалдан авах гэрээний үндсэн дээр шилжүүлснээр Ард Даатгал ХХК-ийн дүрмийн сангийн хэмжээ 500 сая төгрөг болж өөрчлөгдсөн байна.
- 2010 онд Ард Даатгал ХХК-ийн дүрмийн сангийн хэмжээг компанийн хувь нийлүүлэгч Ц.Тогтохбаяр – 193 сая төгрөгөөр, Витингтон Инвестментс /Wittington Investments/ ХХК – 166.5 сая төгрөгөөр, Д.Чулуунцэцэг – 100 сая төгрөгөөр, Б.Мөнхөө – 10.5 сая төгрөгөөр, Н.Эрдэнэтулга – 30 сая төгрөгөөр нийт 500 сая

ARD INSURANCE COMPANY АРД ДААТГАЛ ХХК УЛААНБААТАР ХОТ
УЛААНБААТАР ХОТ МХБ-ийн гишүүн Андеррайтер Брокер, дилерийн "БЛАНСЕК" ҮЦК ХХК
2018 05 11

СЗХ 2018.08.29 БҮРТГЭВ № 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ 0000050 БҮРТГЭВ 01

төгрөгөөр нэмэгдүүлж, компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 1.0 тэрбум төгрөг болсон.

- 2013 онд Ард Даатгал ХХК-ийн дүрмийн сангийн хэмжээг тус компанийн 2012 оны хуримтлагдсан ашгаас 750 сая төгрөгөөр нэмэгдүүлж компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 2.75 тэрбум төгрөг болсон байна.
- 2014 онд Ард Даатгал ХХК-ийн дүрмийн сангийн хэмжээг тус компанийн 2013 оны хуримтлагдсан ашгаас хувьцаа эзэмшигчдэд хуваарилсан ногдол ашгийн мөнгөн хөрөнгө болох нийт 750 сая төгрөгөөр нэмэгдүүлж компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг 3.5 тэрбум төгрөг болгосон.

*Сүүлийн 3 жилийн хувь нийлүүлсэн хөрөнгийн өөрчлөлт:*

*Хүснэгт 7. Хувь нийлүүлсэн хөрөнгийн өөрчлөлт*

| *Хувьцаа эзэмшигчийн нэр* | *2017* | | *2016* | | *2015* | |
|---|---|---|---|---|---|---|
| | *Нийт (мянган.төг)* | *Хувь* | *Нийт (мянган.төг)* | *Хувь* | *Нийт (мянган.төг)* | *Хувь* |
| *Ард Санхүүгийн Нэгдэл ХК* | *3,335,850.0* | *95.31* | *2,905,988.0* | *83.0* | *1,935,885.0* | *55.31* |
| *Блюпланет ХХК* | | | *359,512.0* | *10.3* | *944,566.0* | *26.99* |
| *Энержи Интернешнл Капитал ХХК* | *164,150.0* | *4.69* | *164,150.0* | *4.7* | *164,150.0* | *4.69* |
| *Д.Чулуунцэцэг* | - | - | - | - | *385,049.0* | *11.00* |
| *Хөрөнгө оруулагч үндэстэн ХК* | - | - | *70,350.0* | *2.0* | - | - |
| *Н.Эрдэнэтулга* | - | - | - | - | *70,350.0* | *2.01* |
| *Нийт* | *3,500,000.0* | *100.0* | *3,500,000.0* | *100.0* | *3,500,000* | *100.0* |

Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2016 оны 5 сарын 25-ны өдрийн 16/01 тоот тогтоолоор компанийн хувьцаа эзэмшигч Блью Планет ХХК-ийн эзэмшлийн хувьцаанаас 16.72 хувь буюу 249,490 ширхэг хувьцааг, хувьцаа эзэмшигч Д.Чулуунцэцэгийн эзэмшлийн 11 хувь буюу нийт 164,200 ширхэг хувьцааг хувьцаа эзэмшигч Ард Санхүүгийн Нэгдэл ХК-д, хувьцаа эзэмшигч Н.Эрдэнэтулгын эзэмшлийн 2.01 хувь буюу 30,000 ширхэг хувьцааг Хөрөнгө Оруулагч Үндэстэн ХК-д тус тус хувьцаа худалдах худалдан авах гэрээний дагуу шилжүүлсэн байна. Улмаар СЗХ-ны 2016 оны 10 сарын 18-ны өдрийн 270 тоот тогтоолоор холбогдох өөрчлөлт оруулахыг зөвшөөрсөн байна.

2017 оны байдлаар Блюпланет ХХК болон Хөрөнгө Оруулагч Үндэстэн ХК-уудын эзэмших хувийг Ард Санхүүгийн Нэгдэл ХК өөрийн болгож авснаар эзэмшиж буй хувь хэмжээгээ 83 хувиас 95 хувь болгож өсгөсөн.

ARD INSURANCE COMPANY АРД ДААТГАЛ ХХК УЛААНБААТАР ХОТ
УЛААНБААТАР ХОТ МХБ-ийн гишүүн Андеррайтер Брокер, дилерийн "БИДИ СЕК" ҮЦК ХК 1115205447 2052482
2018-05-11

2018 оны 04 сарын 20-ны өдөр Ард Даатгал ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын 04/18 тогтоолоор компанийн нэгж хувьцааг 11.73-т хуваан нэрлэсэн үнийг 200 төгрөг болгох, хувьцаа хуваасантай холбогдуулан гаргасан болон зарласан хувьцааны тоог 17.5 сая ширхэг болгож өөрчлөх, дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах зөвшөөрөл олгосон байна. Уг тогтоолын дагуу, компанийн нэгж энгийн хувьцааны нэрлэсэн үнэ 200 төгрөг, зарласан буюу гаргасан хувьцаа 17.5 сая ширхэг, нийт 3.5 тэрбум төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй байна.

Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 355 дугаар тогтоолоор "Ердийн даатгалын компанийн дүрмийн сангийн доод хэмжээ 5 тэрбум байна" гэж тогтоосон. Тогтоолыг 2016 оны 12 сарын 31-ний дотор биелүүлж ажиллахыг Ердийн даатгалын компаниудад үүрэг болгосон ч эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулан дүрмийн санг нэмэгдүүлэх хугацааг 2018 оны 6-р сарын 30-ны өдрийг хүртэл сунгасан.

Үнэт цаас гаргагч нь үнэт цаасаа эргүүлэн худалдаж аваагүй болно. Мөн үнэт цаас гаргагчийн санхүүгийн мэдээлэл нь үнэт цаасны танилцуулгын 1.9-д тусгагдсан ба хараат бус аудитын байгууллагын дүгнэлтийг хавсаргав.

*2018 оны 04 сарын ХЭХ-ын хувьцаа хуваах тухай 04/18 тоот тогтоолын дэлгэрэнгүйг хавсралтаас үзнэ үү.*

## 1.7. Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчид

Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчид нь сүүлийн байдлаар дараах байдалтай байна:

*Хүснэгт 8. Ард Даатгал ХХК-ийн хувьцаа эзэмшигчид*

| Хувьцаа эзэмшигчийн нэр | РД | Хувьцааны тоо, хувь эзэмшил | Үйл ажиллагааны чиглэл | Хаяг |
|---|---|---|---|---|
| Ард Санхүүгийн Нэгдэл ХК | 5024145 | 16,679,250 ширхэг, 95.31% | - Бизнесийн зөвлөгөө<br>- Хөрөнгө оруулалт | СБД, 8-р хороо, Алтангэрэлийн гудамж, City центр, 403 |
| "Энержи интернэшнл капитал" ХХК | 5790263 | 820,750 ширхэг, 4.69% | - Бизнесийн зөвлөгөө өгөх<br>- Гадаад худалдаа<br>- Барьцаалан зээлдүүлэх үйлчилгээ | СБД, 7-р хороо, 11 хороолол, Бээжин, 40-41 |

СЭХ 2018.08.29 өдөр БҮРТГЭВ № 01

0000052 MONGOLIAN STOCK EXCHANGE БҮРТГЭВ

## Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн танилцуулга

| | |
|---|---|
| Компанийн нэр: | Ард Санхүүгийн Нэгдэл ХК |
| Улсын бүртгэлийн дугаар: | 9010001132 |
| Регистрийн дугаар: | 5024145 |
| Үйл ажиллагааны чиглэл: | - Бизнесийн зөвлөгөө /8299/<br>- Хөрөнгө оруулалт /6499/ |
| Хаяг: | Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Ерөнхий сайд Амарын гудамж, Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн байр, хоёр давхарт |
| Утас: | 318185, 99177390 |

*Ард Санхүүгийн Нэгдэл ХК нь санхүүгийн салбарт үйл ажиллагаа явуулж буй манлай компаниудад хөрөнгө оруулалт хийж, зах зээл дэх байр суурь, өрсөлдөх чадвар болон үнэ цэнийг нь дээшлүүлэх замаар компанийн хувь нийлүүлэгчдийн өгөөжийг өсгөх зорилт тавин ажиллаж байгаа үндэсний санхүүгийн холдинг компани юм.*

Ард Санхүүгийн Нэгдэл ХК нь анх 2005 оны 9 сард Хас Банкны ажиллагсдын санаачлагаар "Employee Investment Trust" буюу "ИАйТи" ХХК нэртэйгээр байгуулагдсан бөгөөд ажиллагсад болон удирдлага банкныхаа бодлогод нэгдмэл байр суурьнаас оролцох үүднээс банкны нийт ажиллагсдын хувьцааг төвлөрүүлж, Монголын анхдагч институционал хөрөнгө оруулагчийн үндэс суурийг тавьсан.

Үүсгэн байгуулагдах үедээ нийт 1.2 сая төгрөгийн өмч бүхий дүрмийн сантай, 10 хувьцаа эзэмшигчтэй байсан бол 2017 оны жилийн эцсийн байдлаар 3000 орчим хувьцаа эзэмшигчтэй, 35.6 тэрбум төгрөгийн хөрөнгөтэй болж өргөжсөн байна.

Гол хувь нийлүүлэгчид шинэ стратегийн зорилгоо тодорхойлж, арилжааны банк, брокер дилер, хөрөнгө оруулалтын зөвлөх, хөрөнгө оруулалтын сан, даатгал болон бусад санхүүгийн үйлчилгээг цогцоор нь үзүүлэх компаниудын нэгдэл болж, Ард Санхүүгийн Нэгдэл нэрийн дор үйл ажиллагаагаа явуулах шийдвэр гаргажээ. 2015 онд Ард Санхүүгийн Нэгдэл ХХК нь хаалттай хувьцаат компани болж өөрчлөгдсөн. Одоогийн байдлаар тус компани 7 охин компани, 3 хараат компани, 3 компанийн хувь эзэмшигч гэсэн хөрөнгө оруулалтын бүтэцтэй байна.

2018-05-11

*Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн хувьцаа эзэмшигчид*

ARD INSURANCE COMPANY АРД ДААТГАЛ ХХК УЛААНБААТАР ХОТ

УЛААНБААТАР ХОТ МХБ-ийн гишүүн Андеррайтер Брокер, дилерийн "БИДИСЕК" ХХК 1115205447

Компанийн 5-аас дээш хувийг эзэмшдэг хувьцаа эзэмшигчид буюу нөлөө бүхий хувьцаа эзэмшигчид 2017 оны 12 сарын 31-ний байдлаар дараах байдалтай байна:

*Хүснэгт 9. Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн хувьцаа эзэмшигчид*

| Хувьцаа эзэмшигчийн нэр | Эзэмшиж буй хувьцааны тоо | Эзэмшиж буй хувь |
|---|---|---|
| Ард Секьюритиз ҮЦК ХХК | 3,286,567 | 19.11% |
| Батхишиг | 1,689,415 | 9.83% |
| Луна Энд Луна ХХК | 1,333,154 | 7.75% |
| Bruno Raschle | 1,317,337 | 7.66% |
| Венчурс Ван | 1,316,103 | 7.65% |
| Ч.Ганхуяг | 1,145,400 | 6.66% |
| Жинст Увс ХК | 1,020,998 | 5.94% |

*Эх сурвалж: Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн аудитын тайлан*

КТХ-ийн 6.9-д хараат болон охин компани нь толгой компанийн хувьцааг эзэмшиж болно гэж заасны дагуу АСН-ийн охин болон хараат компаниуд түүний хувьцааг эзэмших нь хууль ёсны дагуу байна.

*Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн хараат, охин, болон хувь эзэмшдэг компаниуд*

*Схем 4. АСН-ийн хөрөнгө оруулсан компаниуд*

АРД ДААТГАЛ
Ердийн даатгал
95.31%

АРД МЕНЕЖМЕНТ
Хөрөнгө оруулалтын менежмент
100%

АРД АКТИВ
Хадгаламж зээлийн хоршоо
9.7%

АРД СЕКЮРИТИЗ
Үнэт цаасны компани
100%

ЖИНСТ УВС + ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ ҮНДЭСТЭН
9.55%

ТЕХНИК ТЕХНОЛОГИЙН ДЭЭД СУРГУУЛЬ
12%

АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ

НОМЫН ХИШИГ
Хэвлэлийн газар
20%

АРД КРЕДИТ
ББСБ
80.7%

КРИПТО ҮНДЭСТЭН
Хөрөнгө оруулалт
100%

АРД ЛАЙФ
Хувийн тэтгэврийн сан
100%

ТЭНГЭР СИСТЕМС
Мэдээллийн технологи
100%

МОНГОЛ ШУУДАН
Шуудангийн цогц үйлчилгээ
29.16%

*Хүснэгт 10. АСН-ийн ТУЗ-ийн гишүүд*

| Ердийн гишүүд | Хараат бус гишүүд |
|---|---|
| Н.Мөнхнасан (Монполимет ХХК) | П.Батбаяр |
| Ж.Оюунгэрэл (Луна луна ХХК) | Л.Соронзонболд |
| О.Одбаяр (Мон-Интернэйшнл ХХК) | |
| Ч.Ганхуяг (Ард Санхүүгийн Нэгдэл ХК) | |
| Х.Батхишиг (Хишиг Арвин Индустриал ХХК) | |
| Энтони Хоброу (ВенчурсУан Биви) | |
| Бруно Рашле (Адвек) | |

*Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, дүрэм, холбоотой этгээдүүдийн улсын бүртгэлийн гэрчилгээ, дүрэм, АСН-ийн ҮЦТХТ дахь дансны үлдэгдэл, АСН нь Ард Актив ХЗХ-нд хувь нийлүүлсэн талаар дэлгэрэнгүйг хавсралтаас үзнэ үү.*

## 1.8. Үнэт цаас гаргагчийн бүтэц зохион байгуулалт, эрх бүхий албан тушаалтны мэдээлэл

Бүтэц зохион байгуулалт

Ард Даатгал ХХК нь 1994 онд байгуулагдсан цагаасаа хойш жил болгон шинэ ажлын байр бий болгон, ажиллагсдын нийгмийн даатгалын шимтгэлийг бүрэн төлж, тодорхой хэмжээгээр хувь нэмрээ оруулсаар ирсэн. Тус компанийн хувьд одоогийн байдлаар нийт 100 орчим ажилтан, албан хаагчтайгаар үйл ажиллагаагаа явуулж байна. 2017 оны 5 сарын 18-ны өдөр гүйцэтгэх захирлын тушаалаар компанийн бүтцийг баталжээ.

*Схем 5. Ард Даатгал ХХК-ийн бүтэц зохион байгуулалт*



СЗХ 2018 он 08 сар 29 өдөр БҮРТГЭВ № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ 0000055 БҮРТГЭВ 01

*Ард Даатгал ХХК-ийн бүтэц зохион байгуулалт, холбогдох тогтоол, ХК-ийн дүрмийн төслийг хавсралтаас үзнэ үү.*

## Хувьцаа эзэмшигчдийн хурал

Компанийн дүрмийн 8.1, 8.2, 8.3-д тусгагдсаны дагуу компанийн эрх барих дээд байгууллага нь Хувьцаа эзэмшигчдийн хурал (ХЭХ) байна. Хувьцаа эзэмшигчдийн хурал ээлжит ба ээлжит бус байна. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг Компанийн санхүүгийн жил дууссанаас хойш 3 сарын дотор зарлан хуралдуулна.

Үнэт цаас гаргагчийн дүрмийн 8.5-д зааснаар ээлжит хурлыг хугацаанд нь зарлаагүй тохиолдолд аль нэг хувьцаа эзэмшигч хурлыг зарлан хуралдуулах эрхтэй.

Харин компанийн дүрмийн 8.6-д зааснаар ээлжит бус хурал нь аль нэг талын хүсэлтээр эсхүл хувьцаа эзэмшигчийн хувьд хүндэтгэн үзэх зайлшгүй шалтгаанаар яаралтай хувьцаа шилжүүлэх болон бусад чухал асуудлын талаар хэлэлцэхээр талуудын тохиролцоноор хэдийд ч хуралдаж болно.

## Төлөөлөн удирдах зөвлөл

2018 оны 4 сарын 20-ний өдрийн "Ард Даатгал" ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын 04/18 тоот тогтоолын 1 дүгээр хавсралтаар "Ард Даатгал" ХХК-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.2-т ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг 9 гишүүнтэй байхаар нэмэлт өөрчлөлтийг оруулсан.

Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт Компанийн эрх барих дээд байгууллага нь төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ) байна. Компанийн дүрэмд заасны дагуу ТУЗ нь 9 (ес) гишүүнээс бүрдэх бөгөөд 2-оос доошгүй хараат бус гишүүнтэй байна.

Компанийн нийт хувьцааны 10-аас дээш хувийн хувьцаа эзэмшигч нь ТУЗ-д нэг суудал авах эрхтэй байна. Бусад гишүүдийг хувьцаа эзэмшигчдийн хурлаас сонгох бөгөөд хамгийн олон санал авсан хүнийг сонгоно. ТУЗ нь Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлд заасан эрхийг эдэлж, үүргийг хүлээсэн байна.

ТУЗ нь улиралд нэг удаа хуралдах бөгөөд ТУЗ-өөс гарах бүхий л шийдвэрүүд нь гишүүдийн ердийн олонхийн саналаар батлагдах бөгөөд Тогтоол хэлбэртэй байна.

## Компанийн ТУЗ-ийн гишүүдийн талаарх мэдээлэл:

*Хүснэгт 11. Ард Даатгал ХХК-ийн ТУЗ-ийн гишүүд*

ARD INSURANCE COMPANY АРД ДААТГАЛ ХХК ТНЗ80 2062089 УЛААНБААТАР ХОТ

УЛААНБААТАР ХОТ МХБ-ийн гишүүн Андеррайтер Брокер, дилерийн "БИДИСЕК" ҮЦК ХК 1115205447 2052482

СЗХ 2018.08.29 өдөр БҮРТГЭВ № 1
0000 56
2018 05 11

**Ч.Ганхуяг /ТУЗ-ийн дарга/**

Боловсрол

1993-1997 онд Унгар улсын Эдийн засгийн их сургуулийг тус тус төгсөж, 2002-2005 оны хооронд АНУ-д мэргэжил дээшлүүлэх, удирдах ажилтны манлайллыг дээшлүүлэх чиглэлээр тусгай дамжаануудад суралцсан. 2010 онд АНУ-ын Харвардын Кеннэдийн их сургуулийн Дэлхийн манлайлал, Олон нийтийн бодлого чиглэлээр төгссөн.

Ажлын туршлага

1998-2009 онд “ХасБанк”-ны Гүйцэтгэх захирал, 2009-2010 онд “Тэнгэр Санхүүгийн Нэгдэл” ХХК-ийн Гүйцэтгэх захирал, 2010-2012 онд Сангийн Яамны Дэд сайд, 2012-2014 онд “И Ай Ти” ХХК-ний ТУЗ-ийн даргаар тус тус ажиллаж байсан ба 2014 оноос хойш Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн Гүйцэтгэх захирлаар ажиллаж байна.

Компанийн засаглалын гэрчилгээний № - КТХ-ын 75.8-д заасны дагуу гэрчилгээ авсан. №0130277

ШШГЕГ-ын болон зээлийн мэдээллийн сангийн тодорхойлолтыг хавсаргав.

**Г.Цогбадрах /ТУЗ-ийн ердийн гишүүн/**

Боловсрол

Нийслэлийн 33-р дунд сургууль, МУИС-ийн Эдийн засгийн сургууль, АНУ-ын Үндэсний их сургуулийг тус тус төгсгөсөн.

Ажлын туршлага

2000-2001 онд Хөгжлийн Алтан Сан ББСБ-д салбарын захирал, 2001-2008 онд Хас Банкны Дотоод Аудит, Салбарын Удирдлага, Санхүү Бүртгэл, Хөрөнгө зохицуулалтын газрын захирал, 2010-2011 онд Тэнгэр Санхүүгийн Нэгдэлд Хөрөнгө оруулалт эрхэлсэн захирал, 2011-2014 онд Тэнгэр Даатгал ХХК-ийн Гүйцэтгэх захирал, 2005-2014 онуудад Ард Санхүүгийн Нэгдэлд ТУЗ-ийн гишүүн, 2017 оноос “Ард Даатгал” ХХК-д Гүйцэтгэх захирлаар ажиллаж байна.

КТХ-ын 75.8-д заасны дагуу 2012 оны 06 сарын 28-ны өдөр гэрчилгээ авсан.

ШШГЕГ-ын болон зээлийн мэдээллийн сангийн тодорхойлолтыг хавсаргав.

**Б. Золбоо /ТУЗ-ийн ердийн гишүүн/**

Боловсрол

2012-2013 онд СЭЗИС-ийг олон улсын нягтлан бодогч мэргэжлээр, 2013-2016 онд АНУ-ын Plathsburgh-ийн их сургуулийг эдийн засагч мэргэжлээр тус тус төгссөн.

АРД ДААТГАЛ ХХК УЛААНБААТАР ХОТ
УЛААНБААТАР ХОТ МХБ-ийн гишүүн Андеррайтер Брокер диллер "БИДИ СЕК" ҮЦК ХК

СЗХ
2018.08.29 өдөр
БҮРТГЭВ
№ 1

MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮР-0000 57
...... он .... сар .... өдөр



**Ажлын туршлага**

ARD МЕНЕЖМЕНТ КОМПАНИ

Ард Менежмент нь 2011 оны 09 сарын 6-ны өдөр үүсгэн байгуулагдсан бөгөөд 2014 онд тус компанийг Ард Санхүүгийн Нэгдэл ХХК худалдан авч өөрийн хөрөнгө оруулалтын багцдаа

СЗХ
2018.08.29 өдөр
БҮРТГЭВ
№ 01

0000081
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ 01

оруулсан юм. 2016 оны 2 сарын 24-ний өдөр Санхүүгийн Зохицуулах Хорооны шийдвэрээр "Ард Менежмент" ХХК тусгай зөвшөөрлөө авснаар хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаагаа эхлүүлсэн.

Монгол улсад хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсан 14 компанийн нэг. Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн 100 хувийн эзэмшлийн охин компанид хамаарах бөгөөд 100 сая төгрөгийн өөрийн хөрөнгөтэй байна.

## 1.12. Үнэт цаас гаргагчийн компанийн засаглалын журмуудыг боловсруулж баталсан тухай

КТХ-ийн 76 дугаар зүйлийн 76.1.13-д зааснаар ТУЗ нь гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны болон компанийн засаглалын дотоод журмыг батлах бүрэн эрхтэй.

Ард Даатгал ХХК-ийн 2018 оны 3 сарын 30-ны өдрийн ТУЗ-ийн хурлын 18/16 тоот тогтоолоор компанийн засаглалын журмуудыг баталсан байна. Үүнд:

- Гүйцэтгэх захирлын үйл ажиллагааны журам
- Хувьцаа эзэмшигчдийн хурал зарлан хуралдуулах журам
- Хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам
- Дотоод хяналтын журам
- Төлөөлөн удирдах зөвлөлийн Нэр дэвшүүлэх,цалин урамшууллын хорооны журам
- Төлөөлөн удирдах зөвлөлийн Нарийн бичгийн даргын үйл ажиллагааны журам
- Олон нийтэд мэдээлэл хүргэх үйл ажиллагааны журам
- Ногдол ашгийн бодлого

## 1.13. Компанийн тухай хуулийн 75,79,81 дүгээр зүйлүүдийг дагаж мөрдөх талаар

*Төлөөлөн удирдах зөвлөл:*

Үнэт цаас гаргагч нь компанийн дүрмийн 9 дэх хэсэгт зааснаар КТХ-ийн 75 дүгээр зүйлийг дагаж мөрддөг болно. Үүнд:

- Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих дээд байгууллага нь ТУЗ байна.
- ТУЗ нь 9 гишүүнээс бүрдэх бөгөөд хараат бус 4 гишүүнтэй. Ердийн гишүүдэд Ч.Ганхуяг, Г.Цогбадрах, А.Хоброу, Ч.Ганзориг, Б.Золбоо нар, хараат бус гишүүдэд О.Одбаяр, Б.Гантулга, Б.Болорчимэг, З.Ариун нар багтана.

ARD INSURANCE COMPANY
АРД ДААТГАЛ ХХК
УЛААНБААТАР ХОТ

УЛААНБААТАР ХОТ
МХБ-ийн гишүүн Андеррайтер Брокер, Дилерийн "БИДСЕК" ҮЦК ХХК

2018-05-11

СЗХ
2018 08. 29
БҮРТГЭВ
№ 01

0000082
БҮРТГЭВ
01

- Дээрх ТУЗ-ийн 8 гишүүд нь КТХ-ийн 75.8-д заасны дагуу компанийн засаглалын чиглэлээр сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан. Засаглалын гэрчилгээг хавсаргав. Харин хараат бус гишүүн Б.Болорчимэг-ийн хувьд шинээр томилогдсон учир компанийн засаглалын сургалтад бүртгүүлсэн боловч хараахан засаглалын гэрчилгээ авч амжаагүй байна.

*Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн:*

Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн бүрэлдэхүүний 4 хараат бус гишүүд нь КТХ-ийн 79-р зүйлд зааснаар

- өөрөө, эсхүл нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран компанийн энгийн хувьцааны таваас дээш хувийг эзэмшдэггүй;
- өөрөө, эсхүл нэгдмэл сонирхолтой этгээд нь компанийн болон компани оролцогч нь болж байгаа компанийн нэгдлийн бусад оролцогчид ажил, албан тушаал эрхэлдэггүй, эсхүл сүүлийн 3 жилийн хугацаанд ажил, албан тушаал эрхэлж байгаагүй;
- төрийн үйлчилгээнийхнээс бусад төрийн алба хашдаггүй;
- компанитай бизнесийн аливаа холбоогүй учир уг хуулийн зүйл заалтыг дагаж мөрддөгт тооцогдож байна.

*Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороод*

Ард Даатгал ХХК нь одоогийн байдлаар ТУЗ-ийн дэргэдэх Аудит, Засаглал, Хөрөнгө оруулалт эрсдэлийн хороодтойгоор байнгын үйл ажиллаа явуулж байна.
Мөн үнэт цаас гаргагч нь 2018 оны 03 сарын 30-ний өдрийн ТУЗ-ийн хурлын шийдвэрийг үндэслэн компанийн засаглалын журмуудыг баталсан ба үүнд ТУЗ-ийн нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооны журам мөн хамаарна.

## 1.14. Компанийн эрх бүхий байгууллагаар батлуулсан ногдол ашгийн бодлого

КТХ-ийн 46.1, Компанийн дүрмийн 13.1-д зааснаар ногдол ашиг хуваарилах эсэхийг зөвхөн ТУЗ-ийн шийдвэрт үндэслэн шийдвэрлэдэг. Үнэт цаас гаргагч нь сүүлийн 2 жил дараалан ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн байна.

Өнгөрсөн хугацаанд ногдол ашиг төлсөн байдал:

- ТУЗ-ийн 2017 оны 4 сарын 19-ний өдрийн №1 тоот тогтоолыг үндэслэн 2016 оны цэвэр ашгийн 30 хувьтай тэнцэх дүнгээр буюу нийт 129,340.3 мянган төгрөгийн мөнгөөрх ногдол ашиг зарлаж, олгосон.

ARD INSURANCE COMPANY АРД ДААТГАЛ ХХК УЛААНБААТАР ХОТ

УЛААНБААТАР ХОТ МХБ-ийн гишүүн Андеррайтер Брокер, Дилерийн "БИДСЕК" ҮЦК ХХК

- ТУЗ-ийн 2018 оны 3 сарын 30-ны өдрийн шийдвэрээр компанийн 2017 оны 1.12 тэрбум төгрөгийн цэвэр ашгаас 50 хувийг нь буюу 562 сая төгрөгийг хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хэлбэрээр хуваарилахаар шийдвэрлэсэн.

Ард Даатгал ХХК-ийн ТУЗ-ийн 2018 оны 3 сарын 30-ны өдрийн 18/16 тоот тогтоолоор "Ногдол ашгийн бодлого"-ыг хавсралтаар баталсан ба уг ногдол ашгийн бодлогыг үнэт цаас гаргагч хувьцаат компани болсны дараагаар хувьцаа эзэмшигчдийн хурлаар батална.

Ногдол ашгийн бодлогын хураангуй:

1) КТХ-ийн 47.1-д заасны дагуу ногдол ашиг төлсний дараа компани төлбөрийн чадвартай байх.
2) Ногдол ашиг төлсний дараа компанийн өөрийн хөрөнгө нь хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, татан буулгалтын үнэ, хуульд заасан өөрийн хөрөнгийн доод хэмжээний нийлбэрээс илүү байх.
3) Компани эргүүлэн авах үүрэгтэй үнэт цаасаа бүгдийг нь эргүүлэн авсан байх.
4) Ногдол ашиг төлсний дараа компанийн өөрийн хөрөнгө нь 25-аас дээш хувиар багассан тохиолдолд ногдол ашгаа төлж дууссанаас хойш ажлын 10 хоногийн дотор зээлдүүлэгчиддээ өөрийн хөрөнгийн үлдэгдлийг бичгээр мэдэгдэх үүргийг гүйцэтгэх удирдлага хэрэгжүүлнэ.
5) Компанийн санхүүгийн байдлаас шалтгаалан жилийн санхүүгийн тайланд тусгагдсан цэвэр ашгаас ногдол ашигт хуваарилна. Хуваарилах дүн нь компанийн тухайн жилийн цэвэр ашгийн 30 хувиас 50 хувь байна.
6) Бүртгэлийн өдрөөс ногдол ашиг төлөх хүртэлх хугацаанд өөрийн эзэмшлийн хувьцааг бусдад шилжүүлсэн тохиолдолд уг хувьцаанд ногдох ногдол ашгийг авах эрх нь хувьцаа эзэмшигчдэд үлдэнэ.
7) Хувьцаа эзэмшигчдэд төлбөл зохих ногдол ашгийн хэмжээг төлбөл зохих өр болгон нягтлан бодох бүртгэлд тусгаж, ногдол ашиг төлж эхэлсэн улирлын эцэст ногдол ашгаа аваагүй байгаа хувьцаа эзэмшигч бүрийн нэрээр өглөгийн бүртгэл тусгайлан бүртгэнэ.

## 1.15. Дунд хугацааны бизнес төлөвлөгөөний тойм

### 1.15.1. ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Даатгал нь даатгуулагчийн эрсдэлийг дахин хуваарилах, шилжүүлэх, санхүүгийн нөөцийн хуваарилалтыг оновчтой болгож, хөрөнгө оруулалтыг дэмжин эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх ба санхүүгийн тогтвортой байдлыг хангахад чухал ач холбогдолтой салбар юм.

2016 оны жилийн эцсийн байдлаар нэг хүнд ногдох даатгалын хураамжийн хэмжээ 36,700.0 төгрөг байгаа нь өмнөх оноос 1.4 хувиар буурсан байна. Салбарын бодит эдийн засагт үзүүлэх нөлөөллийг авч үзвэл, 2016 оны байдлаар даатгалын салбарын нийт актив ДНБ-ний 0.87 хувийг эзэлж байгаа нь өмнөх онтой харьцуулахад 27.5 хувиар буурсан үзүүлэлттэй. Тайлант хугацаанд салбарын нэвтрэлт буюу ДНБ-д эзлэх цэвэр хураамжийн орлого 0.48 хувь байгаа нь хөгжиж буй зах зээлтэй орнуудын дунджаас 5.8 дахин, дэлхийн дунджаас 13.5 дахин бага байна. (Эх сурвалж: OECD, Global insurance trends 2015)

2017 оны жилийн эцсийн байдлаар даатгалын салбарт Хорооноос олгосон тусгай зөвшөөрөлтэй ердийн даатгалын компани 15, урт хугацааны даатгалын компани 1, давхар даатгалын компани 1 , даатгалын зуучлагч компани 42, даатгалын хохирол үнэлэгч компани 29 болон даатгалын компанийн 239 салбар, 12 төлөөлөгчийн газар (2893 төлөөлөгч), даатгалын зуучлагч компанийн 209 салбар, даатгалын хохирол үнэлэгч компанийн 47 салбар, 6 төлөөлөгчийн газар тус тус үйл ажиллагаа явуулж байна.

*Нийт хөрөнгө*

*График 30. Даатгалын салбарын нийт хөрөнгө /тэрбум төг/*




Даатгалын компаниудын нийт хөрөнгийн хэмжээ 2017 оны жилийн эцсийн байдлаар 244.7 тэрбум төгрөг байгаа нь өмнөх оны мөн үеэс 36.3 тэрбум төгрөгөөр буюу 17.4 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Салбарын хэмжээнд нийт хөрөнгөнд эзлэх хувиар авч үзвэл, ердийн даатгалын компаниудын хөрөнгө 79.1 хувь, давхар даатгалын компани 17.7 хувь, урт хугацааны даатгалын компани 3.2 хувийг тус тус эзэлж байна.

СЗХ 2018 08. 29 БҮРТГЭВ № 01
0000085

Тайлант хугацаанд даатгалын компаниуд 1,015,275 иргэн, аж ахуйн нэгж байгууллагатай даатгалын гэрээ байгуулж нийт 144.3 тэрбум төгрөгийн хураамжийн орлого төвлөрүүлсэн байна. Уг хураамжийн орлогын 97.8 хувь буюу 141.2 тэрбум төгрөгийг ердийн даатгалын компаниуд, 0.9 хувь буюу 1.3 тэрбум төгрөгийг урт хугацааны даатгалын компани, 1.3 хувь буюу 1.9 тэрбум төгрөгийг давхар даатгалын компаниуд төвлөрүүлжээ. Даатгалын нийт хураамжийн орлого өмнөх оноос 29.8 тэрбум төгрөгөөр өссөн ба 5 жилийн дундаж өсөлт 13.2 хувийн өсөлттэй байна.

*Хураамжийн орлого*

*График 31. Даатгалын салбарын нийт хураамжийн орлого, давхар даатгалын хураамж*




Салбарын хэмжээнд нийт хураамжийн орлогын өсөлт 2013 оноос эхлэн буурсаар 2016 онд дөнгөж 0.6 хувийн өсөлт үзүүлж байсан бол 2017 онд 26.1 хувь өссөн үзүүлэлттэй гарчээ.

Даатгалын нийт хураамжийн орлогын 71.8 хувь нь гэнэтийн осол эмчилгээний, хөрөнгийн, авто тээврийн хэрэгслийн, жолоочийн хариуцлагын даатгалын гэсэн 4 хэлбэрийн хураамжийн орлогоос бүрдсэн байна.

*Хүснэгт 25. Даатгалын салбарын хураамжийн орлогын бүтэц*

| № | Даатгалын бүтээгдэхүүн | ХУРААМЖИЙН ОРЛОГО | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | 2013 | 2014 | 2015 | 2016 | 2017 |
| 1 | Эрүүл мэнд, гэнэтийн ослын даатгал | 9,107.20 | 10,125.80 | 10,612.00 | 12,331.70 | 17,857.00 |
| 2 | Хөрөнгийн даатгал | 25,628.00 | 32,266.80 | 40,884.30 | 31,793.20 | 36,699.10 |
| 3 | Тээврийн хэрэгслийн даатгал | 16,332.80 | 18,277.60 | 15,676.40 | 14,481.90 | 18,547.90 |
| 4 | Ачаа тээврийн даатгал | 1,810.20 | 3,190.20 | 2,375.80 | 1,943.60 | 1,486.30 |
| 5 | Барилга угсралтын даатгал | 4,122.30 | 1,433.70 | 2,002.50 | 3,266.50 | 7,408.10 |
| 6 | Газар тариалангийн даатгал | | | | 13.7 | 42.8 |

УЛААНБААТАР ХОТ

СЭХ
2018 .08. 29 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
0000086
....... он .... сар .... өдөр



| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 7 | Мал амьтадын даатгал | 770.8 | 890.3 | 709.7 | 1,158.50 | 2,386.00 |
| 8 | Агаарын хөлгийн даатгал | 7,730.60 | 8,667.40 | 5,307.30 | 6,029.90 | 8,714.00 |
| 9 | Жолоочийн хариуцлагын даатгал | 15,525.60 | 20,513.10 | 23,317.00 | 28,254.40 | 30,882.40 |
| 10 | Хариуцлагын даатгал | 7,069.10 | 5,912.00 | 7,335.80 | 7,857.30 | 10,766.80 |
| 11 | Санхүүгийн даатгал | 2,576.80 | 3,259.50 | 3,197.30 | 3,232.60 | 3,189.00 |
| 12 | Зээлийн даатгал | 2,198.40 | 2,769.20 | 795.1 | 1,313.20 | 3,201.00 |
| **НИЙТ ХУРААМЖИЙН ОРЛОГО** | | **92,871.80** | **107,305.60** | **112,213.30** | **111,676.50** | **141,180.40** |

*Хүснэгт 26. Ердийн даатгалын компаниудын хураамжийн орлого*

| № | Компанийн нэр | ХУРААМЖИЙН ОРЛОГО | | | | Өөрчлөлт | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | 2016 | | 2017 | | 2016/2017 | |
| | | дүн | хувь | дүн | хувь | дүн | хувь |
| 1 | Бодь даатгал | 20,148.3 | 18.0% | 28,214.5 | 20.0% | 8,066.24 | 40.0% |
| 2 | Монгол даатгал | 24,724.8 | 22.1% | 24,788.6 | 17.6% | 63.80 | 0.3% |
| 3 | Мандал женерал даатгал | 13,092.8 | 11.7% | 22,533.1 | 16.0% | 9,440.26 | 72.1% |
| 4 | Миг даатгал | 11,307.8 | 10.1% | 13,908.3 | 9.9% | 2,600.53 | 23.0% |
| 5 | Тэнгэр даатгал | 9,004.4 | 8.1% | 12,175.2 | 8.6% | 3,170.79 | 35.2% |
| 6 | Ард Даатгал | 7,172.3 | 6.4% | 10,355.1 | 7.3% | **3,182.83** | **44.4%** |
| 7 | Практикал даатгал | 7,507.0 | 6.7% | 8,193.1 | 5.8% | 686.15 | 9.1% |
| 8 | Хаан даатгал | 4,412.4 | 4.0% | 4,678.2 | 3.3% | 265.77 | 6.0% |
| 9 | Номин даатгал | 4,296.2 | 3.8% | 4,645.6 | 3.3% | 349.38 | 8.1% |
| 10 | Соёмбо даатгал | 4,728.7 | 4.2% | 4,635.1 | 3.3% | (93.56) | -2.0% |
| 11 | Монре даатгал | 2,971.0 | 2.7% | 3,894.5 | 2.8% | 923.54 | 31.1% |
| 12 | Улаанбаатар хотын даатгал | 485.5 | 0.4% | 892.7 | 0.6% | 407.18 | 83.9% |
| 13 | Гэр даатгал | 419.3 | 0.4% | 876.4 | 0.6% | 457.08 | 109.0 % |
| 14 | Мөнх даатгал | 854.1 | 0.8% | 836.7 | 0.6% | (17.47) | -2.0% |
| 15 | Ган зам даатгал | 552.0 | 0.5% | 553.3 | 0.4% | 1.31 | 0.2% |
| **НИЙТ ХУРААМЖИЙН ОРЛОГО** | | **111,676. 5** | **100.0 %** | **141,180. 4** | **100.0 %** | **29,503.8 6** | **26.4%** |

*Нөхөн төлбөр*

*График 32. Даатгалын салбарын нөхөн төлбөр /тэрбум.төг/*

2018 08 -29- 1117

ARD INSURANCE COMPANY
АРД ДААТГАЛ ХХК
УЛААНБААТАР ХОТ

УЛААНБААТАР ХОТ
"БИДИСЕК" ҮЦК ХК




Тайлант хугацаанд даатгалын тохиолдлын улмаас нийт 61,234 даатгуулагчдад 44.3 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр олгожээ. Нөхөн төлбөрийн хэмжээ өмнөх оноос 32.8 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Даатгалын нөхөн төлбөрийг хэлбэрээр нь авч үзвэл жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын 29,728 даатгуулагчдад нийт 15.5 тэрбум төгрөг, авто тээврийн хэрэгслийн даатгалын 12,550 даатгуулагчдад 8.5 тэрбум төгрөгийн нөхөн төлбөрийг тус тус олгосон нь хамгийн өндөр үзүүлэлтүүд байв. Даатгалын хохирлын харьцаа тайлант хугацаанд салбарын хэмжээнд нийт хураамжийн орлоготой харьцуулахад 31.4 хувьтай, цэвэр хураамжийн орлоготой харьцуулахад 48.6 хувьтай байна.

*Хүснэгт 27. Ердийн даатгалын компаниудын нөхөн төлбөр*

| № | Компанийн нэр | НИЙТ НӨХӨН ТӨЛБӨР | | | | Өөрчлөлт | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | 2016 | | 2017 | | 2016/2017 | |
| | | дүн | хувь | дүн | хувь | дүн | хувь |
| 1 | Монгол даатгал | 6,703.5 | 20.1% | 8,562.9 | **19.3%** | 1,859.43 | 27.7% |
| 2 | Миг даатгал | 4,954.1 | 14.8% | 6,820.6 | **15.4%** | 1,866.54 | 37.7% |
| 3 | Тэнгэр даатгал | 2,385.6 | 7.1% | 4,847.0 | **10.9%** | 2,461.44 | 103.2% |
| 4 | Мандал женерал даатгал | 4,116.2 | 12.3% | 4,705.6 | **10.6%** | 589.45 | 14.3% |
| 5 | Бодь даатгал | 2,839.0 | 8.5% | 4,519.4 | **10.2%** | 1,680.41 | 59.2% |
| 6 | Ард Даатгал | 2,595.8 | 7.8% | 4,063.1 | 9.2% | **1,467.37** | **56.5%** |
| 7 | Практикал даатгал | 3,152.5 | 9.4% | 3,397.4 | **7.7%** | 244.87 | 7.8% |
| 8 | Монре даатгал | 1,547.3 | 4.6% | 2,062.5 | **4.7%** | 515.24 | 33.3% |
| 9 | Соёмбо даатгал | 2,214.9 | 6.6% | 1,835.6 | **4.1%** | (379.32) | -17.1% |
| 10 | Номин даатгал | 1,375.5 | 4.1% | 1,440.7 | **3.2%** | 65.20 | 4.7% |
| 11 | Хаан даатгал | 1,071.7 | 3.2% | 1,378.9 | **3.1%** | 307.19 | 28.7% |
| 12 | Гэр даатгал | 114.0 | 0.3% | 413.0 | **0.9%** | 298.96 | 262.1% |
| 13 | Улаанбаатар хотын даатгал | 158.7 | 0.5% | 145.0 | **0.3%** | (13.64) | -8.6% |
| 14 | Ган зам даатгал | 55.5 | 0.2% | 78.8 | **0.2%** | 23.36 | 42.1% |
| 15 | Мөнх даатгал | 104.3 | 0.3% | 62.4 | **0.1%** | (41.98) | -40.2% |
| **НИЙТ НӨХӨН ТӨЛБӨР** | | **33,388.5** | **100.0%** | **44,333.0** | **100.0%** | **10,944.52** | **32.8%** |

*Цэвэр ашиг*

*График 33. Даатгалын салбарын цэвэр ашиг /тэрбум.төг/*

СЗХ
2018 .08. 29 өдөр
БҮРТГЭВ
№ 01

0000088
БҮРТГЭВ 01






Тайлант хугацаанд даатгалын компаниудын цэвэр ашиг 13.2 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оноос 1.8 тэрбум төгрөгөөр өссөн байна. Үүнд урт хугацааны болон давхар даатгалын компанийн үзүүлэлт багтсан болно.

*График 34. Даатгалын салбарын хураамжийн орлого, нөхөн төлбөр, хохирол нөхөлтийн харьцаа*




2017 онд ердийн даатгалын 15 компани жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын үйл ажиллагаа эрхэлсэн ба жолоочийн хариуцлагын албан журмын даатгалаар нийт 30.4 тэрбум төгрөгийн даатгалын хураамжийн орлого төвлөрүүлсэн нь өмнөх оны мөн үеэс 2.6 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Даатгалын компаниуд гадаадын давхар даатгагчид нийт 37.2 тэрбум төгрөгийн давхар даатгалын хураамжийг төлсөн нь нийт хураамжийн 32.5 хувьтай тэнцэж, давхар даатгалын хураамж өмнөх оны мөн үеэс 9.9 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Даатгагч нарын ашигт ажиллагаанд гол нөлөөлөх харьцаануудыг тооцвол, салбарын хэмжээнд нийт хөрөнгийн өгөөж 35.4%, үндсэн үйл ажиллагааны зардлын харьцаа 49.5 хувь, хохирлын харьцаа 42.2 хувь, зардал ба хохирлын хосолсон харьцаа 91.7 хувьтай байна.

ARD INSURANCE COMPANY
АРД ДААТГАЛ ХХК
УЛААНБААТАР ХОТ

УЛААНБААТАР ХОТ
МХБ-ийн гишүүн Андеррайтер Брокер, дилерийн "БИДИСЕК" ҮЦК ХК

## 1.15.2. КОМПАНИЙН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

*График 35. Ард Даатгал ХХК-ийн хөрөнгийн бүтэц /сая.төг/*




2016 онд компанийн нийт актив 9,541.14 сая төгрөг байсан бол 2017 оны эцэст 11,726.64 сая төгрөгт хүрч 2,185.49 сая төгрөг буюу 23 хувиар өссөн байна.

*График 36. Ард Даатгал ХХК-ийн эх үүсвэрийн бүтэц /сая.төг/*




Нийт хураамжийн орлогын хувьд 2017 оны эцсээр 10,355.13 сая төгрөгт хүрсэн бөгөөд энэ нь өмнөх оноос 3,182.83 сая төгрөг буюу 44 хувиар өссөн үзүүлэлттэй байна. 2016 онд 2,595.76 сая төгрөгийн нөхөн төлбөр олгосон бол 2017 оны эцэст 4,063.12 сая төгрөгийн нөхөн төлбөр олгож өмнөх оноос 1,467.37 сая төгрөг буюу 57 хувиар өссөн байна.




*График 37. Ард Даатгал ХХК-ийн хураамж, нөхөн төлбөр /сая.төг/*

СЗХ 2018 .08. 29 өдөр БҮРТГЭВ № 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE БҮРТГЭВ 0000090 ...... он .... сар .... өдөр 01

## 1.15.3. БИЗНЕСИЙН ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ

### Гадаад орчны шинжилгээ

*УЛС ТӨР*

Улс төр судлаачид 2020 оны сонгууль хүртэл улс төр харьцангуй тогтвортой байна гэж үзэж байгаа хэдий ч АНУ-ын стратеги судалгааны хүрээлэн "Heritage Foundation"-н судалгаагаар манай улсын эдийн засгийн эрх чөлөөний үзүүлэлтийг байр ухраасан байна.

Тус хүрээлэн нь худалдааны бодлого, Засгийн газрын санхүүгийн бодлогын нөлөө, эдийн засаг дахь Засгийн газрын оролцоо, мөнгөний бодлого, капиталын урсгал ба гадаадын хөрөнгө оруулалт, банк санхүү, цалин хөлс, өмчийн эрх, зохицуулалт, албан бус зах зээл гэсэн арван шалгуур үзүүлэлт дээр үндэслэн дэлхийн улс орнуудыг жил бүр эдийн засгийн эрх чөлөөгөөр нь жагсаадаг. Манай улс 2015 онд 96 дугаарт, 2016 онд 100 дугаарт тус тус жагсаж байсан бол 2017 онд 186 улсаас 125 дугаарт жагссан үзүүлэлттэй байна.

*ЭДИЙН ЗАСАГ*

Дэлхийн эдийн засаг, таамаглал

Дэлхийн банкнаас гаргасан Зүүн Ази, Номхон далайн бүсийн 2017 оны аравдугаар сарын эдийн засгийн тоймд 2017 оны эдийн засгийн өсөлт өмнө төсөөлж байсантай харьцуулахад өндөр гарсан нь Хятадын эдийн засгийн өсөлт таамагласнаас өндөр буюу 6.7 хувьтай байгаагаас голлон шалтгаалжээ.

АНУ болон Евро бүс мөнгөний бодлогоо төсөөлж байснаас илүү хурдан чангаруулах магадлалтай байна.

Жижиг улс орнуудын эдийн засгийн ирээдүйн төлөв харилцан адилгүй байна. Монгол болон Фижи улсын эдийн засаг 2018 онд сайжрах төлөвтэй.

Монгол улсын макро эдийн засгийг тогтворжуулах хөтөлбөр нь уул уурхай, тээврийн салбарт гадаадын шууд хөрөнгө оруулалтыг дэмжиж байна.

Зүүн Ази, Номхон далайн бүсийн эдийн засаг тогтвортой байх буюу 2015 онд 6.5 хувь, 2016 онд 6.3 хувь, 2017 онд 6.4 хувь байсан ба 2018 онд 6.2 хувийн өсөлттэй байна гэж таамаглажээ. Аажмаар удааширч байгаа БНХАУ-ын эдийн засаг 2016 онд 6.7 хувь, 2017 онд 6.5 хувийн өсөлттэй байсан бол 2018 онд 6.9 хувь өсөхөөр таамаглагдсан. Хувийн хэрэглээг дэмжиж байгаа учраас хөдөлмөрийн зах зээл, орхийн орлого хүчтэй өссөөр байх

ARD INSURANCE COMPANY АРД ДААТГАЛ ХХК УЛААНБААТАР ХОТ 2062089
УЛААНБААТАР ХОТ МХБ-ийн гишүүн Андеррайтер Брокер, дилерийн "БДИСЕК" ҮЦК ХК 5205447 2057484
2018-05-11

СЗХ 2018.09.29 өдөр БҮРТГЭВ № 01

болно түүнчлэн үйлчилгээний салбарт барьж буй зөөлөн бодлогын улмаас үйлчилгээний салбарт хийж буй шилжилт цаашид үргэлжилнэ гэж үзсэн.

Монгол улсын эдийн засгийн нөхцөл байдал, таамаглал

Монгол Улс 2017 оны эхний 11 сард дэлхийн 161 улстай худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлт 9.6 тэрбум америк доллар, үүнээс экспорт 5.7 тэрбум америк доллар, импорт 3.9 тэрбум америк долларт хүрчээ.

*Зураг 1. Гадаад худалдааны тэнцэл*




Гадаад худалдааны тэнцэл 2016 оны эхний 11 сард 1.2 тэрбум америк долларын ашигтай гарч байсан бол 2017 оны эхний 11 сард өмнөх оны мөн үеэс 585.2 (48.9 хувь) сая америк доллараар нэмэгдэж, 1.8 тэрбум америк долларт хүрчээ.

*График 38. Инфляци /хувь/*




Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс улсын хэмжээнд 2017 оны 09 сараас 0.1 хувь, 2016 оны эцсээс 5.8 хувь, 2016 оны 10 сараас 6.5 хувиар тус тус өссөн байна.

## НИЙГМИЙН БАЙДАЛ

Эрүүл мэндийн салбар

Хотжилт, үйлдвэржилт, хүн амын төвлөрөл, гэмт хэргийн гаралт нэмэгдэж ажилгүйдэл, эдийн засгийн хямрал, орчны бохирдол, замын хөдөлгөөний нягтрал зэрэг олон хүчин зүйлээр иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдалд үзүүлэх сөрөг нөлөөлөл ихэсч байна.

Жилээс жилд эрүүл мэндийн байгууллага, эмнэлэг, түүнтэй холбоотой дэмжих салбарууд олширч байгаа нь хүн амын эрүүл мэндийн түвшин доогуур байгаатай холбоотой.

СЗХ 2018.08.29-ний өдөр БҮРТГЭВ № 01
0000092
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE БҮРТГЭВ 01

Тухайлбал, 2016 онд өмнөх оноос хувийн эмнэлэг 80 ширхэгээр, хувийн эмийн сан 74 ширхэгээр тус тус өссөн байна. Дээрх өсөлтөөс гадна хүн амын өсөлт жил бүр дунджаар 600,000-аар өсч байгаа нь эрүүл мэндийн даатгалын бүтээгдэхүүнийг бий болгох зайлшгүй шаардлага үүсч байна. (Үндэсний статистикийн газар, 2016)

*Хүснэгт 28. Хүн ам, хувийн эмнэлгийн мэдээлэл*

| | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 |
|---|---|---|---|---|---|
| Хүн ам | 2.87 сая | 2.93 сая | 3.00 сая | 3.06 сая | 3.12 сая |
| Хувийн эмнэлэг | 1,030 | 1,019 | 1,171 | 1,230 | 1,310 |
| Хувийн эмийн сан | 855 | 789 | 936 | 967 | 1,041 |

Барилга орон сууц, нийтийн аж ахуйн салбар

Өнгөрсөн 4 жилийн хугацаанд барилгын салбарын бүтээн байгуулалт эрчимтэй нэмэгдсээр 2014 онд 87 хувиар огцом өсөж 2.9 их наяд хүрсэн бол 2015 онд 2.9 их наяд төгрөг, 2016 онд 2.7 их наяд төгрөгийн үнэлгээтэй үл хөдлөх хөрөнгийг ашиглалтад оруулсан байна. Нийт бүтээн байгуулалтын 96.4 хувийг дотоодын компани гүйцэтгэжээ. Нийт барилгажилтын 50 хувиас доошгүй хэсгийг орон сууцны барилгын бүтээн байгуулалт эзэлж байна.

*Хүснэгт 29. Барилгын салбарын мэдээлэл*

| | 2013 | 2014 | 2015 | 2016 |
|---|---|---|---|---|
| Нийт /сая.төг/ | 1,564,701.40 | 2,930,085 | 2,920,087.00 | 2,773,116.80 |
| Үүнээс | | | | |
| Орон сууц | 856,903.70 | 1,443,363.70 | 1,538,706.90 | 1,408,774.10 |
| Худалдаа үйлчилгээний барилга | 49,912.60 | 140,914.10 | 150,712.20 | 270,986.40 |
| Эмнэлгийн барилга | 5,523.70 | 16,296.40 | 30,158.20 | 23,532.70 |
| Сургууль, соёлын барилга | 64,814.30 | 186,983.60 | 210,691.00 | 273,323.80 |
| Автозам | 335,146.70 | 412,130.50 | 330,124.20 | 196,237.70 |
| Гүүр, гүүрэн гарц | 7,893.60 | 18,294.40 | 15,469.00 | 23,695.70 |
| Бусад | 244,506.80 | 712,102.30 | 644,225.50 | 576,566.40 |
| Ашиглалтад орсон орон сууцны м2 | 1,237,300.00 | 1,898,200.00 | 2,308,700.00 | 1,079,200.00 |
| 1м2 - ийн үнэ /сая.төг/ | 0.69 | 0.76 | 0.67 | 1.31 |

Боловсрол

Жил тутамд нийт хүн амын ойролцоогоор 32 хувь нь ерөнхий болон дээд боловсрол эзэмшихээр суралцаж байдаг ба эдгээр иргэд нь тодорхой хугацааны дараа эдийн засгийн

2018 05-111
ARD INSURANCE COMPANY АРД ДААТГАЛ ХХК УЛААНБААТАР ХОТ
УЛААНБААТАР ХОТ МХБ-ийн гишүүн Андеррайтер Брокер, дилерийн "БИДИСЕК" ҮЦК ХК

идэвхтэй хүн амд шилждэг. Боловсролын салбарын хүрээнд оюутан, сурагчид, хүүхдүүдэд зориулсан болзошгүй гэнэтийн ослоос хамгаалсан хураамж багатай өндөр хүртээмжтэй бүтээгдэхүүн боловсруулж болно. (Үндэсний статистикийн газар, 2016)

*Хүснэгт 30. Боловсролын салбар*

| | 2012 | 2013 | 2014 | 2015 |
|---|---|---|---|---|
| Хүн ам | 2,867.70 | 2,930.30 | 2,995.90 | 3,057.80 |
| Ерөнхий боловсролын сургууль | 719.6 | 716.3 | 728.9 | 742.5 |
| Их дээд сургууль, коллеж | 221.6 | 217.7 | 222.1 | 206.4 |

Өрхийн орлого

Өрхийн орлогыг мөнгөн дүнгээр нь бүлэглэж харвал нийт өрхийн 46 хувь нь 700 мянган төгрөгөөс бага орлоготой байна. Харин 25.1 хувь нь 700 мянгаас 1.1 сая төгрөгийн орлоготой ба нийт өрхийн талаас илүү хувь нь бага, дунд орлоготой, 29 хувь нь дундаас дээш орлоготой байна.

Өнгөрсөн жилүүдэд улсын дунджаар нэг өрхөд ногдох дундаж орлого нэмэгдэх хандлагатай байгаа ба 2012 онд 819.9 мянган төгрөг байсан дүн 2015 онд 1,1 сая төгрөгт хүрч 27 хувиар нэмэгдсэн байна. Жил бүр өрхийн нийт орлогын 90 хувийг мөнгөн орлого эзэлж байна. (Үндэсний статистикийн газар, 2016)

*Схем 9. Өрхийн орлого*




*Хүснэгт 31. Өрхийн орлого*

| | 2012 | 2013 | 2014 | 2015 |
|---|---|---|---|---|
| Нийт орлого | 819,996.00 | 959,247.00 | 1,080,145.00 | 1,047,255.00 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Үүнээс мөнгөн орлого | 719.60 | 862,511.00 | 974,392.00 | 016,118.00 |

## ТЕХНИК ТЕХНОЛОГИ

Бүртгэлтэй гэрээ бүхий интернет хэрэглэгчийн тоог 2017 оны байдлаар нэгтгэж үзэхэд 2.9 сая хүрсэн. Сүүлийн жилүүдэд интернет хэрэглэгчдийн тоо хурдацтай өсөж байгаа ба 2014

*Зураг 2. Интернет хэрэглэгчдийн тоо /мянган хэрэглэгч/*

| Он | 2012 он | 2013 он | 2014 он | 2015 он | 2016 он | 2017 он |
|---|---|---|---|---|---|---|
| DSL | 36,695 | 40,684 | 29,244 | 24,123 | 24,842 | 20,251 |
| Шилэн кабель | 65,256 | 107,886 | 168,003 | 157,244 | 179,662 | 247,164 |
| 3G | 520,012 | 655,107 | 1,734,414 | 2,222,112 | 2,430,183 | 2,625,685 |
| LTE/4G | - | - | - | - | 216,401 | 677,131 |
| Wi-Fi | 5,281 | 10,444 | 11,700 | 16,413 | 10,643 | 13,957 |
| Wi-MAX | 24,587 | 24,322 | 16,394 | 10,265 | 8,673 | 1,469 |
| Бусад | 2,178 | 2,700 | 2,394 | 2 | 2,327 | 2,252 |
| Нийт | 654,009 | 841,143 | 1,962,149 | 2,430,159 | 2,656,330 | 2,910,778 |




| Нэрс | 2017 он |
|---|---|
| DSL | 0.70% |
| Шилэн кабель | 8.49% |
| Мобайл дата (3G) | 90.21% |
| Wi-Fi | 0.48% |
| Wi-Max | 0.05% |
| Бусад | 0.08% |

онд их хэмжээний өсөлт үзүүлсэн нь Монгол улсад мэдээллийн технологийн хэрэгцээ хэр хурдацтай өсөж байгааг тод илэрхийлж байна. 2017 оны жилийн эцсийн байдлаар үүрэн холбооны 3G хэрэглэгчийн тоо 2.6 сая хүрсэн бол 4G (өндөр хурдны LTE) сүлжээ аль хэдийн 677 мянган хэрэглэгчтэй болсон байна.

2016 оны эхний хагас жилийн байдлаар Монгол улсад 3.9 сая гар утас хэрэглэгч байгаа бол үүнээс 2.4 гаруй сая нь ухаалаг утас хэрэглэж байна.

*Зураг 3. Үүрэн холбооны идэвхтэй хэрэглэгчдийн тоо /мянган хэрэглэгч/*

СЗХ 2018.08.29 өдөр БҮРТГЭВ №1
0000095 БҮРТГЭВ 01




Интернетийн хэрэглээ ихээр нэмэгдэж байгаа тоон үзүүлэлтээс илэрхий харагдаж байгаа ба энэ өнөөгийн хэрэглэгч мэдээллээ суурин байдлаар аваад зогсохгүй хөдөлгөөнт үүрэн холбооны өндөр хурдны интернетийг ашиглаж үргэлж мэдээллээ авч, мэдээлэл солилцож чадаж байгааг харуулж байна.

Монголын даатгалын компаниудын технологийн дэвшлийг ашиглах явдал банкны салбартай харьцуулахад сул хөгжсөн боловч ойрын жилүүдэд интернетэд суурилсан онлайн даатгалын систем, даатгалын аппликэйшн хөгжүүлэлт эрчтэй хөгжих хандлагатай, туршилтын хувилбарууд хийгдсэн байна.

Даатгалын ажилтнуудын борлуулалтын болон дуудлагын ажилтнуудын бүртгэлийг real-time бүртгэх, хянах систем, харицагчдын удирдлагын систем /CRM/, ERP зэргийг бүх даатгалын компаниуд жигд хөгжүүлээгүй орхисон, зөвхөн үндсэн системд суурилсан байдалтай байна. Өөрөөр хэлбэл даатгалын компаниуд нь зөвхөн борлуулалтын тоон мэдээлэлд суурилсан шийдвэр гаргаж, даатгуулагчаа таньж мэдэхгүйгээр ажиллаж байгаа тул зорилтот зах зээлд чиглэсэн оновчтой борлуулалт, маркетинг хийх, бүтээгдэхүүн хөгжүүлэлтээ хэрэгжүүлэх боломжгүй болгож байна.

## *ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН БАЙДАЛ*

Өнөөдрийн байдлаар даатгалын салбарын үйл ажиллагааг

- Даатгалын тухай хууль
- Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль
- Жолоочийн даатгалын тухай хууль
- Иргэний хуулийн 43 дугаар бүлэг (Даатгал)
- СЗХ-ны эрх зүйн байдлын тухай хууль зэрэг хуулиуд болон СЗХ-ноос багц журам заавар гаргаж зохицуулж байна.

Цаашид заавал даатгалын шинэ хуулиуд батлагдахаар хуулийн төслийн шатанд явж байгаа бөгөөд эдгээр заавал даатгалын хуулиуд батлагдсанаар даатгалын салбарт томоохон

нөлөө үзүүлэх юм. Мөн даатгалын үйл ажиллагаа, борлуулалтын сувагт шууд нөлөөлөхүйц цахим гарын үсгийн зохицуулалтыг Санхүүгийн зохицуулах хорооноос гаргахаар төлөвлөж байна. Цахим гарын үсгийн тухай хуулийг УИХ-аас баталсан гэх боловч хэрэгжүүлэхэд шаардлагатай дүрэм, журмууд гараагүй, энэхүү хуулийн хэрэгжилт туйлын хангалтгүй байгаа.

### *БАЙГАЛЬ ОРЧИН*

Монгол улсын мал аж ахуйн салбар ажил эрхлэлтийн гуравны нэг болон ДНБ-ний 17 хувийг эзэлж байна. Өвлийн зуднаас үүдэн маш их хэмжээний мал үрэгддэг бөгөөд 1999-2003 онуудын хооронд нийт 11.2 сая мал амь үрэгдэж 12,000 айл өрхүүдийн хөрөнгийг үгүй хийсэн байна.

Мөн сүүлийн 40 орчим жилийн хугацаанд хотын хүн ам 2.5 дахин өсч хотжилт, хүн амын төвлөрөл ихсэх болсноос шалтгаалан байгалийн жамаар нөхөн сэргэх чадавх нэн хязгаарлагдмал болж байгаль орчин бохирдон доройтож хот суурин газрын эргэн тойрны хөрс элэгдэн эвдэрч, усны нөөц ховордон, зарим амьтан нүүн дайжиж, ургамлын зүйлийн бүрэлдэхүүн өөрчлөгдөж, ургацын хэмжээ эрс буурч, улмаар устгах аюул нүүрлэж байна. Энэ нь газар тариалан, малын даатгал зэрэг даатгалын хэрэгцээ шаардлага хангалттай өндөр үүсэх боломжтойг харуулж байна. Үүнээс гадна эрүүл мэндийн даатгалын хэрэгцээ ч даган нэмэгдэх боломжтой байна.

### Давхар даатгал

Даатгалын зах зээлд дотоодын 1 давхар даатгалын компани үйл ажиллагаа явуулж байгаа ба төрийн хамааралтай үндэсний давхар даатгалын компани байгуулах ажлын хэсэг СЗХ-ны дэргэд байгуулагдаад ажиллаж байна. Ердийн даатгагчид өөрийн хүлээх эрсдэлийг хэсэгчлэн гадаадын давхар даатгагчид даатгуулахад тайлант хугацаанд 45.76 тэрбум төгрөгийг зарцуулсан нь өмнөх оноос 23.3 хувиар өссөн байна.

*Хүснэгт 32. Ердийн даатгалын компаниудын давхар даатгалын хураамж*

| № | Компанийн нэр | ДАВХАР ДААТГАЛ | | | | | | Өөрчлөлт | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 2015 | | 2016 | | 2017 | | 2016/2017 | |
| | | дүн | хувь | дүн | хувь | дүн | хувь | дүн | хувь |
| 1 | Бодь даатгал | 18,479.2 | 44.1% | 13,081.2 | 35.2 % | 16,711.5 | 36.5% | 3,630.3 | 27.8% |
| 2 | Мандал женерал даатгал | 5,784.0 | 13.8% | 7,418.6 | 20.0 % | 11,243.9 | 24.6% | 3,825.2 | 51.6% |
| 3 | Монгол даатгал | 11,311.7 | 27.0% | 10,195.1 | 27.5 % | 7,782.6 | 17.0% | (2,412.5 ) | - 23.7% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 4 | Тэнгэр даатгал | 1,949.3 | 4.6% | 2,343.9 | 6.3% | 3,900.5 | 8.5% | 1,556.6 | 66.4% |
| 5 | Ард Даатгал | 1,842.0 | 4.4% | 1,346.4 | 3.6% | 3,301.9 | 7.2% | 1,955.5 | 145.2 % |
| 6 | Соёмбо даатгал | 534.8 | 1.3% | 455.8 | 1.2% | 912.9 | 2.0% | 457.1 | 100.3 % |
| 7 | Миг даатгал | 1,067.1 | 2.5% | 495.5 | 1.3% | 696.5 | 1.5% | 200.9 | 40.5% |
| 8 | Практикал даатгал | 467.3 | 1.1% | 1,356.1 | 3.7% | 538.8 | 1.2% | (817.4) | -60.3% |
| 9 | Номин даатгал | 238.2 | 0.6% | 295.7 | 0.8% | 358.6 | 0.8% | 62.9 | 21.3% |
| 10 | Хаан даатгал | 67.8 | 0.2% | 134.1 | 0.4% | 205.3 | 0.4% | 71.3 | 53.2% |
| 11 | Монре даатгал | 191.4 | 0.5% | | 0.0% | 110.6 | 0.2% | 110.6 | 100.0 % |
| 12 | Мөнх даатгал | | | | | | | | |
| 13 | Ган зам даатгал | | | | | | | | |
| 14 | Улаанбаатар хотын даатгал | | | | | | | | |
| 15 | Гэр даатгал | | | | | | | | |
| | **НИЙТ ДАВХАР ДААТГАЛ** | **41,932.7** | **100.0%** | **37,122.5** | **100.0 %** | **45,762.9** | **100.0 %** | 8,640.4 | **23.3%** |

## Өрсөлдөгчийн судалгаа

Даатгалын салбар тэр дундаа ердийн даатгалын зах зээлийн өнөөгийн нөхцөл байдал, өрсөлдөгч компаниудын мэдээ, мэдээлэл зэрэгт үндэслэн зах зээлийн боломжийг тодорхойлж өрсөлдөхүйц компани байгуулах нь чухал ач холбогдолтой юм.

2017 оны эцсийн байдлаар ердийн даатгалын компаниудын нийт хөрөнгө 193.58 тэрбум төгрөг байгаа нь өмнөх оны үетэй харьцуулахад 16.7 хувиар өссөн байна.

*Хүснэгт 33. Ердийн даатгалын компаниудын нийт хөрөнгө*

| № | Компанийн нэр | НИЙТ ХӨРӨНГӨ | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | 2015 | | 2016 | | 2017 | |
| | | дүн | хувь | дүн | хувь | дүн | хувь |
| 1 | Монгол даатгал | 27,887.6 | 20.0% | 30,374.7 | 18.3% | 33,176.6 | 17.1% |
| 2 | Мандал женерал даатгал | 9,797.3 | 7.0% | 17,309.4 | 10.4% | 21,472.2 | 11.1% |
| 3 | Тэнгэр даатгал | 12,689.0 | 9.1% | 16,653.7 | 10.0% | 19,291.3 | 10.0% |
| 4 | Бодь даатгал | 11,019.2 | 7.9% | 12,304.7 | 7.4% | 16,663.7 | 8.6% |
| 5 | Миг даатгал | 10,389.1 | 7.4% | 11,485.0 | 6.9% | 16,088.8 | 8.3% |
| 6 | Практикал даатгал | 9,035.3 | 6.5% | 11,173.9 | 6.7% | 13,400.2 | 6.9% |
| 7 | Ард Даатгал | **8,758.5** | **6.3%** | **9,541.1** | **5.8%** | **11,726.6** | **6.1%** |
| 8 | Номин даатгал | 8,339.6 | 6.0% | 10,490.7 | 6.3% | 11,606.8 | 6.0% |
| 9 | Соёмбо даатгал | 9,289.4 | 6.7% | 9,770.5 | 5.9% | 10,065.1 | 5.2% |
| 10 | Хаан даатгал | 5,775.7 | 4.1% | 7,840.1 | 4.7% | 8,887.8 | 4.6% |
| 11 | Ган зам даатгал | 5,708.3 | 4.1% | 6,981.1 | 4.2% | 7,338.9 | 3.8% |
| 12 | Монре даатгал | 5,805.6 | 4.2% | 6,376.1 | 3.8% | 6,660.2 | 3.4% |
| 13 | Гэр даатгал | 5,007.9 | 3.6% | 5,604.4 | 3.4% | 6,230.8 | 3.2% |

СЗХ 2018 .08. 29 өдөр БҮРТГЭВ № 01
0000098 БҮРТГЭВ ... он ... сар ... өдөр 01

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 14 | Улаанбаатар хотын даатгал | 5,678.3 | 4.1% | 5,637.8 | 3.4% | 6,125.0 | 3.2% |
| 15 | Мөнх даатгал | 4,329.3 | 3.1% | 4,313.6 | 2.6% | 4,846.1 | 2.5% |
| | Системийн дүн | **139,510.2** | **100.0%** | **165,856.9** | **100.0%** | **193,580.1** | **100.0%** |

Монгол улсын даатгалын салбарт ашиглаж буй програм хангамжийн өнөөгийн байдал доорхи хүснэгтийн дагуу байна. Үүнд:

*Хүснэгт 34. Даатгалын компаниудын хэрэглэдэг програм хангамж*

| | Даатгалын компани | Програмын нэр |
|---|---|---|
| 1 | Ард Даатгал | Silicon system |
| 2 | Миг даатгал | Silicon system |
| 3 | Тэнгэр даатгал | Heaven pro |
| 4 | Монгол даатгал | 1c |
| 5 | Монре даатгал | Програм байхгүй |
| 6 | Улаанбаатар хотын даатгал | Дотоодын ERP |
| 7 | Ган зам даатгал | Програм байхгүй |
| 8 | Соёмбо даатгал | Мэдээлэл байхгүй |
| 9 | Мөнх даатгал | Мэдээлэл байхгүй |
| 10 | Гэр даатгал | Програм байхгүй |
| 11 | Номин даатгал | Дотоодын ERP system |
| 12 | Мандал даатгал | Heaven pro өөрсдөө |
| 13 | Хаан даатгал | Prosoft - ERP |
| 14 | Практикал даатгал | Мэдээлэл байхгүй |
| 15 | Бодь даатгал | Мэдээлэл байхгүй |

Эдгээр програмууд санхүү болон даатгалын програмуудыг багтаасан програмууд болович одоог хүртэл хөгжүүлэлт хийх шаардлагатай байсаар байна.

2017 онд даатгалын зах зээлд нийт 44.33 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр олгосон бөгөөд энэ нь өмнөх оны мөн үеэс 10.94 тэрбум төгрөг буюу 32.8 хувиар буурсан үзүүлэлттэй гарсан байна. Нөхөн төлбөр олголтын харьцаа нь 0.31 хүрсэн байна энэ нь өмнөх оноос 0.01 нэгжээр өссөн байна.

*Хүснэгт 35. Ердийн даатгалын компаниудын нөхөн төлбөр*

| № | Компанийн нэр | НИЙТ НӨХӨН ТӨЛБӨР | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | 2015 | | 2016 | | 2017 | |
| | | дүн | хувь | дүн | хувь | дүн | хувь |
| 1 | Монгол даатгал | 8,090.80 | 22.8% | 6,703.5 | 20.1% | 8,562.9 | **19.3%** |
| 2 | Миг даатгал | 4,354.60 | 12.3% | 4,954.1 | 14.8% | 6,820.6 | **15.4%** |
| 3 | Тэнгэр даатгал | 2,755.30 | 7.8% | 2,385.6 | 7.1% | 4,847.0 | **10.9%** |

ГТН 80 2062089 УЛААНБААТАР ХОТ
Андеррайтер брокер, дилерийн "БЛАСЕР" ХХК 1112054

2018 05-11

СЗХ 2018.08.29 өдөр БҮРТГЭВ № 1
0000099 БҮРТГЭВ 01

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4 | Мандал женерал даатгал | 4,515.90 | 12.8% | 4,116.2 | 12.3% | 4,705.6 | **10.6%** |
| 5 | Бодь даатгал | 3,288.60 | 9.3% | 2,839.0 | 8.5% | 4,519.4 | **10.2%** |
| **6** | **Ард Даатгал** | **3,020.60** | **10.0%** | **2,606.8** | **7.8%** | **4,063.1** | **9.2%** |
| 7 | Практикал даатгал | 2,256.20 | 6.4% | 3,152.5 | 9.4% | 3,397.4 | **7.7%** |
| 8 | Монре даатгал | 1,700.50 | 4.8% | 1,547.3 | 4.6% | 2,062.5 | **4.7%** |
| 9 | Соёмбо даатгал | 1,659.70 | 4.7% | 2,214.9 | 6.6% | 1,835.6 | **4.1%** |
| 10 | Номин даатгал | 1,599.80 | 4.5% | 1,375.5 | 4.1% | 1,440.7 | **3.2%** |
| 11 | Хаан даатгал | 843.90 | 2.4% | 1,071.7 | 3.2% | 1,378.9 | **3.1%** |
| 12 | Гэр даатгал | 81.20 | 0.2% | 114.0 | 0.3% | 413.0 | **0.9%** |
| 13 | Улаанбаатар хотын даатгал | 270.80 | 0.8% | 158.7 | 0.5% | 145.0 | **0.3%** |
| 14 | Ган зам даатгал | 97.20 | 0.3% | 55.5 | 0.2% | 78.8 | **0.2%** |
| 15 | Мөнх даатгал | 74.70 | 0.2% | 104.3 | 0.3% | 62.4 | **0.1%** |
| | **НИЙТ НӨХӨН ТӨЛБӨР** | **35,417.80** | **100.0%** | **33,388.5** | **100.0%** | **44,333.0** | **100.0%** |

*Хүснэгт 36. Ердийн даатгалын зах зээлийн мэдээлэл*

| № | Санхүүгийн үзүүлэлт | 2016 | 2017 |
|---|---|---|---|
| 1 | Хураамжийн орлого | 111,676.55 | 141,180.4 |
| 2 | Давхар даатгалын хураамж | 37,122.53 | 45,762.9 |
| 3 | Даатгалын цэвэр хураамж | 71,662.47 | 91,151.3 |
| 4 | Нөхөн төлбөр | 33,388.50 | 44,333.0 |
| 5 | Тайлант үеийн цэвэр ашиг | 8,455.33 | 8,701.3 |
| 6 | Нөөц сан | 76,273.30 | 94,775.4 |
| 7 | Нийт хөрөнгө | 165,856.90 | 193,580.1 |

Даатгалын салбарын нийт хураамж 2011 онд 47 тэрбум төгрөг байсан бол 2017 оны эцэст 141 тэрбум төгрөгт хүрч нийт хураамж 200 хувиар өссөн байна. Энэ өсөлт нь зах зээлийн хамралт нэмэгдэж тэлсэн, гадаадын хөрөнгө оруулалттай компаниуд орж ирсэн, Жолоочийн даатгалын тухай хууль хэрэгжиж эхэлсэн, нөгөө талаас даатгалын үнэлгээ болон үнийн ерөнхий өсөлттэй холбоотой гэж үзэж болохоор байна.

*Хүснэгт 37. Даатгалын салбарын нийт хураамж, давхар даатгал, цэвэр хураамжийн орлого /сая.төг/*



СЗХ 2018.08.29 өдөр БҮРТГЭВ № 11

0000100 MONGOLIAN STOCK EXCHANGE БҮРТГЭВ 01

Даатгалын салбарт ердийн даатгалын компаниуд 17 даатгалын хэлбэрт хамаарах 80 гаруй даатгалын бүтээгдэхүүн борлуулж байгаа ба үнэт цаас гаргагч нь 13 даатгалын хэлбэрээр 50 гаруй даатгалын бүтээгдэхүүний зөвшөөрөлтэйгээр үйл ажиллагаа явуулж байна. 2017 оны 141 тэрбум төгрөгийн хураамжийн 81.3 хувийг 5 төрлийн даатгалын хэлбэр дангаар бүрдүүлсэн ба үүнд:

- Хөрөнгийн даатгал
- Авто тээврийн хэрэгслийн даатгал
- Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал
- Гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал
- Хариуцлагын даатгалууд хамаарч байна.

*Хүснэгт 38. Даатгалын салбарын хураамжийн орлого /сая.төг/*

| № | Даатгалын бүтээгдэхүүн | ХУРААМЖИЙН ОРЛОГО | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | 2015 | | 2016 | | 2017 | |
| | | Дүн | хувь | Дүн | хувь | Дүн | хувь |
| 1 | Эрүүл мэнд, гэнэтийн ослын даатгал | 10,612.0 | 9.5% | 12,331.7 | 11.0% | 17,857.0 | 12.6% |
| 2 | Хөрөнгийн даатгал | 40,884.3 | 36.4% | 31,793.2 | 28.5% | 36,699.1 | 26.0% |
| 3 | Тээврийн хэрэгслийн даатгал | 15,676.4 | 14.0% | 14,481.9 | 13.0% | 18,547.9 | 13.1% |
| 4 | Ачаа тээврийн даатгал | 2,375.8 | 2.1% | 1,943.6 | 1.7% | 1,486.3 | 1.1% |
| 5 | Барилга угсралтын даатгал | 2,002.5 | 1.8% | 3,266.5 | 2.9% | 7,408.1 | 5.2% |
| 6 | Газар тариалангийн даатгал | - | 0.0% | 13.7 | 0.0% | 42.8 | 0.0% |
| 7 | Мал амьтадын даатгал | 709.7 | 0.6% | 1,158.5 | 1.0% | 2,386.0 | 1.7% |
| 8 | Агаарын хөлгийн даатгал | 5,307.3 | 4.7% | 6,029.9 | 5.4% | 8,714.0 | 6.2% |
| 9 | Жолоочийн хариуцлагын даатгал | 23,317.0 | 20.8% | 28,254.4 | 25.3% | 30,882.4 | 21.9% |
| 10 | Хариуцлагын даатгал | 7,336.8 | 6.5% | 7,857.3 | 7.0% | 10,766.8 | 7.6% |
| 11 | Санхүүгийн даатгал | 3,197.3 | 2.8% | 3,232.6 | 2.9% | 3,189.0 | 2.3% |
| 12 | Зээлийн даатгал | 795.1 | 0.7% | 1,313.2 | 1.2% | 3,201.0 | 2.3% |
| **НИЙТ ХУРААМЖИЙН ОРЛОГО** | | **112,213.3** | **100.0%** | **111,676.5** | **100.0%** | **141,180.4** | **100.0%** |

2017 оны нийт хураамжийн дүнгээр хөрөнгийн даатгал борлуулалт өндөртэй байна. Хөрөнгийн даатгал нь давтамж бага боловч хохирол өндөртэй даатгал учраас даатгалын компани болзошгүй эрсдэлээс сэргийлж давхар даатгуулахыг эрмэлздэг, мөн фронтингийн гэрээгээр хийгдэж байгаа зэргээс хамаарч цэвэр хураамжийн дүн буурсан байна. Гэхдээ хөрөнгийн даатгал нь үйл ажиллагааны зардал багатай даатгагчид өгөөж өндөр өгдөг даатгалын бүтээгдэхүүн юм.

ARD INSURANCE COMPANY АРД ДААТГАЛ ХХК УЛААНБААТАР ХОТ

УЛААНБААТАР ХОТ МХБ-ийн гишүүн Андеррайтер Брокер, дилерийн БИДИСЕК ҮЦК ХК

2018 08 05-113

СЗХ
2018 .08. 29 өдөр
БҮРТГЭВ
№ 01



## 1.15.4. ТӨЛӨВЛӨЛТ

### *SWOT TOWS шинжилгээ*

*Хүснэгт 39. SWOT TOWS Шинжилгээ*

| | Гадаад орчин /шууд бус нөлөөтэй/ | Үзүүлэх нөлөө |
|---|---|---|
| Үл хамаарах | Улс төр | -1 |
| | Даатгалын салбарт төрийн оролцоо нэмэгдэж өрсөлдөөний орчинг хязгаарлаж байна | -2 |
| | Төрийн зохицуулалтын байгууллагын улс төрөөс хамаарсан тогтвортой бус, мэргэжлийн бус байдал. | -1 |
| | Хөрөнгө оруулагчдийн улс төрийн нөлөөлөл | 1 |
| | Хууль эрх зүй | 2 |
| | Заавал даатгалын хуулиуд батлагдснаар шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ нэвтрэх | 2 |
| | Хамааралтай дүрэм журмуудын өөрчлөлт /Замын хөдөлгөөний дүрэм/ | 1 |
| | Эдийн засаг | 0 |
| | Эдийн засгийн өсөлт удааширсан | -1 |
| | Түүхий эдийн зах зээлийн үнийн тогтворгүй байдал (Алт, Зэс, Нүүрс) | -1 |
| | Гадаадын шууд хөрөнгө оруулалтын өсөх таамаглал | 1 |
| | Байгаль орчин | -1 |
| | Байгалийн гамшиг /үер, зуд, газар хөдлөлт гэх мэт/ | 0 |
| | Агаарын бохирдол, Орчны бохирдол | -1 |
| | Нийгэм, соёл | 0 |
| | Шашны нөлөө | -2 |
| | Даатгалын боловсрол | 1 |
| | Эрүүл мэнд | 1 |
| | Гэмт хэрэг | -1 |
| | Технологи | 2 |
| | Цахим ертөнц, нийгмийн сүлжээний нөлөөлөл, ухаалаг төхөөрөмж хөгжил | 2 |
| | Үйлчилгээний байгууллагын технологийн хөгжил | 2 |
| Хамаарах | Өрсөлдөгч | -1 |
| | Бусад даатгалын компаниудын өсөлт | -2 |
| | Шударга бус өрсөлдөөн, түүний хяналт, зохицуулалт сул | -1 |
| | Банк даатгалын компаниудын хоорондын хамаарал | -1 |
| | Хэрэглэгч /даатгуулагч/ | 0 |
| | Хэрэглэгчийн үнэнч бус байдал | -1 |
| | Хэрэглэгчийн бусдад нөлөөлөх нөлөөлөл | 1 |
| | Дэмжигч | 1 |
| | Даатгалын мэргэжлийн холбоодын үйл ажиллагаа | -1 |
| | Хөрөнгө оруулагчийн хамааралтай компаниудын нөлөө (Групп) | 2 |
| | Бусад салбарын мэргэжлийн холбоод, ТББ-ын үйл ажиллагаа | 1 |

| | Дотоод орчин /шууд нөлөөтэй/ | Үзүүлэх нөлөө |
|---|---|---|
| Хамаарах | Зохион байгуулалт | 0 |
| | Мэдээллийн урсгал | -1 |
| | Ажилчдын ёс зүй | 0 |
| | Багаар ажиллах чадвар | 0 |
| | Сургах хүмүүжүүлэх тогтолцоо | 0 |
| | Дүрэм журам | -1 |
| | Дотоод дүрэм журмуудын уялдаа холбоо, эмх цэгц, түүний хяналт | -1 |

| | | |
|---|---|---|
| | Идэвх санаачлага | 0 |
| | Идэвхжүүлэлт, урамшууллын зохицуулалт | 1 |
| | Идэвхжүүлэлт, урамшууллын тогтолцооны хэрэгжилт | -1 |
| | Байгууллагын соёл | 0 |
| | Дотоод харилцаа | 1 |
| | Ажилчдын шинэ санал, санаачилга, түүний урамшуулах тогтолцоо | -1 |
| | Ажилчдын нийгмийн асуудалд анхаарах байдал | 1 |
| | Маркетинг | -1 |
| | Маркетингийн төлөвлөгөө, бодлого | -2 |
| | Судалгаа шинжилгээ | -1 |
| | Танилцуулга, сурталчилгаа /брошур, реклам, цахим сурталчилгаа/ | -1 |
| | Бүтээгдэхүүн үйлчилгээ | 0 |
| | Гэрээ байгуулах үеийн хэрэглэгчийн халамж | 1 |
| | Гэрээ байгуулсны дараах харилцагчийн халамж | 1 |
| | Даатгалын тохиолдлын үеийн харилцагчийн үйлчилгээ | -1 |
| | Нөхөн төлбөрийн дараах харилцагчийн сэтгэл ханамж | 0 |
| | Чанарын удирдлагын тогтолцоо | -1 |
| | Эрсдэлийн удирдлага | 1 |
| | Санхүүгийн эрсдэл | 1 |
| | Даатгалын эрсдэл | 1 |

*Хүснэгт 40. SWOT Шинжилгээ*

| Давуу тал | Сул тал |
|---|---|
| ❖ Хүний нөөц<br>❖ Туршлага<br>❖ Үйлчилгээ, түүний чанар | ❖ Хэрэглэгчдийн үнэнч бус байдал<br>❖ Дүрэм журам хэрэгжилт<br>❖ Маркетинг<br>❖ Байгууллагын соёл |
| **Боломж** | **Аюул** |
| ❖ Даатгалын зах зээлийг дэмжих заавал даатгалын хуулиуд<br>❖ Технологийн хөгжил<br>❖ Хөрөнгө оруулагч болон бусад хамаарал бүхий компаниудын нөлөө | ❖ Улс төрийн нөлөөлөл<br>❖ Эдийн засгийн уналт<br>❖ Байгалийн гамшиг<br>❖ Шашны нөлөөлөл<br>❖ Шударга бус өрсөлдөөн |

*Давуу талаа ашиглан хэрхэн боломжийг бий болгох вэ?*

Заавал даатгалын хуулиуд шинээр батлагдаж хэрэгжихээр болвол туршлага бүхий ажиллах хүчин болон бусад холбогдох нөөцүүд хангалттай хэмжээнд бий болсон байна.

Холбоо бүхий аж ахуй нэгжүүдэд болон тэдгээрээр дамжуулан борлуулалт хийх, үйлчилгээний чанарыг сайжруулах.

*Давуу талаа ашиглан хэрхэн аюулаас зайлсхийх вэ?*

СЭХ
2018 .08 сар 29 өдөр
БҮРТГЭВ
№ 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН
MONGOLIAN
0000103
БҮРТГЭВ
01

Хүний нөөцийн туршлага болон даатгал, санхүүгийн эрсдэлүүдийг үнэлэх замаар эдийн засаг, байгалийн сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх. Даатгалын үйлчилгээ болон түүний чанарт анхааран бусдаас ялгарч шударга бус өрсөлдөөнөөс хамгаалах.

*Сул талаа хэрхэн боломж болгох вэ?*

Технологийн хөгжлийг ашиглан дүрэм журмын хэрэгжилтэнд хяналт тавих, маркетингийн арга хэрэгслүүдийг нэмэгдүүлэх боломжийг үүсгэх.

*Сул тал болон аюул*

Сул тал болон учирч болзошгүй аюулаар дамжин компани хүнд байдалд оруулах нөхцөл нь бага байна.

## Зорилтот зах зээл

Үнэт цаас гаргагч нь зорилтот зах зээлийг тодорхойлохдоо даатгалын зах зээлийн томоохон хэсгийг эзлэж буй дараах дөрвөн төрлийн даатгалын хэлбэрийг тодорхойлж байна. Үүнд:

1) Хөрөнгийн даатгал
2) Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал, тус даатгалыг дагаж тээврийн хэрэгслийн даатгал уялдан хийгдэх боломжтой
3) Гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал
4) Хариуцлагын даатгал

Дээрх даатгалын төрлөөс гадна зах зээлд эзлэх хувь нь бага хэдий ч компанид өгөөж өндөртэй даатгалын хэлбэрүүдээр борлуулалт хийнэ. Үүнд:

1) Барилга угсралтын ажлын даатгал
2) Ачаа тээврийн даатгал
3) Агаарын хөлгийн даатгал

<u>Хөрөнгийн даатгал</u>

Хөрөнгийн даатгалын салбар жил ирэх тусам нэмэгдсээр байгаа ба 2017оны байдлаар 36.69 тэрбум төгрөгийн хураамж бүрдүүлсэн байна. Нийт зах зээлийн 50 хувь буюу 18.42 тэрбум төгрөгийг Бодь болон Монгол даатгал бүрдүүлсэн байна. (2016 оны зах зээлийн мэдээлэл тодорхойгүй байна)

*Хүснэгт 41. Хөрөнгийн даатгалд голлох оролцоотой даатгалын компаниуд*

| сая төгрөг | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 | 2017 |
|---|---|---|---|---|---|---|

АРД ДААТГАЛ ХХК
ARD INSURANCE COMPANY
УЛААНБААТАР ХОТ
МХБ-ийн гишүүн Андеррайтер Брокер, дилерийн "БИДСЕК" ХХК
2018 05 11

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| Бодь даатгал | 1,079.18 | 1,340.23 | 8,269.15 | 15,628.97 | | 10,298.32 |
| Монгол даатгал | 6,591.06 | 8,677.16 | 9,831.22 | 8,339.03 | | 8,122.88 |
| Ард Даатгал | 2,977.67 | 5,005.84 | 1,935.05 | 2,924.85 | | 4,236.46 |
| Тэнгэр даатгал | 781.42 | 1,327.93 | 1,752.08 | 2,598.93 | | 3,363.58 |
| Миг даатгал | 1,103.91 | 2,135.04 | 2,453.90 | 2,295.66 | | 2,026.01 |
| Бусад | 6,183.32 | 7,141.82 | 8,025.40 | 8,130.18 | | 8,651.85 |
| **Нийт** | **18,716.57** | **25,628.03** | **32,266.80** | **39,917.63** | | **36,699.09** |

Үнэт цаас гаргагч нь хөрөнгийн даатгалаар хангалттай зах зээл байгаа гэж үзэж байгаа ба Тэнгэр, Миг, Мандал даатгалуудын оролцоо эрчимтэй өсөж байна.

Эрүүл мэнд, гэнэтийн ослын даатгал

Эрүүл мэндийн даатгалаар нийт 17.86 тэрбумын зах зээл байгаа бөгөөд Монгол, Миг, Бодь, Мандал даатгалуудын хувьд олон улсын эрүүл мэндийн даатгал борлуулдаг учраас зах зээлд дээгүүр байр эзэлж байна. Үнэт цаас гаргагчийн хувьд 2017 оноос олон улсын эрүүл мэндийн даатгалыг зах зээлд нэвтрүүлсэн бөгөөд тус бүтээгдэхүүнийг идэвхжүүлэх зах зээлд таниулах ажил хийх шаардлагатай байна. Ингэснээр эрүүл мэндийн даатгалаар зах зээлд эзлэх хувиа нэмэгдүүлэх бүрэн боломж байна.

*Хүснэгт 42. Эрүүл мэндийн даатгалд голлох оролцоотой даатгалын компаниуд*

| | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 | 2017 |
|---|---|---|---|---|---|---|
| Монгол даатгал | 1,446.57 | 1,534.58 | 2,769.25 | 2,190.47 | | 2,820.05 |
| Миг даатгал | 804.46 | 566.20 | 653.34 | 1,641.59 | | 1,234.37 |
| Бодь даатгал | 618.93 | 662.40 | 1,095.63 | 1,602.97 | | 2,937.79 |
| Соёмбо даатгал | 399.04 | 577.34 | 888.62 | 1,111.48 | | 704.58 |
| Мандал женерал даатгал | 0.10 | 119.25 | 738.25 | 1,010.42 | | 4,943.51 |
| Бусад | 2,268.60 | 2,441.22 | 2,962.08 | 3,055.09 | | 5,216.71 |
| **Нийт** | **5,537.70** | **6,200.99** | **9,107.17** | **10,612.02** | | **17,857.02** |

Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал

2012 онд жолоочийн даатгалын хууль хэрэгжиж эхэлсэн ба жил ирэх тусам хураамж нэмэгдсээр байна. Энэ нь авто тээврийн хэрэгслийн тоо, шинээр жолооны эрхийн үнэмлэх авч байгаа иргэдийн тооноос шууд хамааралтайгаар өсдөг зах зээл юм. 2017 оны байдлаар 30.44 тэрбум төгрөгийн хураамж бүрдүүлсэн.

*Хүснэгт 43. Жолоочийн даатгалд голлох оролцоотой даатгалын компаниуд*

| | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 | 2017 |
|---|---|---|---|---|---|---|
| Монгол даатгал | 3,792.44 | 3,614.54 | 3,659.25 | 3,867.14 | | 5,609.93 |
| Миг даатгал | 1,377.81 | 1,855.56 | 2,936.50 | 3,727.46 | | 4,680.99 |

0000105

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| Бодь даатгал | 2,419.27 | 1,650.73 | 3,414.04 | 3,506.36 | | | 3,743.60 |
| Ард Даатгал | 1,160.71 | 1,064.41 | 2,048.96 | 2,282.41 | | | 1,780.87 |
| Бусад | 5,796.01 | 5,906.88 | 6,610.97 | 7,561.35 | | | 14,630.05 |
| **Нийт** | **16,298.08** | **15,154.92** | **20,088.80** | **22,714.85** | | | **30,445.44** |

## Хариуцлагын даатгал

Өнгөрсөн 2011-2015 онуудад хариуцлагын даатгалын зах зээл тогтвортой байсан ба онцгой өөрчлөлт бол төдийлөн гараагүй. Гэхдээ энэ төрлийн даатгалд тэргүүлж байгаа компаниудын хувьд нилээн савалгаатай байсан. Сүүлийн хоёр жилийн хугацаанд хариуцлагын даатгал зах зээл өсөх хандлагатай байгаа бөгөөд 2017 оны байдлаар нийт 10.77 тэрбум төгрөгийн хураамжтай байгаа нь тус бүтээгдэхүүний зах зээлд хангалттай орон зай байгааг илэрхийлж байна.

*Хүснэгт 44. Хариуцлагын даатгалд голлох оролцоотой даатгалын компаниуд*

| сая төгрөг | 2011 | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 | 2017 |
|---|---|---|---|---|---|---|---|
| Монгол даатгал | 605.57 | 1,050.91 | 1,151.62 | 993.85 | 2,064.25 | | 1,730.55 |
| Бодь даатгал | 1,898.32 | 2,765.71 | 1,780.21 | 594.60 | 1,314.61 | | 2,227.00 |
| Тэнгэр даатгал | 812.00 | 608.29 | 607.96 | 624.74 | 907.59 | | 1,176.59 |
| Мандал женерал даатгал | 379.85 | 477.42 | 511.83 | 1,035.02 | 877.66 | | 2,302.07 |
| Ард Даатгал | 516.43 | 543.69 | 839.28 | 583.15 | 612.39 | | 500.37 |
| Бусад | 1,843.62 | 2,068.30 | 2,178.20 | 2,080.69 | 1,464.10 | | 2,830.19 |
| **Нийт** | **6,055.80** | **7,514.33** | **7,069.09** | **5,912.05** | **7,240.60** | | **10,766.78** |

## Бизнес төлөвлөгөөний зорилго

Үнэт цаас гаргагчийн 5 жилийн хугацаанд хэрэгжүүлэхээр зорьж буй бизнес төлөвлөгөөний зорилго бол топ 3 даатгалын компанийн нэг болох болон ашигт ажиллагаа өсгөх юм. Уг зорилгын хүрээнд дараах ажлуудыг хийхээр төлөвлөсөн байна:

*Хүснэгт 45. Ард Даатгал ХХК"-ийн хэрэгжүүлэхээр төлөвлөж буй төслүүд*

| Хэрэгжүүлэх төсөл | Хийх ажлууд | Хугацаа |
|---|---|---|
| **ТОП 3 даатгалын компанийн нэг болох** | | |
| Харилцагчийн үйлчилгээ, бүтээмжийг нэмэгдүүлэх | Харилцагчийн хэрэгцээнд тулгуурлан бүтээгдэхүүн, үйлчилгээг шинэчлэх, харилцагчийн санал хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх, түүнд хяналт тавих зохицуулалт хийх | 2018-2022 он |

СЗХ
2018 .08. 29 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
0000106
БҮРТГЭВ
...... он .... сар .... өдөр
01



| | | |
|---|---|---|
| Нэгдсэн салбар | Ард Санхүүгийн Нэгдэлийн хүрээнд нэгдсэн санхүүгийн үйлчилгээ хүргэх салбарууд байгуулах | 2017.05.01-2018.05.01 |
| Хүний нөөцийн бодлого боловсруулах | Чадвартай боловсон хүчний талаарх судалгаа хийх, тэдгээрээс шаардлагатай тохиолдолд "headhunting" урвуулах | Улирал тутам |
| Үйлчилгээний ISO-9001 стандартыг нэвтрүүлэх | Компанийн системийн хэмжээнд хэрэгжүүлэх бөгөөд даатгалын онцлогт нийцүүлэн чанарын удирдлагын тогтолцоог хэрэгжүүлнэ | 2019.01.01-2020.03.31 |
| Бүтээгдэхүүн хөгжил болон шинэ бүтээгдэхүүн | Сегментэд зориулж бүтээгдэхүүнийг цаг тухай бүр хөгжүүлэх | 2018-2022 он |
5.4.8. Энгийн хувьцааны 10 хувиас дээш хувьцаа эзэмшигч хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг хуралдуулахаар ТУЗ-д санал хүргүүлэх, ТУЗ энэ саналыг үндэслэлгүйгээр хүлээн аваагүй тохиолдолд өөрөө зарлан хуралдуулах, хурал зарлагдсан үед хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг гаргуулах;

5.4.9. Хувьцаа эзэмшигч нь улирал бүр компанийн санхүүгийн тайлантай танилцах эрхтэй.

5.4.10. Хууль тогтоомж болон энэхүү дүрмээр тогтоосон бусад эрх

## 2.6. Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт

Үнэт цаас гаргагчийн МХБ-д бүртгүүлж олон нийтээс татан төвлөрүүлсэн хөрөнгийг зарцуулах нэн тэргүүний зорилго бол СЗХ-ны "Даатгалын компанийн дүрмийн сангийн доод

АРД ДААТГАЛ ХХК УЛААНБААТАР ХОТ 2062089
МХБ-ийн гишүүн Андеррайтер Брокер, дилерийн "БИДНЕРЗ" ҮЦК ХК 5205447 2052482
2018 05 11

СЗХ
2018.08.29 өдөр
БҮРТГЭВ
№ 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ 01
0000127

хэмжээг шинэчлэн тогтоох" тухай тогтоолын дагуу дүрмийн сангаа нэмэгдүүлэх шаардлагатай юм.

Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 355 дугаар тогтоолоор "Ердийн даатгалын компанийн дүрмийн сангийн доод хэмжээ 5 тэрбум байна" гэж тогтоон 2016 оны 12 сарын 31-ний өдрийн дотор биелүүлж ажиллахыг ердийн даатгалын компаниудад үүрэг болгосон. СЗХ нь улс орны эдийн засаг, бизнесийн орчин нөхцөл, даатгалын компаниудын санхүү, төлбөрийн чадварын байдлыг харгалзан 236 тоот тогтоолоор хэрэгжиж эхлэх хугацааг 2018 оны 06 сарын 30-ны өдөр болгон сунгасан.

Иймд үнэт цаас гаргагч нь 7,500,000 ширхэг хувьцаа нэмж гаргаснаар СЗХ-ны дүрмийн сангийн шаардлагыг хангахаар байна.

Үнэт цаас гаргагчийн дүрмийн сан:

*Хүснэгт 62. Үнэт цаас гаргагчийн дүрмийн сангийн бүтэц*

| | Хувьцааны тоо | Нэрлэсэн үнэ /төг/ | Нийт дүн /төг/ |
|---|---|---|---|
| Дүрмийн сан /бүртгүүлэхээс өмнө/ | 17,500,000 | 200 | 3,500,000,000 |
| Шаардлагатай дүрмийн сан | 7,500,000 | 200 | 1,500,000,000 |
| *Үнэт цаас бүртгэсний дараах дүрмийн сан* | *25,000,000* | *200* | *5,000,000,000* |

Үнэт цаас гаргагчийн 2018 оны 05 сарын 8-ны өдрийн ТУЗ-ийн хурлын 07/18 тоот тогтоолоор хараат бус үнэлгээний байгууллага "БДО Аудит" ХХК-ийн бизнесийн үнэлгээг үндэслэн МХБ-д нэмж гаргах нэгж энгийн хувьцаа бүрийн үнийг 700 төгрөг байхаар тогтоосон.

Үнэт цаас гаргагч нь олон нийтээс татан төвлөрүүлэхээр тооцоолсон 5.25 тэрбум төгрөгийг СЗХ-ны холбогдох журмын дагуу хадгаламж, ББСБ-ын итгэлцэл, ЗГҮЦ, МХБ дээрх үнэт цаас, компанийн бонд, үл хөдлөх хөрөнгө, хөрөнгө оруулалтын сан зэрэг хэрэгслүүдэд хөрөнгө оруулалт хийхээр төлөвлөсөн.

Өмнөх жилүүдийн хөрөнгө оруулалтаас харвал үнэт цаас гаргагч нь СЗХ-ны "Ердийн даатгалын нөөц сан байгуулах, зарцуулах, түүнд хяналт тавих журам"-ын дагуу нөөц сан байгуулж холбогдох журам, тогтоолд заагдсан зохистой хэмжээний дагуу хөрөнгө оруулалтууд хийж ашигтай удирдаж ирсэн туршлагатай.

Тухайлбал, 2017 оноос өөрийн зэргэлдээ компани болох хөрөнгө оруулалтын сангийн удирдлагын үйл ажиллагаа эрхэлдэг Ард Менежмент ХХК-тай хамтын ажиллагаагаа эхлүүлэн

АРД ДААТГАЛ ХХК
МХБ-ийн гишүүн Андеррайтер Брокер дилерийн "БДСЕК" ҮЦК ХК
2018 05 11

Ард Даатгал ХХК-ийн хөрөнгө оруулалтын багцыг удирдах, компани дээр байгаа үл хөдлөх хөрөнгүүдийг удирдах, хувьцаа, засгийн газрын бонд, компанийн бонд зэрэгт хөрөнгө оруулалт хийх, удирдах ажлуудыг гүйцэтгэсэн байна.

Нөөц сангаас хийгдсэн хөрөнгө оруулалтыг СЗХ-ны "Ердийн даатгалын компанийн нөөц сангаас хөрөнгө оруулалт хийхэд тавигдах шаардлага"-д тусгагдсаны хөрөнгө оруулах хувь хэмжээний хязгаарт багтаан гүйцэтгэсэн бөгөөд дүрмийн сангаас МХБ дээрх I ангиллын хувьцаа, компанийн бонд, ЗГҮЦ, үл хөдлөх хөрөнгө, хугацаатай хадгаламжуудад байршуулан өндөр өгөөж хүртсэн байна.

*График 39. Үнэт цаас гаргагчийн хөрөнгө оруулалтын мэдээлэл /сая.төг/*




Сүүлийн 3 жилд үнэт цаас гаргагчийн оруулсан хөрөнгө оруулалт, түүнээс олох орлого тогтвортой өссөн нь графикаас харагдаж байна. Тухайлбал, 2015 онд хөрөнгө оруулалтын хэмжээ 2.67 тэрбум төгрөг байсан бол 2017 онд хөрөнгө оруулалтын хэмжээ 5.78 тэрбум төгрөг болж өссөн нь 3 жилийн дотор 112.7 хувиар өссөн үзүүлэлт юм. Мөн 2015 онд хөрөнгө оруулалтын олз нийт хөрөнгө оруулалтын 18.23 хувийг эзэлж байсан бол 2017 онд 24.2 хувийг эзэлж байна.

Иймээс үнэт цаас гаргагч нь эргэлтийн хөрөнгийн чөлөөт эх үүсвэрээ ашиглан үр ашигтай хөрөнгө оруулалтын хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийснээр өндөр өгөөж хүртэх, компанийн ашигт байдал нэмэгдэх, үнэ цэнийг нэмэгдүүлэх боломжтой.

Үнэт цаас гаргагч нь дараагийн 5 жилийн хугацаанд дараах санхүүгийн хэрэгслүүдэд хөрөнгө оруулалт хийхээр төлөвлөсөн:

*Хүснэгт 63. Хөрөнгө оруулалтын төлөвлөлт /сая.төг/*

| № | Хөрөнгө оруулалтууд | 2017 | БТ2018 | БТ2019 | БТ2020 | БТ2021 | БТ2022 |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Хадгаламж | 2,600.00 | 5,000.00 | 5,600.00 | 7,000.00 | 8,500.00 | 10,500.00 |
| 2 | ББСБ итгэлцэл | 60.00 | 550.00 | 750.00 | 1,300.00 | 2,300.00 | 3,500.00 |
| 3 | ЗГҮЦ | 1,386.40 | | 300.00 | 1,000.00 | 1,200.00 | 1,000.00 |
| 4 | МХБ дээрх үнэт цаас | 639.40 | 2,700.00 | 3,000.00 | 3,400.00 | 4,400.00 | 5,000.00 |

СЗХ 2018.08.29 БҮРТГЭВ № 01
0000129
МОНГОЛЫН ... MONGOLIAN STOCK EXCHANGE БҮРТГЭВ

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 5 | Компанийн бонд | 1,097.70 | 1,500.00 | 1,800.00 | 2,400.00 | 3,500.00 | 4,500.00 |
| 6 | Үл хөдлөх хөрөнгө | 1,800.00 | 1,800.00 | 1,800.00 | 800.00 | | 3,000.00 |
| 7 | Хөрөнгө оруулалтын сан | | 1,800.00 | 2,000.00 | 2,600.00 | 3,200.00 | 4,000.00 |
| | **Нийт хөрөнгө оруулалт** | **7,583.50** | **13,350.00** | **15,250.00** | **18,500.00** | **23,100.00** | **31,500.00** |

Нийт хөрөнгө оруулалтын дунджаар 35 хувийг хөрөнгийн зах зээлд, 36.4 хувийг банкны салбарт, 7.4 хувийг банк бус санхүүгийн салбарт, үлдэх хувийг үл хөдлөх хөрөнгө болон хөрөнгө оруулалтын санд байршуулахаар төлөвлөжээ.

*Хүснэгт 64. Үйл ажиллагааны үзүүлэлтийн төлөвлөлт*

| /сая.төг/ | БТ2018 | БТ2019 | БТ2020 | БТ2021 | БТ2022 |
|---|---|---|---|---|---|
| **Цэвэр ашиг** | **1,643.03** | **2,363.36** | **3,911.83** | **5,856.37** | **8,249.20** |
| **Нийт хураамжийн орлого** | **13,000.00** | **15,921.84** | **20,106.72** | **24,793.74** | **31,245.23** |
| Нийт нөхөн төлбөр | 3,501.60 | 4,204.67 | 5,309.82 | 6,591.15 | 8,269.61 |
| Нийт хөрөнгө оруулалт | 13,350.00 | 15,250.00 | 18,500.00 | 23,100.00 | 31,500.00 |
| Нийт хөрөнгө оруулалтын орлого | 1,400.00 | 1,900.00 | 2,500.00 | 3,000.00 | 4,000.00 |
| Цэвэр ашгийн маржин | *13%* | *15%* | *19%* | *24%* | *26%* |
| EPS | *65.72* | *94.53* | *156.47* | *234.25* | *329.96* |
| Үнэ ашгийн харьцаа P/E | *10.65* | *7.40* | *4.47* | *2.99* | *2.12* |

Үнэт цаас гаргагч нь дээрх төлөвлөлтийн дагуу хөрөнгө оруулалтын орлогыг жил бүр өсгөсөөр 2022 онд 4 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын орлого төвлөрүүлэхээр байна. Энэ нь 2018 онтой харьцуулахад 185.7 хувийн өсөлт юм.

# ГУРАВ. ҮНЭТ ЦААС ГАРГАХ АЖИЛЛАГААНД ОРОЛЦСОН ЭТГЭЭДИЙН ТУХАЙ

## 3.1. Аудитын компанийн танилцуулга, тусгай зөвшөөрөл

| | |
|---|---|
| Компанийн нэр: | "Далайван Аудит" ХХК |
| Улсын бүртгэлийн дугаар: | 9018001041 |
| Регистрийн дугаар: | 2018365 |
| Үйл ажиллагааны чиглэл: | - Аудитын үйл ажиллагаа /6920/<br>- Хөрөнгийн үнэлгээ /6820/<br>- Бизнесийн зөвлөгөө /8299/ |
| Хаяг: | Улаанбаатар хот, Баянгол, 16-р хороо, амарсанаа, 5, "Далайван Аудит" ХХК-ийн байр |

СЭХ 2018.08.29-ний өдөр БҮРТГЭВ № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 0000132 БҮРТГЭВ 01 ....... он .... сар .... өдөр

Утас: 70005401

## Танилцуулга

“Далайван Аудит” ХХК нь 1993 онд байгуулагдсан Монголын анхны аудитын компани бөгөөд үүсгэн байгуулагдсанаас өнөөг хүртэл 20 гаруй жилийн хугацаанд аудитын салбарт манлайлагч, тэргүүлэгч байр сууриа хадгалж, Монголын аудитын салбарыг бэхжүүлэх, хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох, мэргэжлийн байгууллагуудын үндэс суурийг тавьж, хөгжүүлэхэд хувь нэмэр оруулж ирсэн.

2007 онд Олон улсын хэмжээнд 8-д жагсдаг дэлхийн 131 улс орны 161 гишүүн байгууллагыг нэгтгэсэн аудит, нягтлан бодох бүртгэл, бизнесийн зөвлөх үйлчилгээний топ сүлжээ “Бэйкер Тилли Интернэшнл” (Baker Tilly International)-ийн Монгол улсыг төлөөлөх хараат бус бие даасан гишүүн болж өргөн цар хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байна.

“Бэйкер Тилли Интернэшнл” нь хараат бус бие даасан гишүүн байгууллагуудаа мэргэжил арга зүйн дэмжлэгээр хангаж Дэлхийн болон Ази Номхон далайн бүсийн хурал, семинарыг жил бүр тогтмол зохион байгуулж, шинэ мэдлэг мэдээлэл туршлагыг түгээж, олон улсын хэмжээнд зөвлөх үйлчилгээнүүдийг хамтран гүйцэтгэж байна. Энэ нь “Далайван Аудит” ХХК-ийн давуу тал, олон улсын төвшинд танигдах боломжийг нээсээр байна.

“Далайван Аудит” ХХК нь дараах үйлчилгээг харилцагчиддаа үзүүлдэг:

1. Аудит ба баталгаажуулах үйлчилгээ
   - санхүүгийн тайлангийн аудит,
   - худалдан авалтын аудит,
   - залилангийн аудит,
   - татварын зарга маргааны аудит,
   - гүйцэтгэлийн аудит,
   - төслийн санхүү ба хэрэгжилтийн аудит,
   - хяналт шалгалт,
   - шүүхийн шинжээчээр ажиллах үйлчилгээ,
2. Нягтлан бодох бүртгэлийн зөвлөх үйлчилгээ
   - Санхүүгийн тайлан гаргах талаар зөвлөх
   - Санхүүгийн тайланг СТОУС, холбогдох журам зааврын дагуу бэлтгэх талаар зөвлөх

ARD INSURANCE COMPANY АРД ДААТГАЛ ХХК 2062089 УЛААНБААТАР ХОТ

УЛААНБААТАР ХОТ МХБ-ийн гишүүн Андеррайтер Брокер, дилерийн “БИДИСЕК” ҮЦК ХХК 2052482

2018 05-11

СЗХ
2018 .08. 29 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ
...... он .... сар .... өдөр 01
0000000131



- НББ-ийн бодлогын баримт бичиг боловсруулах

3. Компанийн засаглал ба эрсдэлийн удирдлагын үйлчилгээ
   - Дотоод аудитын үйлчилгээ
   - Дотоод хяналтын зөвлөх үйлчилгээ
   - Үйл ажиллагааны зөвлөх үйлчилгээ
   - Байгууллагын эрсдэлийн удирдлагын үйлчилгээ
4. Корпорацийн зөвлөх үйлчилгээ
   - Хөрөнгийн ба бизнесийн үнэлгээний үйлчилгээ
   - Бизнесийг хөгжүүлэх зөвлөх үйлчилгээ
   - Санхүүгийн эх үүсвэр олох үйлчилгээ
   - Шүүхийн зарга маргааныг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх үйлчилгээ
   - Компанийн дампуурал ба компанийг шинээр зохион байгуулах асуудалд зөвлөх үйлчилгээ
5. Татварын зөвлөх үйлчилгээ
   - Татварын тайлан бэлтгэж өгөх
   - Татварын асуудлаар зөвлөгөө өгөх

### Тусгай зөвшөөрөл

"Далайван Аудит" ХХК нь 2014 оны 01 сарын 28-ны өдөр 06 дугаар тушаалын дагуу 22-2015 дугаарт аудитын үйл ажиллагаа эрхлэх 3 жилийн хүчинтэй хугацаатай тусгай зөвшөөрлийн гэрчилгээг авсан. Сангийн сайдын 2017 оны 18 дугаар тушаалаар уг тусгай зөвшөөрлийг 2017 оны 01 сарын 28-ны өдрөөс 3 жилийн хугацаатай сунгасан.

2014 оны 01 сарын 29-ний өдрийн 23 дугаар СЗХ-ны тогтоолын дагуу Далайван Аудит ХХК нь үнэт цаасны зах зээлд оролцогчид аудитын үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийг шинэчлэн бүртгэх бүртгэлд багтсан байна.

## 3.2. Аудитын компанитай байгуулсан гэрээгээр хүлээсэн эрх, үүргийн тухай

Үнэт цаас гаргагч нь 2017 оны 12 дугаар сарын 19-ны өдөр 01/17-13 дугаартай санхүүгийн тайланд аудит хийх гэрээг "Далайван Аудит" ХХК-тай байгуулсан. Талууд гэрээний дагуу дараах эрх, үүрэгтэй хүлээнэ:

*Хүснэгт 65. Аудитын компанитай байгуудсан гэрээгээр хүлээсэн эрх, үүрэг*

| Ард Даатгал ХХК-ийн эрх | "Далайван Аудит" ХХК-ийн эрх, үүрэг |
|---|---|

ARD INSURANCE COMPANY
АРД ДААТГАЛ ХХК
ТТД380 рд.2062089
УЛААНБААТАР ХОТ

УЛААНБААТАР ХОТ
МХБ-ийн гишүүн Андеррайтер Брокер, дилерийн "БИДСЕК" ҮЦК ХК
1115205447 рд. 2052482

2018-05-11

| | |
|---|---|
| - Аудитын ажлын эцэст аудитороос зөвлөмж, дүгнэлт гаргуулах, эдгээртэй холбогдсон тайлбар өгөхийг шаардах<br>- Аудитын дүгнэлтийг зөвшөөрөхгүй бол энэ талаар холбогдох эрх бүхий байгууллагад гомдол гаргах<br>- Аудитын байгууллагыг гэрээгээр хүлээсэн үүргээ, зохих ёсоор биелүүлэхийг шаардах<br>- Аудитын ажлын төлөвлөгөөнд тусгагдсан гүйцэтгэх хугацаанд тайлагнахыг шаардах эрхтэй | - Үйлчлүүлэгчийг гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлэхийг шаардах<br>- Үйлчлүүлэгчээс аудитын ажлын холбогдолтой санхүүгийн баримт, компьютерийн файл мэдээллийг шаардаж авах, мөнгө, үнэт цаас, материал болон биет хөрөнгөнд хэсэгчилсэн тоолллого хийх, шалгалтын явцад гарсан аливаа асуудлаар шаардлагатай баримт, нотолгоо гаргуулах<br>- Үйлчлүүлэгчийн санхүүгийн тайлан, баримтыг баталгаажуулахтай шууд холбоотой бичиг баримт, мэдээлэл, тайлбарыг холбогдох санхүү, банкны болон бусад харилцагч аж ахуйн нэгж, байгууллагуудаас шаардан авч танилцах |
| **Ард Даатгал ХХК-ийн үүрэг** | **“Далайван Аудит” ХХК-ийн үүрэг** |
| - Санхүүгийн тайлангаа Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт болон Монгол улсын хууль, тогтоомж, бусад дүрэм, журамд нийцүүлэн бүрэн гаргаж аудитын байгууллагад гэрээний хавсралт дахь хугацаанд ирүүлсэн байх<br>- Компанийн санхүүгийн тайлан, санхүүгийн тайланд тодруулах мэдээлэл, тохируулгууд, тайлбарууд, санхүүгийн тайлангийн задаргаанууд бусад шинжилгээ анализ, мөн бүртгэлийн журнал, баримтууд гадаад болон дотоод удирдлагын тайлангууд, бусад шаардлагатай мэдээлэл | - Үйлчлүүлэгчийн жилийн эцсийн санхүүгийн тайланд аудиторын тайлан, зөвлөмж гаргах<br>- Аудитын үйл ажиллагааг Аудитын Олон Улсын Стандартад нийцүүлэн мөрдөгдөж байгаа хууль, эрх зүйн акт, заавар аргачлалуудын дагуу явуулах<br>- Аудитын байгууллага нь аудитын шалгалтаар алдаа дутагдал илэрсэн тохиолдолд үйлчлүүлэгчийн удирдлагад мэдээллэх, тайлагнах<br>- Аудитын тайлангийн үнэн зөвийг хариуцах, хугацаа хоцроосонтой холбоотой хариуцлага хүлээх |

СЗХ 2018.08.29 өдөр БҮРТГЭВ № 01

0000133 MONGOLIAN STOCK EXCHANGE БҮРТГЭВ 01

| | |
|---|---|
| тайлангууд болон аудитын үйлчилгээ үзүүлэхэд гуравдагч этгээдээс шаардагдах мэдээллийг тухай бүрд бүрэн гүйцэд цаг хугацаанд нь бүрдүүлж өгөх<br>- Аудитын багийн ажиллах тоног төхөөрөмж болон тухтай өрөөгөөр хангах | |

*Дараах материалуудыг үнэт цаасны танилцуулгын хавсралтаас үзнэ үү.*

- *"Далайван Аудит" ХХК-ийн улсын бүртгэлийн гэрчилгээ*
- *"Далайван Аудит" ХХК-ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн гэрчилгээ болон хавсралтын хуулбар*
- *СЗХ-ны ҮЦЗЗ-д оролцогчид аудитын үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийн бүртгэл*
- *Үнэт цаас гаргагч болон "Далайван Аудит" ХХК нарын байгуулсан гэрээний хуулбар*

## 3.3. Үнэлгээний компанийн танилцуулга, тусгай зөвшөөрөл

| | |
|---|---|
| Компанийн нэр: | "БДО Аудит" ХХК |
| Улсын бүртгэлийн дугаар: | 9018001010 |
| Регистрийн дугаар: | 2546442 |
| Үйл ажиллагааны чиглэл: | Аудитын үйл ажиллагаа /751300/ |
| Хаяг: | Улаанбаатар хот, СБД, 1-р хороо, ЮНЕСКО-гийн гудамж, Нарны зам-62, ЮНИОН БЮЛДИНГ В-блок 15-р давхар, 1502 тоот |
| Утас: | 77404040, 77404041 |

### Танилцуулга

"БДО Аудит" ХХК нь аудит, нягтлан бодох бүртгэл, зөвлөх үйлчилгээний дэлхийн тав дахь том сүлжээ юм. БДО-ийн дэлхий даяарх 60,000 гаруй ажилчид дэлхийн 152 орон дахь 1,328 салбар оффисоороо дамжуулан харилцагчидтайгаа хамтран ажилладаг байна.

БДО сүлжээ нь 1963 онд мэдлэг туршлага солилцон, өргөжүүлж харилцагчдад илүү сайн үйлчилгээ үзүүлэхийн тулд Их Британий Нэгдсэн Вант Улс болон Канадын байгууллагууд нэгдсэнээр анх үүсгэн байгуулагдсан юм. БДО нь Бейндер Дикер Отте & Ко гэж нэрээ

ARD INSURANCE COMPANY АРД ДААТГАЛ ХХК УЛААНБААТАР ХОТ

УЛААНБААТАР ХОТ МХБ-ийн гишүүн Андеррайтер, брокер, дилерийн "БИДИСИ" ҮЦК ХК 1115205447 ш. 2052482

СЗХ 2018.08.29 өдөр БҮРТГЭВ № 01
0000134 БҮРТГЭВ 01

солихоос өмнө 1973 он хүртэл бид Бейндер Сайдман Интернэйшл гэдэг нэрээр дэлхийд танигдсан.

БДО-ийн Монгол дахь оффис 2012 оны 12 сард Улаанбаатар хотноо БДО Монгол нэртэйгээр Монгол улсын аудит, нягтлан бодох бүртгэл, зөвлөх үйлчилгээний салбарт 15 жилийн туршлагатай "Итгэлт Аудит" ХХК-ийн суурин дээр үүсгэн байгуулагдсан. "БДО Аудит" ХХК нь чиглэл чиглэлээр мэргэшсэн зэрэг, цолтой 2 партнер, 40 орчим мэргэжилтнүүд бүхий чадварлаг багийн туршлага, мэдлэгээр дамжуулан үйлчлүүлэгчдийн бизнесийг дэмжин ажилладаг байна.

Үнэлгээ ба шинжилгээ, аудит ба баталгаажуулалт, дотоод, гадаад аутсорсинг, бизнесийн зөвлөх үйлчилгээ, татвар ба хууль зүйн зөвлөх үйлчилгээ зэрэг үйлчилгээг үйлчлүүлэгчиддээ үзүүлж, хамтран ажилладаг байна.

"БДО Аудит" ХХК нь Санхүүгийн Зохицуулах Хорооноос тавигддаг шаардлагыг хангаж, дараах салбарт ажиллах жагсаалтад бүртгэгдсэн. Үүнд:

- Монголын үнэт цаасны зах зээл дээр үнэт цаас гаргагчдад аудитын үйлчилгээ үзүүлэх
- Монголын үнэт цаасны зах зээл дээр үнэт цаас гаргагчдад хөрөнгийн болон бизнесийн үнэлгээний үйлчилгээ үзүүлэх
- Даатгалын байгууллагад аудитын үйлчилгээ үзүүлэх

СЗХ–ны 2014 оны 01 сарын 29-ний өдрийн 22 тоот "Үнэт цаасны зах зээлд оролцогчид хөрөнгийн үнэлгээний үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийг шинэчлэн бүртгэх тухай" тогтоолоор "БДО Аудит" ХХК–ийг үнэт цаасны зах зээлд оролцогчдод хөрөнгийн үнэлгээний үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдээр бүртгэсэн байна.

## Тусгай зөвшөөрөл

"БДО Аудит" ХХК-д Сангийн сайдын 2012 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 287 тоот тушаалаар 3 жилийн хугацаатайгаар аудитын үйл ажиллагаа эрхлэх 009-1997 дугаартай тусгай зөвшөөрлийн гэрчилгээг олгосон байна. Сангийн сайдын 2015 оны 325 дугаар тушаалаар энэхүү тусгай зөвшөөрлийг 2015 оны 12-р сарын 27-ны өдрөөс 3 жилийн хугацаагаар сунгажээ.

*Хүснэгт 66. Үнэлгээчдийн тусгай зөвшөөрөл*

**Үнэлгээчдийн хөрөнгийн үнэлгээ хийх тусгай зөвшөөрөл**

2018 05 11

СЗХ
2018.08.29 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ 01
0000135

| Овог нэр | Гэрчилгээний дугаар | Сунгасан хугацаа |
|---|---|---|
| Г.Баянмөнх | 07120001 | 2017 оны 01 сарын 11-ний өдрөөс 3 жилийн хугацаатай сунгасан байна |
| Ж.Энхчимэг | 017200053 | 2017 оны 01 сарын 11-ний өдрөөс 3 жилийн хугацаатай сунгасан байна |

Г.Баянмөнх нь 2015 оны 12 сарын 23-ны өдөр Монголын мэргэшсэн үнэлгээчдийн институтаас тэргүүлэх үнэлгээчний зэрэг авч батламжлан 07 дугаарт гэрчилгээг авсан байна.

## 3.4. Үнэлгээний компанитай хийсэн гэрээгээр хүлээсэн эрх үүрэг

Үнэт цаас гаргагч нь 2018 оны 03 сарын 11-ний өдөр хөрөнгийн болон бизнесийн үнэлгээ хийх гэрээг "БДО Аудит" ХХК-тай байгуулсан. Талууд гэрээний дагуу дараах эрх, үүргийг хүлээнэ:

*Хүснэгт 67. Үнэлгээний компанитай хийсэн гэрээгээр хүлээсэн эрх, үүрэг*

| Ард Даатгал ХХК-ийн эрх | "БДО Аудит" ХХК-ийн эрх |
|---|---|
| - Үнэлгээний байгууллагаас гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлэх, энэхүү Гэрээгээр харилцан тохирсон нөхцөл, шаардлага болон холбогдох хууль, журмын шаардлагад нийцсэн үнэлгээ хийх, тайлан гаргахыг шаардах<br>- Үнэлгээний байгууллага Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, үйлчлүүлэгчийн итгэлийг эвдсэн аливаа үйлдэл хийсэн тохиолдолд Гэрээнээс татгалзах<br>- Гэрээнд заасан бусад эрхийг хэрэгжүүлнэ | - Үйлчлүүлэгчээс Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах, хууль болон энэхүү Гэрээгээр тогтоосон нөхцөлийг зөрчсөн Үйлчлүүлэгчийн аливаа шаардлагыг биелүүлэхээс татгалзах<br>- Үйлчлүүлэгчийн буруутай үйл ажиллагаанаас шалтгаалж Гэрээг цуцлах болон Үйлчлүүлэгч гэрээнд заасан үндэслэлээс өөр шалтгаанаар гэрээг дангаар цуцалсан болон үнэлгээний байгууллагын буруутай биш шалтгаанаар ажлын сул зогсолт үүссэн тохиолдолд гүйцэтгэсэн ажлын зардлыг нэхэмжлэх бөгөөд энэхүү нэг өдөрт ногдох нэхэмжлэх зардлын хамгийн бага хэмжээ 2,000,000 төгрөг байна |

ARD INSURANCE COMPANY
АРД ДААТГАЛ ХХК
УЛААНБААТАР ХОТ

УЛААНБААТАР ХОТ
МХБ-ийн гишүүн Андеррайтер Брокер, Дилерийн "БИДСЕК" ХК
1115205447

2018-05-11

СЗХ 2018.08.29 өдөр БҮРТГЭВ № 01
0000136 МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE БҮРТГЭВ 01

| | |
|---|---|
| | - Гэрээт ажлын үр дүнгийн талаар үйлчлүүлэгчид ямарваа байдлаар амлалт, баталгаа өгөхгүй байх /үнэлгээний үр дүнд гарах мөнгөн дүнг урьдчилан тодорхойлж, түүндээ хөтлөгдсөн үнэлгээ хийхгүй байх/ |
| Ард Даатгал ХХК-ийн үүрэг | "БДО Аудит" ХХК-ийн үүрэг |
| - Гэрээт ажилтай холбоотой Компанийн бизнес төлөвлөгөө, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, удирдлагын дотоод мэдээлэл зэрэг бүхий л мэдээлэл, шаардлагатай нэмэлт баримт, материалыг шаардсан тухай бүрт нь бүрэн гүйцэт, үнэн зөв гаргаж өгөх бөгөөд гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгэхэд нь шаардагдах бүх талын дэмжлэг үзүүлэх<br>- Үнэлгээний байгууллагыг өөрийн байранд нэвтрэх, уулзалт хийх, дүгнэлт гаргахад шаардлагатай холбогдох мэдээллийг авах, шалгах ажлыг гүйцэтгэх орчноор хангах, тухайн мэдээлэл, баримтыг хариуцсан ажилтнуудыг томилж ажиллуулах, мэдээ, материал, түүний агуулгыг тодорхойлоход туслах зэрэг ажлыг үнэн зөв, цаг хугацаанд нь гүйцэтгэхэд шаардалагатай бусад ажлыг зохион байгуулах<br>- Үйлчлүүлэгч нь Үнэлгээний байгууллагад нэр төр, ажил хэргийн | - Үйлчлүүлэгчийн хөрөнгийн болон бизнесийн үнэлгээ хийх, холбогдох ажиллагаа хийх бүрт тэмдэглэл хөтлөх, ажлын явц үр дүн, гарч болох эрсдэл, нөхцөл байдлын талаар шуурхай мэдээлэл өгөх<br>- Гэрээт ажлыг гүйцэтгэх явцад аливаа байдлаар сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал бий болсон даруйд үйлчлүүлэгчид мэдэгдэх<br>- Үйлчлүүлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлын эсрэг аливаа үйлдэл хийхгүй байх үүрэгтэй бөгөөд үйл ажиллагаандаа холбогдох хууль тогтоомж, энэхүү гэрээний нөхцлийг чанд мөрдөх<br>- Гэрээнд заасан бусад үүргийг хүлээнэ |

ARD INSURANCE COMPANY АРД ДААТГАЛ ХХК ТТН380 № 2062089 УЛААНБААТАР ХОТ
УЛААНБААТАР ХОТ ХХБ-ийн гишүүн Андеррайтер Брокер, дилерийн "БИДИЕСЕК" ҮЦК ХХК 1115205447 № 2052482
2018-05-11

СЗХ
2018.08.29
БҮРТГЭВ
№ 01

0000137

| | |
|---|---|
| нэр хүндэд нь харш үйлдэл хийх,<br>Үнэлгээний байгууллагыг ашиг сонирхлын зөрчил, хараат байдалд хүсэлт, шаардлага гаргахгүй байх<br>- Гэрээнд заасан бусад үүргийг хүлээнэ | |

## 3.5. Хөрөнгө болон бизнесийн үнэлгээний тайлан, дүгнэлт

*Бизнесийн үнэлгээ*

2018 оны 02 сарын 27-нд "БДО Аудит" ХХК болон Ард Даатгал ХХК нарын хооронд байгуулсан гэрээний дагуу "БДО Аудит" ХХК нь 2017 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болгон Ард Даатгал ХХК-ийн ердийн даатгалын үйл ажиллагааг хамарсан бизнесийн 100 хувийн хувь оролцоог үнэлж, бизнесийн үнэлгээний тайлан болон хөрөнгийн үнэлгээний тайланг хийж гүйцэтгэсэн байна. Үнэлгээний зорилго нь хөрөнгийн зах зээлд анх удаа олон нийтэд хувьцаа санал болгон арилжих (IPO)-д зориулж Ард Даатгал ХХК-ийн бизнесийн зах зээлийн үнэ цэнийг үнэлгээний өдрөөр тодорхойлох юм.

"БДО Аудит" ХХК нь "Бизнесийн зах зээлийн үнэ цэнийг тооцоолохдоо зах зээлийн хандлага ба орлогын хандлагыг авч үзсэн ба зах зээлийн хандлагын үнэлгээнд жишиг компанийн арга зүй, жишиг арилжааны арга зүй, орлогын хандлагын үнэлгээнд хорогдуулсан мөнгөн урсгалын загварыг удирдлагын төсөөлөлд үндэслэн тооцсон. Бид мэргэжлийн багийн түвшинд шүүн тунгааж хорогдуулсан мөнгөн урсгалын аргын үр дүн нь үнэлгээний өдрийн байдлаар бизнесийн зах зээлийн үнэ цэнийг илүү сайн төлөөлж чадна. Бизнесийн 100 хувийн өмчийн хувь оролцоонд ногдох зах зээлийн үнэ цэнэ 18,910,026 - 20,371,190 мянган төгрөг байх үндэслэлтэй байна " гэж дүгнэжээ.

Үнэлгээний өдрийн байдлаар Ард Даатгал ХХК нь:

- Мөнгө ба мөнгөтэй адилтгах хөрөнгө - 793,306 мянган төгрөг
- Хадгаламжийн сертификат - 2,660,000 мянган төгрөг
- Засгийн газрын болон корпорацийн үнэт цаас – 3,123,659 мянган төгрөгтэй байгаа бөгөөд санхүүгийн өр төлбөргүй байна.

2018-05-11

D000138
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ 01
СЗХ 2018.08.29 БҮРТГЭВ № 01



Үнэлгээчид бизнесийн зах зээлийн үнэ цэнийг тооцохдоо зах зээлийн хандлага, орлогын хандлага, тохируулсан цэвэр активын аргыг авч ашигласан ба зах зээлийн хандлагын үед жишиг компанийн арга зүй болон жишиг арилжааны арга зүйг, орлогын хандлагыг үед удирдлагын төсөөлөлд үндэслэн хорогдуулсан мөнгөн урсгалыг загварыг ашиглаж тус бүрд нь үнэлгээг олоход дараах байдалтайгаар гарсан байна.

*Хүснэгт 68. Бизнес үнэлгээний аргуудын харьцуулалт*

***Үнэлгээний үр дүнгүүдийн харьцуулалт***

| Үнэлгээний арга хандлага | /мян.төгрөг/ |
|---|---|
| Жишиг арилжааны арга | 23,660,980 |
| Жишиг компанийн арга | 23,078,912 |
| Хорогдуулсан мөнгөн урсгал | 20,371,190 |
| Тохируулсан цэвэр активын арга | 4,404,517 |

Хорогдуулсан мөнгөн урсгалын загварын үед мөнгөн урсгалын тооцооллыг хийхдээ үнэлгээчид нь удирдлагаас ирүүлсэн дунд хугацааны бизнесийн төлөвлөгөөнд үндэслэсэн ба хорогдуулах хүүний тооцооллыг өөрсдийн шинжилгээгээр 23.0 хувиас 24.0 хувь байхаар тооцсон. Үүн дээр нэмээд дараах арга зүй, параметрүүдийг мөнгөн урсгалын төсөөлөлд ашигласан:

- Бизнесийн үлдэх үнэ цэнэ буюу эцсийн мөнгөн урсгалыг Гордоны тогтмол өсөлтийн загвар ашиглан тодорхойлсон.
- Урт хугацааны өсөлтийн параметрийг сонгохдоо Сангийн яам-ны урт хугацааны эдийн засгийн өсөлтийн судалгаанд тодорхойлсон 3.6 хувиас 5.6 хувь байхаар сонгон авсан.
- Урт хугацааны хүлээгдэж буй инфляци 6.5 хувь байна.
- Хувьцаат капиталын цэвэр дансны үнэ таамагласан хугацааны туршид өөрчлөгдөхгүй гэж таамагласан
- Хорогдуулах хүүний үеийг дундаж үеийн аргаар тооцсон.

Хорогдуулсан мөнгөн урсгалын загварын үр дүнгээс үзэхэд үнэлгээний өдрийн бизнесийн үнэ цэнэ дараах байдалтайгаар гарсан байна.

1. *Сонгосон хорогдуулах хүү болох 23%-иар тооцох үед:*

*Хүснэгт 69. Үнэ цэнийн тооцоолол 23%-иар*

| Үнэ цэнийн тооцоолол | ТЖ18Т | ТЖ19Т | ТЖ20Т | ТЖ21Т | ТЖ22Т |
|---|---|---|---|---|---|
| Тасралттай мөнгөн урсгал | 837,404 | 349,179 | 1,695,695 | 3,316,137 | 5,310,117 |

ARD INSURANCE COMPANY УЛААНБААТАР ХОТ 2062089
УЛААНБААТАР ХОТ МХБ-ийн гишүүн Андеррайтер Брокер, дилерийн үйл ажиллагаа эрхлэх ҮЦК 2052482
2018 05 11

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| Тасралтгүй мөнгөн урсгал | | | | | 28,348,291 |
| Хорогдуулах үе | 0.50 | 1.50 | 2.50 | 3.50 | 4.50 |
| Хорогдуулах хүчин зүйл | 0.90 | 0.73 | 0.60 | 0.48 | 0.39 |
| Хорогдуулсан дискрет мөнгөн урсгал | 754,792 | 255,843 | 1,010,317 | 1,605,263 | 2,089,593 |
| Хорогдуулсан эцсийн мөнгөн урсгал | | | | | 11,155,382 |
| 100%-ийн оролцооны үнэ цэнэ (мян төгрөг) | | | | | **20,371,190** |
| 100%-ийн хувь оролцооны үнэ цэнэ (мян ам доллар) | | | | | 8,393 |

2. *Хорогдуулах хувийн дээд хязгаар болох 24%-иар тооцох үед:*

*Хүснэгт 70. Үнэ цэнийн тооцоолол 24%-иар*

| Үнэ цэнийн тооцоолол | ТЖ18Т | ТЖ19Т | ТЖ20Т | ТЖ21Т | ТЖ22Т |
|---|---|---|---|---|---|
| Тасралттай мөнгөн урсгал | 802,404 | 261,679 | 1,608,195 | 3,228,637 | 5,222,617 |
| Тасралтгүй мөнгөн урсгал | | | | | 26,514,975 |
| Хорогдуулах үе | 0.50 | 1.50 | 2.50 | 3.50 | 4.50 |
| Хорогдуулах хүчин зүйл | 0.90 | 0.72 | 0.58 | 0.47 | 0.38 |
| Хорогдуулсан дискрет мөнгөн урсгал | 720,316 | 189,415 | 938,987 | 1,519,214 | 1,981,601 |
| Хорогдуулсан эцсийн мөнгөн урсгал | | | | | 10,060,493 |
| 100%-ийн оролцооны үнэ цэнэ (мян төгрөг) | | | | | **18,910,026** |
| 100%-ийн хувь оролцооны үнэ цэнэ (мян ам доллар) | | | | | 7,791 |

## *Хөрөнгийн үнэлгээ*

**Хөдлөх үндсэн хөрөнгө**

"БДО Аудит" ХХК-ийн зүгээс Ард Даатгал ХХК-ийн үл хөдлөх хөрөнгөөс бусад хөдлөх үндсэн хөрөнгийг элэгдэл тооцсон нөхөн оруулах өртгийн аргаар шинжилсний үндсэн дээр дансны үнэ цэнэ нь аливаа үнэ цэнийн бууралт агуулаагүй байна гэсэн дүгнэлтэд хүрсэн. Үнэт цаас гаргагчийн хөдлөх үндсэн хөрөнгө:

- Тавилга эд хогшил – 24,126.8 мянган төгрөг
- Компьютер – 33,384.0 мянган төгрөг
- Тээврийн хэрэгсэл – 186,387.7 мянган төгрөгийн үнэ цэнэтэй байна.

**Үл хөдлөх хөрөнгийн үнэлгээний хувьд** "БДО Аудит" ХХК нь орлогын хандлагаас шууд капиталжуулах арга, зах зээлийн хандлагаас жишиг нэлттэй арилжааны аргыг сонгон ашигласан ба Ард Даатгал ХХК-ийн эзэмшиж буй аялал жуулчлалын зориулалттай үл хөдлөх хөрөнгө нь 815.839 мянган төгрөг, аж ахуйн зориулалттай үл хөдлөх хөрөнгө нь 800.302 мянган төгрөг төгрөгийн тооцоолсон зах зээлийн үнэ цэнэтэй байх үндэслэлтэй гэж дүгнэсэн байна.

*Хүснэгт 71. Хөрөнгийн үнэлгээний үр дүнгийн нэгтгэл*

| | ҮХХ-ийн гэрчилгээний дугаар | ҮХХ-ын хүлээн зөвшөөрсөн анхны өртөг | Ашиглалтад оруулсан огноо | Цаашид ашиглах хугацаа | Орлогын хандлагаар тооцсон үр дүн | Зах зээлийн хандлагаар тооцсон үр дүн | Тооцоолсон зах зээлийн үнэ цэнэ |
|---|---|---|---|---|---|---|---|
| Нийслэлийн Хан-Уул дүүргийн 11-р хороо, богины ам /17050/, Дүнжингарав гудамж, 406-р байр, 5 тоот-д байрлах Аялал жуулчлалын зориулалттай үл хөдлөх хөрөнгө | Ү-2206054238 | 1,000,000,000 | 10/1/2017 | 40 жил | 768,738,000 | 862,939,000 | 815,839,000 |
| Нийслэлийн Баянгол дүүргийн 5-р хороо, үйлдвэрийн төвийн бүс, Энхтайваны өргөн чөлөө гудамж, 90в-д байрлах Аж ахуйн нэгжийн зориулалттай үл хөдлөх хөрөнгө | Ү-2205056077 | 800,000,000 | 10/1/2017 | 40 жил | 733,974,000 | 866,629,000 | 800,302,000 |

*Дараах материалуудыг үнэт цаасны танилцуулгын хавсралтаас үзнэ үү.*

- *"БДО Аудит" ХХК-ийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар*
- *"БДО Аудит" ХХК-ийн аудитын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар, үнэлгээчдийн тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар*
- *ҮЦЗЗ дээр хөрөнгийн үнэлгээ хийх хуулийн этгээдээр бүртгэгдсэн тухай СЗХ-ны тогтоолын хуулбар*
- *Үнэт цаас гаргагч болон "БДО Аудит" ХХК нарын байгуулсан гэрээний хуулбар*

## 3.6. Хуулийн компанийн танилцуулга, тусгай зөвшөөрөл

| | |
|---|---|
| Компанийн нэр: | "Өмгөөллийн ИЭлСи" ХХН |
| Улсын бүртгэлийн дугаар: | 9022001046 |
| Регистрийн дугаар: | 5765412 |
| Үйл ажиллагааны чиглэл: | Хууль зүйн зөвлөгөө, туслалцаа, өмгөөллийн үйл ажиллагаа /6910/ |
| Хаяг: | Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Гэндэнгийн гудамж 16, Ардчиллын Өргөө, 6 давхар |
| Утас: | 77118193, 77118194 |

СЗХ 2018 08. 29 БҮРТГЭВ № 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE БҮРТГЭВ 01 ...... он .... сар .... өдөр
0000141

## Танилцуулга

Өмгөөллийн ИЭлСи ХХН нь 2000 онд байгуулагдсан, Монгол Улсад хэрэгжүүлж буй дэд бүтэц, ашигт малтмал, барилга угсралтын төслүүдэд бизнесийн бүтэц, санхүүжилт, зээл, татвар, зөвшөөрөл болон бусад асуудлаар зөвлөх үйлчилгээ үзүүлдэг мэргэшсэн 30 гаруй хуульч, өмгөөлөгчдөөс бүрдсэн томоохон хуулийн фирмүүдийн нэг юм.

Дан ганц бизнесийн зөвлөх үйлчилгээ төдийгүй хуулийн төсөл боловсруулах, гадны санхүүжүүлэгч байгууллагуудаас хэрэгжүүлдэг, нийгмийн хөгжилд чиглэсэн төслүүдэд зөвлөхөөр ажиллаж, дотоодын болон олон улсын шүүхийн болон арбитрын хэргүүдэд өмгөөллийн үйлчилгээ үзүүлж байна.

Тус нөхөрлөл нь Англид төвтэй, олон улсын хуулийн фирмийн рэйтинг тогтоодог Чамберс энд Партнерсийн 2015 оны “Монголын тэргүүлэх хуулийн фирм”, дэлхийн шилдэг 500 хуулийн фирмийг нэрлэдэг “Legal 500”-аас 2015 болон 2016 оны “Монгол Улсын Шилдэг хуулийн фирм”, Монгол Хуульчдын Холбооны 2017 оны “Монголын Шилдэг Өмгөөллийн Нөхөрлөл”-өөр тус тус шалгарсан.

Санхүүгийн Зохицуулах Хорооноос үнэт цаасны зах зээлд оролцогчдод хууль зүйн зөвлөгөө, үйлчилгээ үзүүлэх эрх авсан хамгийн анхны өмгөөллийн нөхөрлөл юм.

## Тусгай зөвшөөрөл

*Хүснэгт 72. Өмгөөллийн ИЭлСи ХХН-ийн тусгай зөвшөөрөл*

| Өмгөелллийн нөхөрлөлийн тусгай зөвшөөрөл | | |
|---|---|---|
| Гэрчилгээ олгосон огноо | Гэрчилгээний дугаар | Эрхлэх үйл ажиллагаа |
| 2006 оны 02 сарын 15 | 1108 | Өмгөөллийн үйл ажиллагаа |
| 2014 оны 01 сарын 29 | 24 | ҮЦЗЗ-д оролцогчид хууль зүйн зөвлөгөө үзүүлэх |

*Хүснэгт 73. Өмгөөллийн ИЭлСи ХХН-ийн хуульчдын тусгай зөвшөөрөл*

| Хуульчдын тусгай зөвшөөрөл | | |
|---|---|---|
| Овог нэр | Шүүхэд төлөөлөх гэрчилгээний дугаар | ҮЦЗЗ-д оролцогчид үйлчилгээ үзүүлэх гэрчилгээний дугаар |
| Х.Баасанжаргал | 0049 | 13/23 |

ARD INSURANCE COMPANY ... ТАЙ ... 2062089 УЛААНБААТАР ХОТ
УЛААНБААТАР ХОТ МХБ-ийн гишүүн Андеррайтер Брокер, дилерийн “БИДИСЕК” ҮЦК ХК 1115205447 рд. 2052482

СЗХ 2018.08.29 БҮРТГЭВ № 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE БҮРТГЭВ 01
0000142

| | | |
|---|---|---|
| Х.Болорчимэг | 1085 | 17012 |
| Б.Нямцэрэн | 2070 | 17013 |
| С.Батчимэг | 2561 | 17014 |

## 3.7. Хуулийн компанитай хийсэн гэрээний тухай

Үнэт цаас гаргагч нь 2018 оны 03 сарын 12-ны өдөр “Өмгөөллийн ИЭлСи” ХХН-тай хууль зүйн үйлчилгээ үзүүлэх гэрээг байгуулсан. “Өмгөөллийн ИЭлСи” ХХН нь МХБ ТӨХК-ийн Үнэт цаасны бүртгэлийн журмын 2.2-д заасан доорх асуудлыг тусгахаар гэрээнд заагдсан байна.

- Үнэт цаас гаргагчийн улсын бүртгэл, татвар төлөгчийн болон нийгмийн даатгалын шимтгэл төлөгчийн бүртгэлтэй холбоотой зөрчил байгаа эсэх
- Компанийн дүрэм, ХК-ийн дүрмийн төсөл, бусад дотоод журмууд нь хууль тогтоомж, СЗХ-ноос баталсан “Монголын Засаглалын Кодекс”-т нийцсэн эсэх
- Үнэт цаас гаргагчийн гэрээ хэлцлүүд нь хууль тогтоомжид нийцэж байгаа эсэх, компанийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх үр дагавар байгаа эсэх
- Сүүлийн 1 жилийн дотор хийсэн их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцлийг хуульд заасан журмын дагуу байгуулсан эсэх
- Тусгай зөвшөөрөл, лиценз, зохиогчийн эрх, патент, бараа үйлчилгээний тэмдэг, газар эзэмших эрх нь хүчин төгөлдөр эсэх, тэдгээрийн хугацаа дуусах, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангах үүрэг хүлээсэн зэргээр үйл ажиллагаанд нь сөргөөр нөлөөлж болох нөхцөл байгаа эсэх
- Үнэт цаас, хөдлөх, үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрх нь хүчин төгөлдөр эсэх, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангах үүрэг хүлээсэн эсэх
- Үнэт цаас гаргагч нь КТХ-ийн 6.13-т заасан хуулийн этгээдийн нэгдэлд хамаарч байгаа бол толгой, охин, зэргэлдээ компанийн талаарх мэдээлэлд үндэслэн үнэт цаас гаргагч компанийн хяналтыг хэрэгжүүлэгч этгээд нь хэн болохыг тодорхойлох.

## 3.8. Хуулийн дүгнэлт

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 6 дугаар зүйлд зааснаар Ард Даатгал ХХК нь үнэт цаасаа нийтэд санал болгон худалдах гэж байгаатай холбогдуулан Санхүүгийн Зохицуулах Хорооны 2015 оны 408 дугаар тогтоолын Хавсралт "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 5 дугаарын зүйлийн 5.2.2 дахь заалтад заасан шаардлагын дагуу “Өмгөөллийн ИЭлСи” ХХН

ARD INSURANCE COMPANY АРД ДААТГАЛ ХХК УЛААНБААТАР ХОТ 2062089
УЛААНБААТАР ХОТ МХБ-ийн гишүүн Андеррайтер Брокер, дилерийн "БИДНИЙ" ҮЦК ХХК 2052482
2018 05 11

нь 2018 оны 3 сарын 12-ны өдрөөс Хууль зүйн үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулан ажиллаж, хараат бусаар хөндлөнгийн дүгнэлт гаргасан байна.

Хуулийн дүгнэлт нь дараах асуудлыг хамруулсан дүгнэлт гаргажээ. Үүнд:

**Нэг. Үнэт цаас гаргагч нь хуулийн дагуу үүсгэн байгуулагдаж, бүртгэгдсэн эсэх талаар:**

"Нэгтгэн дүгнэж үзвэл компаниин үүсгэн байгуулалт, компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө, үйл ажиллагааны чиглэл, хугацаа, хаяг, удирдлагын бүтэц, салбарууд нь холбогдох хууль тогтоомжийг зөрчөөгүй гэж дүгнэлээ"

**Хоёр. Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага, бусад эрх бүхий албан тушаалтан нь холбогдох хууль тогтоомж болон хорооноос баталсан "компанийн засаглалын кодекс"-т тавигдах шаардлага хангасан болон тэдгээрийн удирдах чадвар, дадлага туршлагын талаар:**

"Нэгтгэн дүгнэж үзвэл компанийн эрх бүхий албан тушаалтнууд нь Компанийн тухай хууль болон 2014 оны 05 сарын 7-ны өдрийн Санхүүгийн Зохицуулах Хорооны 162 тоот тогтоолоор батлагдсан Компанийн Засаглалын Кодекс-т заасан эрх бүхий албан тушаалтнуудад тавигддаг нийтлэг шаардлагыг хангасан байна. ТУЗ-ийн гишүүдийн бүтцэд эрх зүйч, эдийн засагч, нягтлан бодогч зэрэг мэргэжилтэй хувь хүмүүс байгаа нь Засаглалын кодексоор тавьсан шаардлага болох компанийн үйл ажиллагааг компанийн үйл ажиллагааг зохистой удирдах, хяналт тавихад нийцэхүйц аудит эсвэл нягтлан бодох бүртгэл, санхүү, хууль эрх зүйн, хөрөнгө оруулалтын чиглэлээр мэргэшсэн дадлага туршлага бүхий хувь хүмүүсээс бүрдсэн байх шаардлагыг хангасан байна гэж үзнэ"

**Гурав. Үнэт цаас гаргагчийн дүрэм, дотоод журмууд нь холбогдох хууль тогтоомж, хорооноос баталсан "компанийн засаглалын кодекс"-т нийцсэн эсэх талаар:**

"Нэгтгэн дүгнэж үзвэл Ард Даатгал ХХК-ийн дүрэм, хөдөлмөрийн дотоод журам болон бусад журмууд нь Монгол Улсын хууль тогтоомж, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан "Компанийн засаглалын кодекс"-т нийцсэн байна гэвч зарим нэгэн компанийн дүрмүүд дээр сайжруулах шаардлагатай юмс байна гэж зөвлөж байна"

**Дөрөв. Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд чухал ач холбогдол үзүүлэх бусадтай байгуулсан гэрээ, хэлцэл нь хууль тогтоомжид нийцэж байгаа эсэх талаар:**

ARD INSURANCE COMPANY АРД ДААТГАЛ ХХК ТТД 3380... 2062089 УЛААНБААТАР ХОТ

УЛААНБААТАР ХОТ МХБ-ийн гишүүн Андеррайтер Брокер дилерийн "БИДИСЕК" ҮЦК ХК 1115205447 ... 2052482

“Нэгтгэн дүгнэж үзвэл бусадтай байгуулсан давхар даатгалын гэрээ, даатгалын гэрээ, худалдан авах гэрээ, хамтран ажиллах гэрээ, ажил гүйцэтгэх гэрээ, хөдөлмөрийн гэрээ, үүргийн зөрчилтэй байгаа гэрээ, бусад гэрээ хэлцлүүд холбогдох хууль тогтоомжийг зөрчөөгүй байна гэвч хөдөлмөрийн гэрээ болон үүргийн зөрчилтэй гэрээнүүд дээр сайжруулах, нэмж тусгах хэрэгцээтэй зүйлс байна гэж дүгнэж байна”

**Тав. Сүүлийн 3 жилийн дотор хийсэн их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцлийг хуульд заасан журмын дагуу байгуулагдсан эсэх талаар:**

“Нэгтгэн дүгнэж үзвэл Ард Даатгал ХХК-ийн хувьд сүүлийн гурван жилийн хугацаанд их хэмжээний хэлцэл хийгдээгүй харин компанийн энгийн хувьцаа эзэмшигч болон компанийг төлөөлөх эрх бүхий албан тушаалтан зохих зөвшөөрлийг авалгүйгээр сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулсан байна гэвч хуульд заасан эрх бүхий этгээд хэлцлийг хүчин төгөлдөр бусад тооцуулахаар шүүхэд гомдол гаргаагүй учир 6 хэлцэл нь аль хэдийн гэрээний хугацаа дуусгавар болсон нөгөө 2 хэлцлийн хувьд ирээдүйд хөрөнгө оруулагчдын өмчийн эрхэд хохирол учруулахааргүй байна гэж дүгнэж байна.”

**Зургаа. Үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл, лиценз, зохиогчийн эрх, патент, бараа, үйлчилгээний тэмдгийн хүчин төгөлдөр эсэх, тэдгээрийн хугацаа дуусах цуцлагдах, үүргийн гүйцэтгэлийг хангуулах үүрэг хүлээсэн зэргээр үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд нь бодитой нөлөөлж болохуйц нөхцөл буй эсэх талаар:**

“Нэгтгэн дүгнэж үзвэл Ард Даатгал ХХК-ийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл нь хуулийн хувьд хүчин төгөлдөр байгаа бөгөөд тэдгээрийн хугацаа дуусах, цуцлагдах, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангах үүрэг хүлээгээгүй байна. Даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хугацаагүй олгохоор заасан тул салбаруудын гэрчилгээг СЗХ-ноос хугацаатай олгож уг хугацаа дууссан байгаа нь эдгээр гэрчилгээнүүдийн хүчин төгөлдөр байдалд нөлөөлөхгүй боловч салбаруудын үйл ажиллагааг хугацаагүй явуулахаар СЗХ-ноос гэрчилгээг шинэчлэн авахыг зөвлөж байна.”

**Долоо. Үнэт цаас, үл хөдлөх болон бусад эд хөрөнгө өмчлөх эрх нь хүчин төгөлдөр эсэх, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангах үүрэг хүлээсэн эсэх талаар:**

“Нэгтгэн дүгнэж үзвэл компанийн хөрөнгө нь Улсын бүртгэлийн ерөнхий газар, Эд хөрөнгийн бүртгэлийн газар, Нийслэлийн улсын бүртгэлийн газрын лавлагаагаар тодорхойлогдож байгаа ба компани нь аливаа нэгэн иргэн, хуулийн этгээд, татварын өмнө төлбөргүй, хугацаа хэтэрсэн зээл хүүгийн өргүй байна”

**Найм. Үнэт цаасыг бүртгүүлэх өргөдөл, танилцуулгад тусгагдсан мэдээлэл нь хүчин төгөлдөр баримтаар нотлогдож байгаа эсэх талаар:**

"Нэгтгэн дүгнэж үзвэл Ард Даатгал ХХК-ийн нэмж гаргах үнэт цаасны танилцуулга нь "Монголын Хөрөнгийн Бирж" ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны 1 сарын 25-ны өдрийн 2018/01 тоот тогтоолын хавсралтаар баталсан "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.3-т заасан үнэт цаасны танилцуулгад тусгагдсан байвал зохих мэдээллийн шаардлагагыг бүрэн хангасан гэж ирүүлсэн мэдээлэл, хүчин төгөлдөр баримтууд дээр үндэслэн дүгнэж байна"

**Ес. Компанийн толгой, охин, хараат, зэрэгцээ компанийн мэдээлэлд үндэслэн үнэт цаас гаргагч компанийн хяналтыг хэрэгжүүлэгч этгээдийг тодорхойлсон дүгнэлт:**

"Хууль зүйн дүгнэлтийн "Компанийн удирдлагын бүтцийн талаар" хэсэгт дурдсанаар Ард Даатгал ХХК-ийн нийт гаргасан хувьцаанаас Ард Санхүүгийн Нэгдэл ХК 1,422,537 ширхэг хувьцаа буюу нийт хувьцааны 95.31 хувь, Энержи интернэшнл капитал" ХХК 70,00 ширхэг хувьцаа буюу нийт хувьцааны 4.69 хувийг тус тус эзэмшиж байна.

Компанийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-ийг үндэслэвэл Ард Даатгал ХХК нь 95.31 хувийн хувьцаа эзэмшигч Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу үүсгэн байгуулагдсан Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн охин компани болно.

Компанийн тухай хуулийн 89 дүгээр зүйлийн 89.1-т сонирхлын зөрчил бүхий этгээдийг тодорхойлоход хэрэглэгддэг компанийн энгийн хувьцааны 20 буюу түүнээс дээш хувийг дангаараа, эсхүл нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа гэдэг шалгуурыг компанийн хяналтыг хэрэгжүүлэгч этгээдийг тогтоох шалгуур болгож үзвэл Ард Даатгал ХХК-ийн хяналтыг хэрэгжүүлэгч этгээд нь Ард Санхүүгийн Нэгдэл ХК байна."

*Дараах материалуудыг үнэт цаасны танилцуулгын хавсралтаас үзнэ үү.*

- *"Өмгөөллийн ИЭлСи" ХХН-ийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар*
- *"Өмгөөллийн ИЭлСи" ХХН-ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар, хуульчдын тусгай зөвшөөрлийн хуулбар*
- *ҮЦЗЗ дээр хууль зүйн зөвлөгөө үзүүлэх хуулийн этгээдээр бүртгэгдсэн тухай СЗХ-ны тогтоолын хуулбар*
- *Үнэт цаас гаргагч болон "Өмгөөллийн ИЭлСи" ХХН нарын байгуулсан гэрээний хуулбар*

## 3.9. Андеррайтер компанийн танилцуулга, тусгай зөвшөөрөл

| | |
|---|---|
| Компанийн нэр: | “БиДиСЕК ҮЦК” ХК |
| Улсын бүртгэлийн дугаар: | 9010001030 |
| Регистрийн дугаар: | 2052482 |
| Үйл ажиллагааны чиглэл: | Брокер, дилер, хөрөнгө оруулалтын зөвлөх, андеррайтер |
| Хаяг: | Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Залуучуудын өргөн чөлөө, 27/1, “Би Ди Сек ҮЦК” ХК-ийн төв байр. |
| Утас: | 976-11-313108, 976-11-323411 |

### Танилцуулга

Компани нь 1991 оны өмч хувьчлал явагдаж Хөрөнгийн зах зээлийн харилцаа бий болсон цагаас эхлэн өнөөдрийг хүртэл тасралтгүй үйл ажиллагаагаа явуулж ирсэн 26 жилийн туршлагатай компани юм.

“БиДиСЕК ҮЦК” ХК нь 2005 онд 32 дугаартай андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хуучнаар Үнэт Цаасны Хорооноос авч, 2007 онд Хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг Санхүүгийн Зохицуулах Хорооноос авснаар Монгол улсад анхны үнэт цаасны цогц үйлчилгээг үзүүлэгч үнэт цаасны компани болсон.

2011-2017 онуудад МХБ-ийн үнэт цаасны арилжааны нийт гүйлгээний 9-91 хувийг гүйцэтгэснээс 2012 онд хамгийн өндөр буюу үнэт цаасны гүйлгээний 91 хувийг гүйцэтгэсэн.

Мөн Монголын хөрөнгийн биржид шинээр хувьцаа гарган татан төвлөрүүлсэн санхүүжилтийн 40 хувьд, нэлттэй компанийн бондын 36 хувьд нь андеррайтерийн үйлчилгээ үзүүлэн ажилласан байна.

### Тусгай зөвшөөрөл

“БиДиСЕК ҮЦК” ХК-ийн 2005 онд хуучнаар Үнэт цаасны Хороо-ны шийдвэрээр 32 тоот андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 3 жилийн хугацаатай авсан ба улмаар Санхүүгийн Зохицуулах Хорооны 2008 оны 6 сарын 12 өдрийн 136 тоот тогтоолоор андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх эрхийг 3 жилийн хугацаатайгаар сунгасан. Мөн Санхүүгийн Зохицуулах Хорооны 170 тоот тогтоолоор 2011 оны 6 дугаар сарын 12-ны

өдрөөс 3 жилийн хугацаагаар андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх эрхийг сунгасан. 2013 оны 5 дугаар сарын 24-ны өдөр "Үнэт цаасны зах зээлийн тухай хууль" ийг шинэчлэн найруулж УИХ-аас баталсан бөгөөд үүнтэй холбоотой холбогдох журмууд шинэчлэгдэж андеррайтерийн тусгай зөвшөөрөл нь 3 жилийн хугацаагаар сунгагддаг байсан нь өөрчлөгдөн хугацаагүй болсон.

## 3.10. Андеррайтер компанийн хийсэн гэрээгээр хүлээсэн эрх, үүрэг

Үнэт цаас гаргагч нь 2018 оны 03 сарын 21-ний өдөр "БиДиСЕК ҮЦК" ХК-тай 02 дугаартай андеррайтерийн гэрээ байгуулсан. Гэрээний дагуу талууд дараах эрх, үүргийг эдлэнэ:

**Андеррайтер компанийн эрх, үүрэг:**

- Андеррайтер нь Гэрээний 3.1-т заасан үйл ажиллагааг мэргэжлийн түвшинд хийж гүйцэтгэнэ.
- Андеррайтер нь Гэрээнд заасан үйл ажиллагаатай холбогдуулан Үнэт цаас гаргагчид мэргэжлийн зөвлөгөөг өгч, Үнэт цаасны танилцуулга бэлтгэх, холбогдох журам, заавар боловсруулах, шийдвэр гаргахад хамтран ажиллана.
- Үнэт цаас гаргагчийн хэрэгжүүлж буй үйл ажиллагаатай холбогдон гаргах шаардлагатай тогтоол, шийдвэрийн төсөл, загварыг бэлтгэн өгөх үүрэгтэй.
- Мэдээлэл түгээх арга хэрэгслийг сонгох, аргачлалыг боловсруулах ба мэдээллийг үнэн, бодитой, үнэ цэнэтэй байлгахад анхаарч ажиллана.
- Үнэт цаас гаргагчийн шинэ хувьцаа эзэмшигчдэд үнэт цаасны данс нээх, хувьцааг байршуулах ажлыг зохион байгуулах зэргээр брокерийн үйлчилгээ үзүүлэх үүрэгтэй.
- Андеррайтер нь Үнэт цаас гаргагчийг хөрөнгийн зах зээлтэй холбоотой боломжит бүхий л мэдээллээр хангаж, зөвлөгөө өгч ажиллана.
- Татан төвлөрүүлсэн хөрөнгөтэй холбоотой мэдээлэл, баримт судалгааг тухай бүрд нь гарган өгнө.
- Гэрээт ажлын асуудлаар Үнэт цаас гаргагчид зөвлөгөө өгч буй аудит, үнэлгээний болон бусад хөндлөнгийн байгууллага, хуулийн зөвлөх байгууллагатай хамтран ажиллаж, шаардлагатай арга хэмжээг шуурхай шийдвэрлэх үүрэгтэй.

**Үнэт цаас гаргагчийн эрх, үүрэг:**

- Үнэт цаас гаргагч нь дараах үйл ажиллагааг Андеррайтераар гүйцэтгүүлнэ. Үүнд:

- Үнэт цаас гаргагчийн хувьцааг Монголын Хөрөнгийн Бирж, Санхүүгийн Зохицуулах Хороонд бүртгүүлэхтэй холбогдсон үйл ажиллагааг хамтран зохион байгуулах, хэрэгжүүлэх.

- Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд шаардлагатай хөрөнгө оруулалтыг олон нийтээс татан төвлөрүүлэх.

- Үнэт цаас гаргагч нь өөрийн үйл ажиллагаа, үйлчилгээ, санхүүгийн нөхцөл байдал, бусадтай байгуулсан гэрээ хэлцэл болон бусад бодит байдлын талаар Андеррайтерт үнэн зөв мэдээлэх үүрэг хүлээнэ. Үүнд:
  - Компанийн тухай хуулийн 87.1-т заасан их хэмжээний хэлцэлд тооцогдох бусадтай байгуулсан гэрээ хэлцлүүд,
  - Санхүүгийн нөхцөл байдал, авлага, өр төлбөрийн байдал, нарийвчилсан задаргаа,
  - Бизнес төлөвлөгөө, үр ашгийн тооцоо,
  - Үйл ажиллагаа явуулах зах зээлийн мэдээлэл, тоо баримт,
  - Үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтнуудын мэдээлэл,
  - Толгой компани болон зэргэлдээ компаниудын талаарх мэдээлэл,
  - Монголын Хөрөнгийн Бирж, Санхүүгийн Зохицуулах Хороонд бүртгүүлэхэд зайлшгүй шаардагдах санхүү болон үйл ажиллагаа хэвийн явуулахтай холбогдох бусад бүх мэдээлэл,

- Үнэт цаас гаргагч нь бэлтгэн өгч буй мэдээ, мэдээллийн үнэн зөвийг хариуцах ба үүнээс үүдэн гарсан хохирлыг Үнэт цаас гаргагч өөрөө хариуцах үүрэгтэй.

- Андеррайтерын ажлын хөлсийг Гэрээнд заасан хугацаанд шилжүүлэх үүрэгтэй.

- Үнэт цаас гаргагч нь Гэрээ байгуулсанаас хойш ажлын 10 хоногийн дотор Гэрээний хүрээнд компанийг төлөөлөн оролцох эрх бүхий ажилтнуудыг томилж, Андеррайтерт мэдэгдэх бөгөөд /мэдэгдэлд овог, нэр, албан тушаал, и-мэйл хаяг, утасны дугаар болон бусад мэдээллийг тусгана/. Андеррайтер нь Гэрээ хүчин төгөлдөр үйлчлэх хугацаанд мэдэгдэлд дурдагдсан ажилтнуудтай харилцаж хамтран ажиллана.

- Үнэт цаас гаргахтай холбоотой хууль, журамд заасан шаардлагыг хангах, арга хэмжээг авч хэрэгжүүлэх үүрэгтэй.

- Андеррайтераас үл хамаарах шалтгаанаар үйл ажиллагаа төлөвлөсөн хугацаанаас хойшилсон нөхцөлд үнэт цаас гаргагч нэмэлт төлбөр төлөх үүрэг хүлээнэ.

- Андеррайтерын үйлчилгээтэй холбоотой үйл ажиллагааны явцын талаар бүрэн мэдээлэл авах эрхтэй.

- Андеррайтерын үйлчилгээний явц, үр дүнд өөрийн зүгээс тайлбар, санал өгөх эрхтэй.

- Андеррайтераас Гэрээний дагуу хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах эрхтэй.

*"БиДиСЕК ҮЦК" ХК-ийн улсын бүртгэлийн гэрчилгээ, тусгай зөвшөөрөл, үнэт цаас гаргагчтай байгуулсан гэрээний хуулбарыг хавсралтаас үзнэ үү.*

0000150



СЗХ 2018.08.29 БҮРТГЭВ № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE БҮРТГЭВ 01

*Ард Даатгал ХХК*

Хаяг: Ард Санхүүгийн Нэгдлийн байр,
2-р давхар, Ерөнхий сайд Амарын гудамж,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, Монгол улс

Утас: (976) 7720 0089

И-мэйл: info@arddaatgal.mn

Вэб сайт: www.arddaatgal.mn

w3w: цэнэг.эрдэмтэй.өнгөлөх

*"Биржид илгээж байгаа танилцуулга нь Хороонд хүргүүлж байгаа танилцуулгатай адил, ямар нэг зөрүүтэй мэдээлэл тусгагдаагүй болно"*

2018-05-11

ARD INSURANCE COMPANY АРД ДААТГАЛ ХХК УЛААНБААТАР ХОТ

УЛААНБААТАР ХОТ МХБ-ийн гишүүн Андеррайтер Брокер дилерийн "БИДИСЕК" ҮЦК ХК